



Хүний Эрхийн Үндэсний Комисс



НҮБХХ

**Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас
Хүний эрхэд үзүүлэх нөлөө, 2012
Судалгааны тайлан**



**Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны
хүрээлэн**

АГУУЛГА

Товчилсон үгсийн жагсаалт

Хүснэгтийн жагсаалт

Зургийн жагсаалт

БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

1.1 Судалгааны үндэслэл

1.2 Зорилго, зорилт

1.3 Арга зүй

БҮЛЭГ 2. СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ ДҮН ШИНЖИЛГЭЭ

БҮЛЭГ 3. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТОЙМ ДҮН ШИНЖИЛГЭЭ

БҮЛЭГ 4. ГУРВАНТЭС, ХАНБОГД, ЦОГТЦЭЦИЙ СУМЫН МАЛЧДАД УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ

4.1 Малчин өрхийн нийгэм-эдийн засгийн байдал

4.2 Уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэхэд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө

4.3 Малчин өрхийн газар эзэмшилт, ашиглалт, өмчлөлтөд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө

4.4 Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн төлбөрийн зохицуулалт

4.5 Нөлөөллийн бүсэд оршин суугаа малчдын эрүүл мэндэд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө

БҮЛЭГ 5. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ

5.1 Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлж буй нөлөө

5.2 Уул уурхайн үйл ажиллагааны усны нөөцөд үзүүлж буй нөлөө

5.3 Уул уурхайн компанийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа ба орон нутгийн иргэдийн сэтгэл ханамж

5.4 Канад, Австрали улсад уугуул иргэд, уул уурхайн компанийн зөвшилцлөөр нөхөн төлбөрийг шийдвэрлэсэн сайн туршлага

БҮЛЭГ 6. УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

6.1 Уул уурхайн үйлдвэрлэлийн орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлж буй эерэг, сөрөг нөлөө болон уул уурхайн компаниудын хэрэгжүүлж буй нийгмийн хөтөлбөр

6.2 Уул уурхайн үйл ажиллагааны явцад төр, орон нутгийн иргэд, орон нутгийн захиргааны байгууллага, уул уурхайн компанийн оролцоо

БҮЛЭГ 7 . ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

7.1 Дүгнэлт

7.2 Зөвлөмж

Ном зүй

Судалгааны тайлан бичсэн

Судалгааны багийн ахлагч

Ц.Одгэрэл, Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Социологийн шинжлэх ухааны магистр

Судалгааны багийн гишүүн

Т.Бүрэнжаргал, Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Социологийн шинжлэх ухааны доктор, профессор

С.Түмэндэлгэр, Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, Социологийн шинжлэх ухааны доктор

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Товчилсон үгсийн жагсаалт

АМГ	Ашигт Малтмалын Газар
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
БОНБНУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нийгмийн үнэлгээ
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДОХ	Дархлал олдмол хомсдлын хам шинж
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАА	Мал аж ахуй
МАК	Монгол Алт Корпораци
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МУЗН	Монголын улаан загалмайн нийгэмлэг
МХГ	Мэргэжлийн Хяналтын Газар
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
НХХЯ	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам
ОТ ХХК	Оюу толгой хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОНХХ	Олон нийттэй харилцах хэлтэс
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХХИ	Хүний хөгжлийн индекс
ХАА	Хөдөө аж ахуй
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 4.1 Өрхийн гишүүдийн эдийн засгийн идэвхийн байдал, сумдаар
- Хүснэгт 4.2 Уул уурхайн компанид ажил эрхэлж малчин өрхийн гишүүдийн тоо, сумдаар
- Хүснэгт 4.3 Өрхийн малын тоо, сумаар
- Хүснэгт 4.4 Өрхийн мал аж ахуйн бус бусад орлогын эх үүсвэр
- Хүснэгт 4.5 Уул уурхайн үйл ажиллагааны улмаас Таны эрх хэр зэрэг зөрчигдөж байна вэ? (нөлөөллийн бүсэд нутагладаг малчдын өгсөн хариулт)
- Хүснэгт 4.6 Уул уурхайн үйл ажиллагааны улмаас Үндсэн хуулиар олгогдсон эрхүүд зөрчигдөж байна гэж хариулсан малчдын эзлэх хувь
- Хүснэгт 4.7 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсэд орсон малчдын тоо
- Хүснэгт 4.8 Өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн газраа эзэмшсэн гэж хариулсан малчдын эзлэх хувийн жин, сумдаар
- Хүснэгт 4.9 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан байдал, сумдаар
- Хүснэгт 4.10 Нөлөөллийн бүсийн сумдын орон нутгийн захиргааны байгууллагад нүүлгэн шилжүүлэлтийн бодлого байдаг эсэх
- Хүснэгт 4.11 Нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрт хамрагдсан малчдын нөхөн төлбөр авсан талаарх мэдээлэл
- Хүснэгт 5.1 Нөлөөллийн бүсийн байгаль орчинд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө, Гурвантэс сумын малчдын өгсөн үнэлгээ
- Хүснэгт 5.2 Нөлөөллийн бүсийн байгаль орчинд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө, Ханбогд сумын малчдын өгсөн үнэлгээ
- Хүснэгт 5.3 Нөлөөллийн бүсийн байгаль орчинд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө, Цогтцэций сумын малчдын өгсөн үнэлгээ
- Хүснэгт 5.4 Нөлөөллийн бүсийн байгалийн нөөц, мал, ан амьтанд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө, Гурвантэс сумын малчдын өгсөн үнэлгээ
- Хүснэгт 5.5 Нөлөөллийн бүсийн байгалийн нөөц, мал, ан амьтанд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө, Ханбогд сумын малчдын өгсөн үнэлгээ
- Хүснэгт 5.6 Нөлөөллийн бүсийн байгалийн нөөц, мал, ан амьтанд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө, Цогтцэций сумын малчдын өгсөн үнэлгээ
- Хүснэгт 5.7 Уул уурхайн компаниуд байгаль орчинд нөхөн сэргээлт хийдэг эсэх, сумдаар
- Хүснэгт 6.1 Уул уурхайн үйлдвэрлэл эрчимжсэний дараагаар эрхэлж буй ажлаа өөрчилсөн байдал, хувиар
- Хүснэгт 6.2 Малын бэлчээр, өвөлжөө, хаваржааг уурхайн эдэлбэр газрын зориулалтын хүчээр ухсан, булаасан тохиолдол гарсан гэж хариулсан малчдын тоо

Зургийн жагсаалт

- Зураг 4.1 Өрхийн орлогын хүрэлцээг үнэлсэн үнэлгээ, сумдаар
- Зураг 4.2 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр Таны эрх хэр зэрэг зөрчигдөж байна вэ?
- Зураг 4.3 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхүүд зөрчигдөж байна гэж хариулсан малчдын эзлэх хувь
- Зураг 4.4. Уул уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө жилд нүүдэллэдэг нүүдлийн тоо
- Зураг 4.5. Уул уурхайн үйл ажиллагааны дараа жилд нүүдэллэдэг нүүдлийн тоо
- Зураг 4.6 Уул уурхайн үйл ажиллагааны бэлчээрийн МАА-д үзүүлж буй нөлөө
- Зураг 4.7 Өвөлжөөний газраа эзэмшсэн малчны тоо болон үүнээс лицензийн талбайд орсон гэж хариулсан малчны тоо, сумдаар
- Зураг 4.8 Нүүлгэн шилжүүлэх асуудлаар компаний удирдлага, ажилтнууд тохиолцдог эсэх, малчдын хариултаар
- Зураг 4.9 Авч буй нөхөн төлбөр өмнөх амьжиргаатай харьцуулахад хангалттай эсэх
- Зураг 4.10 Уул уурхайн тээвэрлэлтийн хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөг үнэлсэн байдал, сумдаар
- Зураг 4.11 Өмнөговь аймгийн Цогтцэций сумын хүн амын өвчлөлийн үзүүлэлтүүд
- Зураг 4.12 Өмнөговь аймгийн Цогтцэций сумын хүн амын өвчлөлийн эхний нэгдүгээр байрны шалтгаант өвчлөл
- Зураг 5.1 Нөлөөллийн бүсийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, сумдаар
- Зураг 5.2 Нөлөөллийн бүсийн байгаль орчинд уул уурхайн үйл ажиллагааны нөлөөг үнэлсэн байдал
- Зураг 5.3 Нөлөөллийн бүсийн байгалийн нөөц, мал, ан амьтанд уул уурхайн үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ, сумдаар
- Зураг 5.4 Уул уурхайн компаниуд байгаль орчинд нөхөн сэргээлт хийдэг эсэх
- Зураг 6.1 Уул уурхайн үйл ажиллагааны орон нутгийн нийгэм, байгаль орчинд үзүүлж буй нөлөө \сумын төвийн иргэдийн хариултаар\
- Зураг 6.2 Малчдын уул уурхайн компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авдаг эх үүсвэр
- Зураг 6.3 Иргэдийн мэдээлэлтэй байдал
- Зураг 6.4 Өөрийн багийн нутаг дэвсгэрийг лицензийн талбайд орсон талаар мэднэ гэж хариулсан малчдын эзлэх хувийн жин (n=50)
- Зураг 6.5 Хайгуулын болон лиценз олгох шийдвэрийг гаргахдаа орон нутгийн иргэд, малчид малчидтай зөвлөлддөг эсэх
- Зураг 6.6 Хайгуулын болон лиценз олгох шийдвэрийг гаргахдаа эрх ашиг нь хөндөгдсөн малчидтай зөвлөлддөг эсэх, сумдаар (n=50)
- Зураг 6.7 Орон нутгийн удирдлагын уул уурхайтай чиглэлээр явуулж буй арга хэмжээний талаарх сэтгэл ханамжийн түвшин
- Зураг 6.8 Уул уурхайтай холбоотой асуудлаарх орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамж
- Зураг 6.9 Уул уурхайн компани малчидтай хамтарч ажилладаг хэлбэр

Матриц

- Матриц 3.1 Хүчин төгөлдөр үйлчилж байгаа зарим хуулинд уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэм, хүнд үзүүлэх нөлөөллийн зохицуулалт, хэрэгжилт
- Матриц 3.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулинд орсон өөрчлөлт
- Матриц 4.1 Уул уурхайн үйл ажиллагааны бэлчээрийн МАА эрхлэхэд үзүүлж нөлөө
- Матриц 4.2 ОТ ХХК-ийн барилгын нөлөөлөлд өртсөн малчин гэр бүлийн амьжиргааг дэмжих арга хэмжээ
- Матриц 4.3 Уул уурхайн нөлөөллийн бүс дэх малчин өрх болон малын эрүүл мэндийн байдал
- Матриц 5.1 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсийн байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө, сумдаар
- Матриц 6.1 Уул уурхайн нөлөөллийн бүс нутагт уул уурхайн компаниудын хэрэгжүүлж буй нийгмийн асуудлыг шийдвэрлэж буй байдал
- Матриц 6.2 Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын орон нутагт хийсэн хөрөнгө оруулалт
- Матриц 6.3 Уул уурхай үйлдвэрлэлийн орон нутаг, нутгийн иргэдэд үзүүлсэн нөлөө

БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

1.1 Судалгааны үндэслэл

Монгол Улс нь байгалийн арвин их нөөцтэй улс бөгөөд 1994 онд анх Ашигт малтмалын тухай хууль, улмаар 1997 онд Ашигт малтмалын тухай хоёр дахь хуулийг баталж, 2006 онд Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн найруулж баталснаас хойш Газрын хэвлийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай, Усны тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх олборлохыг хориглох тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль хамгаалах багц хуулиуд, Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл хохирол багатай явуулах хөтөлбөр, Нөхөн сэргээлтийн стандарт, Агаарын чанарын стандарт зэрэг олон арван хууль эрх зүйн баримт бичгийг гаргажээ. Өөрөөр хэлбэл, байгаль орчны нөөц баялгийг хамгаалах нөхөн сэргээх, зохистой ашиглах асуудлыг зохицуулах, хэрэгжүүлэх үндэсний 50 гаруй хууль, 26 хөтөлбөр, 130 гаруй дүрэм журам, Засгийн газар, яам агентлаг хоорондын 90 гаруй гэрээ санамж бичиг байна. (www.legalinfo.mn)

Сүүлийн 5 жилд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 10.2 хувийн дундаж өсөлттэй явж ирсэн бөгөөд Монголын эдийн засгийн зонхилох салбар болсон байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд уг салбарын үйлдвэрлэл нь ДНБ-ий 30 орчим хувийг (2006 онд 30%, 2007 онд 29.5%, 2008 онд 28.2%) (Монгол Улсын статистикийн эмхтгэл 2000-2008 он, УСХ) эзэлж, эрдэс бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 60.3 хувийг, үүнд зэсийн баяжмал дангаараа нийт экспортын 33 хувийг эзэлж байна. Түүнчлэн, Монгол Улсын ДНБ 9.1 хувь, нэг хүнд ногдох ДНБ 7.7 хувийн дундаж өсөлттэй байгаа нь уул уурхайн салбарын хөгжил тус орны нийт үйлдвэрлэл, орлогын өсөлтөд ихээхэн хувь нэмэр оруулж буйг харуулж байна (Б. Алтанцэцэг. Уул уурхайн салбар ба тогтвортой хүний хөгжил.2011 он).

2011 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар нийтдээ 23.0 сая га талбайг хамарсан ашигт малтмалын 3765 тусгай зөвшөөрөл, үүнээс 682,9 мянган га талбай бүхий 1196 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 22.3 сая га талбай бүхий 2569 хайгуулын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 0.4 хувийг ашиглалтын, 14.2 хувийг хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай эзэлж, нийт нутгийн 14.6 хувьд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Ашигт малтмал ашиглах дотоодын 461 аж ахуй нэгж 709 ашиглалтын лиценз, гадаадын хөрөнгө оруулалттай 77 аж ахуй нэгж ашиглалтын 161 лиценз, хамтарсан хөрөнгө оруулалттай 59 компани 124 лиценз тус тус эзэмшиж, улсын хэмжээгээр нийт 205700,56 га талбай ашиглалтын лицензтэй байна.

Ийнхүү уул уурхайн салбар хурдацтай хөгжихийн хэрээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд ихээхэн нөлөөлж улмаар иргэд, олон нийт, бодлого боловсруулагчдын анхаарлыг татаж байна. Засгийн газар уул уурхайн салбарт түшиглэсэн эдийн засгийн хөгжлийн бодлого, гадаадын хөрөнгө оруулалтыг татах

зорилгодоо хөтлөгдөн хүний эрх, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн асуудлуудыг орхигдуулж байна. Мөн уул уурхайн нөлөөллийн бүсүүдэд хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах, амьдрах газраа чөлөөтэй сонгох, амьжиргааны эх үүсвэрээ хамгаалуулах, мал маллах, аж ахуй эрхлэх, өмчлөх, уламжлалт соёл, ёс заншлаа хадгалах, өвлүүлэх, хүний орон гэр, өмч хөрөнгө халдашгүй байх, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, цэвэр усаар хангагдах, хөгжих эрхүүд ноцтой зөрчигдсөөр байна. Уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа иргэд малчид газар нутаг, МАА-гаа аргагүйн эрхэнд орхих эсхүл хүчинд автан нүүх, бэлчээр шахагдах зэргээр халдашгүй байх эрх нь зөрчигдөж, эрхээ хамгаалах зорилгоор мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох эрх нь хязгаарлагдмал байна.

“Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлэх нөлөө” сэдэвт судалгааны ажил нь Өмнөговь аймгийн Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сумдыг хамруулан уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн иргэд, малчид болон бусад оролцогч талуудыг хамруулан мэдээлэл цуглуулах, уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүний эрх зөрчигдсэн тохиолдлыг гүнзгийрүүлэн судлах, судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, судалгааны тайлан бичих, судалгааны үр дүнд тулгуурлан дүгнэлт зөвлөмж дэвшүүлэхэд чиглэсэн.

1.2 Судалгааны зорилго, зорилт

Уул уурхайн үйл ажиллагаанаас (хайгуул, олборлолт, тээвэрлэлт г.м) тухайн нөлөөллийн бүсийн байгаль орчин-экоцистем, орон нутгийн иргэд, малчдын амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, эрүүл аюулгүй амьдрах, газар өмчлөх, мэдээлэл авах, шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхийн хэрэгжилт болон эдгээр эрхийн хэрэгжилтэд үзүүлж буй нөлөөллийг судлан, санал, зөвлөмж боловсруулахад судалгааны зорилго оршлоо.

Судалгааны зорилгыг хангах үүднээс дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

Зорилт 1. Уул уурхайн үйлдвэрлэлээс бэлчээрийн мал аж ахуй, нүүдлийн соёл уламжлалд нөлөөлж буй нөлөөллийг судлах

- Нөлөөллийн бүсийн малчдын амьдралын хэв маяг, эрхэлж буй мал аж ахуй, мал аж ахуйн хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшинд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох
- Нөлөөллийн бүсийн малчин өрх, иргэдийн газар эзэмших, өмчлөх эрх, малчдын 4 улирлын онцлогтойгоор мал аж ахуй эрхлэх болон өвөлжөө хаваржааны өмчлөлд уул уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалж буй нөлөөллүүдийг гүнзгийрүүлэн судлах
- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас нөлөөллийн бүсийн экоцистем, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг тухайн орон нутгийн малчид, иргэдийн санаа бодолд тулгуурлан шинжлэх

Зорилт 2. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүс дэх нүүлгэн шилжүүлэлтийн бодлого, хэрэгжилт, нөхөн төлбөртэй холбогдуулан хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр нөлөө болон нүүлгэн шилжүүлэлтийн бодлого, хөтөлбөрийн талаарх малчид, иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг судлах

- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас орон нутгийн иргэд, малчдыг өөр газар нүүлгэн шилжүүлэх, мөн малчдад нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн төлбөр олгох асуудлыг зохицуулж буй өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх
- Уурхайн ашиглалтын болон хайгуулын лицензийн талбайд орсон, нутаг орноо орхин нүүсэн, амьжиргааны эх үүсвэрээ алдсан малчид болон тэдэнд тохиолдож буй асуудлуудыг судлах
- Эрх нь зөрчигдсөн тохиолдолд шүүхээр эрхээ хамгаалуулж буй байдал, нөхөн төлбөрийн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийх,

Зорилт 3. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсэд иргэд, малчид болон бусад оролцогч талуудыг уул уурхайн ашиглалтын асуудлаар шийдвэр гаргах түвшин дэх оролцуулж буй байдал, мэдээллийн хүртээмжийг судлах


- Уул уурхайн асуудлаар нөлөөллийн бүсийн иргэд, малчид, оролцогч талуудын мэдээллийн хүртээмжийн байдал, чанар, үр нөлөөнд дүн шинжилгээ хийх
- Уурхайн үйл ажиллагааны улмаас эрх ашиг, эрх нь хөндөгдөж буй нөлөөллийн бүсийн иргэд, малчдын шийдвэр гаргах үйл явц дахь оролцоог хангаж буй байдал, оролцоог хангаж буй хэлбэрүүдийг шинжлэх
- Уул уурхайн асуудлаар шийдвэр гаргахад орон нутаг, нөлөөллийн бүсийн иргэд, малчид, оролцогч талуудын хамтын ажиллагаа, төр, хууль хяналтын болон иргэний нийгмийн байгууллагуудад хандаж, асуудал дэвшүүлсэн, шийдвэрлүүлсэн асуудлуудыг судлах, дүн шинжилгээ хийх

Зорилт 4. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүс дэх иргэд, малчид, оролцогч талуудын амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, эрүүл аюулгүй орчинд аж төрөх, газар эзэмших, өмчлөх, оролцох эрхүүдийн хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээл, хүний эрхийн зөрчлийг арилгах, цаашид уул уурхайн салбарт хүний эрхийг хангаж хамгаалахад чиглэсэн санал зөвлөмжийг судалгааны үр дүнд тулгуурлан боловсруулах

1.3 Судалгааны арга зүй

“Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлэх нөлөө” судалгааны тайланд уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй явагдаж байгаа Өмнөговь аймгийн Гурвантэс, Цогтцэций, Ханбогд зэрэг гурван сумдыг хамруулан уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн иргэд, малчид болон оролцогч талуудыг \орон нутгийн засаг захиргаа, иргэд, иргэний нийгмийн байгууллага, уул уурхайн компани\ хамруулан мэдээлэл цуглуулахдаа асуулга, ярилцлага, тохиолдол шинжлэл, баримт бичгийн судалгааны аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулж, нэгтгэн дүгнэлээ.

Судалгаанд асуулга, бүлгийн ярилцлагын аргыг хослуулан хэрэглэсэн ба сэдвийн судлагдсан байдлын тойм шинжилгээ, хууль тогтоомжийн дүн шинжилгээ хийхдээ бичиг баримтын судалгааны аргыг ашиглав.



Баримт бичиг, хоёрдогч мэдээллийн судалгаа

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас Хүний эрхэд үзүүлэх нөлөө судалгааны хүрээнд сэдвийн судлагдсан байдлын тойм шинжилгээ, холбогдох хуулийн дүн шинжилгээг хоёрдогч мэдээллийн эх үүсвэрт тулгуурлан хийв. Судалгааны зорилго, ач холбогдлын хүрээнд Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумын түвшний хоёрдогч мэдээллийг цуглуулан авсан болно.

Асуулгын арга

Нөлөөлөлд өртсөн малчид, иргэдээс урьдчилсан боловсруулсан асуулгын хуудсаар нүүр тулсан (face to face interview) хэлбэрээр мэдээлэл авсан. Багийн гишүүд болон орон нутагт ажилласан судлаачид судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг талбарт зохион байгуулах, ярилцлагыг хэрхэн явуулах, асуулгын хуудсыг хэрхэн нөхөх сургалтад хамрагдаж, дадлага эзэмшсэн.

Бүлгийн ярилцлага

Иргэд, нөлөөлөлд өртсөн малчдыг хамруулан урьдчилан бэлтгэсэн асуултын чиглэлүүдээр хэлэлцүүлэг хийлээ. Бүлгийн ярилцлагаар уул уурхайн үйл

ажиллагаанаас бэлчээрийн МАА, байгаль орчин, хүний үндсэн эрхүүдэд үзүүлж буй нөлөөллийг судалсан.

Ганцаарчилсан ярилцлага

Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумын нутаг дэвсгэр дэх уул уурхайн компани, орон нутгийн засаг захиргааны төлөөлөл, иргэд болон нөлөөлөлд өртсөн малчдыг хамруулан урьдчилан бэлтгэсэн ярилцлагын хуудсаар мэдээлэл цуглуулав.

Судалгааны хамрах хүрээ

Судалгааны талбарыг сонгосон үндэслэл нь уул уурхайн үйлдвэрлэлийн олборлолт, ашиглалт, тээвэрлэлт өргөн хүрээтэй явагдаж байгаа стратегийн ач холбогдолтой уул уурхайн үйлдвэрлэл явагдаж буй Өмнөговь аймгийн Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сумыг хамруулав.

Хүснэгт 1.1 Хамрах хүрээ

Түүвэр хүн ам	Гурвантэс сум	Ханбогд сум	Цогтцэций сум	Бүгд
Асуулга (n=228)				
Нөлөөлөлд өртсөн малчид	16	18	16	50
Сумын төвийн иргэд	60	60	60	178
Ганцаарчилсан ярилцлага (n=42)				
Нөлөөлөлд өртсөн малчид	10	10	10	30
Бүлгийн ярилцлага				
Нөлөөлөлд өртсөн малчид	6	5	6	12
Бүлгийн ярилцлага (n=30)				
Иргэдийн төлөөлөл	10	10	10	30
Мэргэжилтнүүдтэй хийх ганцаарчилсан ярилцлага (n=33)				
Сумын Засаг даргын орлогч		1	1	2
Сумын тамгын газрын дарга	1		1	2
Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, гишүүд	1	1	1	3
Байгаль орчны улсын байцаагч, байгаль орчны байцаагч		1	2	3
Газрын даамал	1			1
Багийн Засаг дарга	3	3	3	9
Сумын эмч	1		1	2
Бусад \ХАА хариуцсан, статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн\	2	2	2	6
Оюу толгой төслийн ОНХХ-ийн салбарын менежер, ажилтан		3		3
Энержи ресурс компанийн Ухаа худаг төслийн захирал, ОНХХ-ийн ажилтан			3	3
МАК компанийн уурхайн дарга, байгаль орчин, хөдөлмөр хамгаалал хариуцсан мэргэжилтэн, эмч	4			4
Нийт	115	114	116	345

Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг Гурвантэс, Ханбогд, Цогтцэций суманд зохион байгуулж нийт 345 зорилтот хүн амыг хамруулан тоон болон чанарын судалгааны мэдээллийг цуглууллаа.

Мэдээлэл боловсруулах ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Боловсруулалтын эхний шатанд нээлттэй болон хагас нээлттэй асуултуудыг багцлан хаалттай хэлбэрийн хувьсагчуудыг үүсгэх,
- SPSS программд асуулгын мэдээллийг бүтцээр бааз үүсгэн бүх хувьсагчуудыг оруулах,
- Мэдээллийн баазад нийт асуулгын хуудсуудыг шивсэний дараа санамсаргүй болон логикийн алдаа зөрчлийг бүх асуулгын хуудастай тулган засварласан
- SPSS-т оруулж дууссаны дараа мэдээллийн баазад үр дүнгийн хүснэгтэн төлөвлөгөөг хийж, дан тооллогын болон харьцуулсан хүснэгтүүдийг боловсруулах,
- SPSS-т оруулсан тоон болон интервал түвшний хувьсагчийг дахин кодлож судалгааны мэдээллийг шинжлэхэд шаардлагатай шинэ хувьсагчуудыг үүсгэх,
- Чанарын судалгааны мэдээллүүдийг шивэх, категорчилсон агуулгын шинжилгээ, хэв маягчлал, ангилал хийх, ишлэл, кейс мэдээллүүдийг боловсруулах,

БҮЛЭГ 2. СЭДВИЙН СУДАЛГАДСАН БАЙДЛЫН ТОЙМ ДҮН ШИНЖИЛГЭЭ

Сүүлийн жилүүдэд уул уурхайн үйлдвэрлэл эрчимжиж байгаатай зэрэгцэн түүнд холбогдох судалгаа нэлээд хийгджээ. Судалгааны баг хүний эрхэд холбогдох асуудлыг илүү хөндсөн судалгаануудад анхаарлаа хандуулан судлав. Зорилго, хөндсөн асуудлаас нь хамааруулан судалгаануудыг дараах 4 бүлэгт ангилан үзэж болох юм.

1. Уул уурхай дахь хүний эрхийн асуудлуудад шууд анхаарлаа хандуулсан судалгаа.

Ийм зорилго бүхий судалгаа харьцангуй цөөхөн хийгджээ. Монголын ТББ-ын форумас бэлтгэсэн “Байгаль орчин-Уул уурхай-Хүний эрхийн төлөв байдал судалгааны тайлан”-г авч үзье.

1. Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт бэлтгэх Монголын төрийн бус байгууллагуудын форумас Байгаль орчин-Уул уурхай-Хүний эрхийн төлөв байдал судалгааны тайланг “Оюу толгой хяналт”, Монголын байгаль орчны иргэний зөвлөл, “Хил хязгааргүй алхам” ТББ бэлтгэн боловсруулсан байна. Уг судалгааг уул уурхайн үйл ажиллагаа эрчимжсэн Өмнөговь, Дархан-Уул аймгийн сумдад явуулсан аж. Судалгааны мэдээлэл цуглуулахдаа фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага, байгаль орчин, хүний эрхийн зөрчилд хамаарах тохиолдол шинжлэх аргуудыг ашиглажээ. Иргэдтэй ганцаарчлан ярилцсаны зэрэгцээ бүлгийн ярилцлагыг тэдний дунд зохион байгуулсан байна. Зөвхөн Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Дархан-Уул аймгийн Хонгор сумдад орон нутгийн удирдлага, компанийн төлөөлөлтэй ганцаарчлан ярилцаж мэдээллээ цуглуулсан байна. Мөн уг асуудалд холбогдох хууль эрх зүйн актуудад дүн

шинжилгээ хийн, судалгаа хийгдсэн үеийн эрх зүйн орчинд үнэлэлт дүгнэлт өгөн, хуулиар зохицуулагдаагүй байгаа асуудлуудыг тодотгожээ.

Судлаачид уул уурхайн үйл ажиллагааны улмаас Монгол улсад эрүүл аюулгүй орчинд амьдрах, амьжиргааны эх үүсвэрээ сонгох ба хамгаалуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрх, өмчлөх, аж ахуй эрхлэх, уламжлалт соёл, ёс заншлаа хадгалах, өвлүүлэх, хүний орон гэр халдашгүй байх, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, усаар хангагдах, төр барих болон хүний хөгжих эрх зөрчигдөх болсон хэмээн дүгнэжээ. Мөн иргэд газар нутгаасаа аргагүйн эрхэнд шахагдан нүүх, хүчинд автан нүүх, хөөгдөх зайлах зэргээр халдашгүй байх эрх зөрчигдөх, эрхээ хамгаалах зорилгоор мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох эрх нь хаалттай, шударга шүүхээр эрхээ хамгаалуулах эрх нь хангагдахгүй байна гэж үзжээ.

Гар аргаар алт олборлогчдын хувьд амьд явах эрх, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр, боолчлол, садар самуун, хүчирхийллээс ангид байх, газар доор хүүхэд, эмэгтэйчүүд ажиллаж эхний ээлжинд эрсдэх, хөдөлмөрийн аюулгүй нөхцлөөр хангагдах, хөдөлмөрийн хөлсөө шударгаар үнэлүүлэх, хуулийн өмнө эрх тэгш байх, сонгох ба сонгогдох эрх, эрх зүйн чадамжтай байх эрхүүд нь эрх зүйн орчин бүрдээгүйгээс ноцтой зөрчигдөж байна.

Нэгд, Эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, хоёрт, усны эрх, гуравт, газар эзэмших эрх, дөрөвт, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрх, тавд, хүн амын түүх соёл, байгалийн өвийг хамгаалуулах, залгамжлуулах эрх, зургаад, эрүүл мэнд, халдашгүй байдлаа хамгаалуулах эрх, долоод, байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох эрхүүд зөрчигдөж байгааг баримт нотолгоо болон холбогдох олон улсын, үндэсний хууль тогтоомжийн заалт, бодлогын баримт бичгүүдтэй холбон тайлбарлажээ. Түүнчлэн дээрх эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сэргээх, зөрчлийг шийдвэрлэхэд холбогдох зөвлөмжүүдийг дэвшүүлэн тавьсан нь ихээхэн ач холбогдолтой байна.

Хоёрт, ХЭҮК. Уул уурхайн зарим салбарт хөдөлмөрийн хүрээний суурь зарчмууд болон Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжинд заасан эрхийн хэрэгжилтэд хийсэн шалгалт судалгааны тайлан (2003).

Уг шалгалт судалгааг уул уурхайн үйлдвэр, компанид ажиллагсад болон гар аргаар алт олборлогчдын хөдөлмөрийн тухайн хууль тогтоомжинд заасан эрх, хөдөлмөрийн суурь зарчмуудын хэрэгжилтийг газар дээр нь шалган үнэлж, зөрчигдсөн эрхийг сэргээн засах, ажиллагсдын эрхийг бүхий л түвшинд хамгаалах зорилготойгоор явуулжээ. Мэдээллийг судлахдаа асуулга, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, ажиглалт зэрэг аргуудыг ашигласан байна. ХЭҮК нь Мэргэжлийн хяналтын газар, Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хматран ОУХБ-ын дэмжлэгтэйгээр энэхүү судалгааг хийжээ. Уг судалгаанд Баянхонгор, төв аймгийн Заамар, Өвөрхангай аймгийн Уянга суманд байрлах алтны нийт 20 уурхай, Налайхад байрлах нүүрсний нийт 8 уурхай, Дорноговь, Хэнтийн Бор-Өндөрийн жоншны уурхай зэрэг нийт 30-аад уурхайн 3840 ажилтан, гар аргаар алт олборлож буй 1500 хүнтэй уулзаж ярилцан, 270 хүнээс асуулгын аргаар мэдээлэл цуглуулсан байна.

Судалгааны үр дүнд судалгаа явагдсан уул уурхайн компаниудын олонхи нь ажилтнуудтайгаа хамтын гэрээ байгуулахгүйгээр ажиллуулж байгааг илрүүлсэн ба үүнтэй холбоотойгоор нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлүүлж чадахгүй байх, илүү цагаар ажиллуулсын нэмэгдэл хөлс олгохгүй байх, амрах, чөлөө авах зэрэг хөдөлмөрийн харилцааны эрхүүдээ эдэлж чадахгүй нөхцөлд хүрч байгааг тогтоосон байна. Мөн ажил олгогч болон ажилтнуудын хөдөлмөрийн харилцаа болон бусад холбогдох эрхийн актуудын талаарх мэдлэг хомс байгааг анзаарсан байна.

Хөдөлмөрийн зохион байгуулалт оновчтой бус, хөдөлмөрийн норм, үнэлгээ тогтоогүйгээс ажиллагчид сул зогсох, улмаар цалин хөлсөө авч чадахгүйд хүрэх зэрэг асуудлууд гардаг байна.

Хөдөлмөрийн үйл ажиллагааны орчин, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл хангалтгүй байгаагаас ажилчдын дунд үйлдвэрлэлийн осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн тоо буурахгүй байна гэжээ.

Зарим аж ахуйн нэгжид нас, хүйс, цалин хөлсөөр ялгаварлах байдал байгааг илрүүлсэн тогтоосон байна.

Албан ёсны уурхайд хүүхэд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхтэй холбогдсон эрх зохих ёсоор хэрэгжиж байгаа бол гар аргаар алт олборлогчдын дунд хүүхэд тэвчишгүй төрлийн хөдөлмөр эрхэлж байгаад анхаарлаа хандуулжээ.

2. Уул уурхайн салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгаа.

Уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний ихэнхийг үйлдвэрлэж байгаагийн зэрэгцээ уг салбар дахь албан ба албан бус хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин өсөж байна. Иймд ажиллагчдын хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн норм, нийгмийн хамгаалал, цалин хөлсний асуудлыг судалсан судалгаанууд хийгджээ.

3. “Алтны уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн байдал” судалгааг 2002 онд МУИС-ийн Хүн амын сургалт, судалгааны төв хийжээ. Уг судалгааг Сэлэнгэ аймгийн Баянгол (Баруунхараа), Ерөө, Төв аймгийн Сүмбэр, Жаргалант, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын зорилттойгоор сонгосон 122 өрхийн 6-18 насны 122 хүүхдүүдийг хамруулан хийсэн байна. Тэдгээр хүүхдүүд нь бүгд шороон болон үндсэн ордоос алт олборлох ажил хийдэг хүүхдүүд аж.

Энэ судалгаагаар хүүхэд хэт бага наснаасаа хүнд хүчир ажил хийж, улмаар эрүүл мэндээрээ хохирч, өсөлт хөгжил нь зогсож, эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээний гадна орхигдох эрсдэлтэй нөхцөлд байгааг илрүүлжээ. Тодруулбал судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 50 орчим хувь нь алт олборлож байх үедээ ямар нэгэн өвчин туссан, 22.5 хувь нь осолд орж байсан, давхардсан тоогоор 92.6 хувь нь хөл, гар, нуруугаа, 14.8 хувь нь толгойгоо гэмтээж байсан ба гэмтэж бэртсэн хүүхдүүдийн дөрөвний нэг нь эмнэлэгт хандсан байна. Түүнчлэн судалгаанд хамрагдсан алт олборлогч хүүхдүүдийн 34.4 хувь нь сургуулийн гадна буюу сургуульд суралцдаггүй болохыг тогтоожээ. Мөн хэдийгээр сургууль завсардаагүй ч алт олборлогч хүүхдүүдийн дунд хичээлээ таслах орхигдуулах явдал нийтлэг байна.

4. “Хувиараа алт олборлогчдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын байдал” судалгааг 2002 онд Эрүүл мэндийн яамны харьяа Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн хийсэн байна. Уг судалгааг мөнгөн усаар бариулан алт олборлож буйн хүүхэд, насанд хүрэгчдийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны байдлыг тодруулах, ажлын байран дахь мөнгөн усны агууламж, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг тодруулах, мөн мөнгөн усны талаарх ойлголт, хандлага, дадлыг тодруулах зорилготойгоор явуулжээ. Энэхүү судалгаанд Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгийн 6 сумдын 132 хүүхэд, 209 насанд хүрэгсдийг хамруулсан байна.

Уг судалгааны үр дүнд судалгаанд оролцогсдын 68 хувь нь мөнгөн усаар бариулан алт олборлодог ба тэдгээрийн 63 хувь нь гэртээ үүнийгээ хэрэгжүүлдэг болохыг тодруулсан байна. Судалгаанд оролцогсдын 17 хувьд нь мөнгөн усны архаг хордлогын клиник шинж тэмдэг илэрсэн ба тэдний гуравны нэг орчим хувь нь хүүхдүүд байжээ. Хувиараа алт олборлож гэртээ, гаднаа мөнгөн усаар алт олборлож буй өрхүүдийн агаарын орчинд мөнгөн усны агууламжийн шинжилгээ хийж үзэхэд зөвшөөрөгдөх хэмжээнээс 2.3-3.1 дахин их, гэртээ алт олборлож буй өрхүүдийн гэрийн нөхцлийн мөнгөн усны хэмжээг тодорхойлоход 12 дахин их болохыг тодорхойлжээ. Харамсалтай нь судалгаанд оролцогсдын мөнгөн усны хорт үр дагаврын талаарх мэдлэг туйлын хангалтгүй болохыг илрүүлжээ.

Түүнчлэн хувиараа алт олборлогчид давчуу, хязгаарлагдмал орчинд, биеийн албадмал байдалд ажилладаг, зөвхөн “бээлий” гэсэн ажлын хувцас хэрэглэдэг байна. Иймд уурхайчдын дунд сүүлийн 2 жилд осолд орож эрүүл мэндээрээ хохирох явдал буураагүй аж.

5. НХХЯ, ОУХБ, БНСУ-ын Засгийн газрын түншлэлийн байгууллага. Уул уурхай, барилгын салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний судалгаа. 2011 он.

Уг судалгааг НХХЯ, МУИС, ҮСХ-ны мэргэжилтнүүдийн баг уул уурхай болон барилгын салбарын цалингийн түвшин, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн харьцаа, түүнд үзүүлэгч, хөдөлмөрийн цаг, нас, хүйсээс үзүүлэх нөлөөг тодорхойлон холбогдох талуудын анхаарлыг хандуулах, цалин хөлсний бодлогын боломжит хувилбарыг санал болгох зорилготойгоор хийжээ. Уг судалгааны үр дүнд уул уурхайн салбарын цалин хөлсний хэмжээг нэмэгдүүлэх, илүү цагийн хөлсийг оновчтой тогтоох талаар хэлэлцээр хийгч талуудын анхаарах асуудал байж болох юм гэж дүгнэжээ. Цалин хөлсний хэмжээ үйлдвэрлэгчийн хэмжээнээс хамаарч байгааг илрүүлсэн ба хөдөлмөрийн хөлсний хэмжээг мөрдүүлэх чиглэлээр анхаарч ажиллах нь зүйтэй гэжээ. Мөн ажлын бус өдрөөр ажиллах нь нэлээд түгээмэл болохыг илрүүлсэн байна.

Харин боловсролын салбарын цалин хөлсний дундаж хэмжээ улсын дундажтай ойролцоо болохыг илрүүлээд цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгохын тулд нэмэгдэл, нэмэгдэл хөлс, илүү цагийн ажлын хөлс, урамшууллын механизмыг түлхүү ашиглах нь зүйтэй гэжээ. Мөн нийт ажиллагчдын 26 хувийн цалин нь тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байгаа тул цалин хөлсний нийт түвшинг нэмэгдүүлэхэд анхаарах ёстой. Ажиллагчдын 14 хувь нь илүү цагаар ажилладаг, илүү цагаар ажилладаг атлаа цалин хөлс нь доогуур байгаа учир цалин хөлс дутуу тооцогдох эсвэл хөдөлмөрийн мөлжлөгийн тодорхой хэлбэр оршин байж болзошгүй юм хэмээн үзжээ.

3. Уул уурхайн төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тогтоох судалгаа.

Ийм зорилго бүхий судалгаа нэлээд хийгджээ. Гэхдээ бид Ухаа Худаг төсөл, Оюу толгой төсөл, цагаан суварга төслийн үнэлгээг судалсны зэрэгцээ Дэлхийн банкнаас хийсэн Монголын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгэм эдийн засгийн нөлөөллийн судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийлээ.

6. Ухаа худаг төсөл-Байгаль орчин болон нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ. Уг үнэлгээгээгээр Өмнөговь аймаг, тэр дундаа Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумдын нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөг тодруулан, авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тогтоожээ. Энэхүү үнэлгээгээр Ухаа худаг төслийн эерэг нөлөө нь сөргөөсөө давуу боловч бусад төслүүдийн улмаас үүссэн байгаль орчин, нийгэмд үүссэн сөрөг асуудлуудын улмаас хязгаарлагдмал нөлөөтэй хэмээн дурьджээ. Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар орон нутгийн эдийн хөгжилд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байсан бол явуулын иргэдийн бөөгнөрөл үүсэх замаар хүн болон малын эрүүл мэндийн асуудалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй хэмээн үзжээ. Энэхүү нөлөөг зохицуулах боломжтой хэмээн үзэж нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж байгаа аж. Замын нөхцлийг сайжруулснаар тоосноос үүдэлтэй өвчнөөр малаа алдах, нарийн ширхэглэлтэй тоосонцороос шалтгаалан хүний эрүүл мэндийн асуудал, согтуу/ хариуцлагагүй жолооч нартай холбоотой замын ослын тоо багасана гэж үзжээ.

Ухаа худаг төслийг хэрэгжүүлэхдээ “Сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө (СТТОТ)”-г боловсруулан ажиллахаар төлөвлөөд байна. СТТОТ-г хэрэгжүүлэх чиглэлээр эрсдлийн бүлгийн (уурхайн орчим амьдардаг 10 малчин өрх) хүмүүстэй нүүр тулан ажиллаж санал бодлоо солилцон, багийн засаг дарга нартай сар бүр харилцана гэжээ. Мөн үүнээс гадна, Энержи ресурс компанийн зүгээс олон нийтийн уулзалт, хэлэлцүүлгийн багц ажлуудыг хөдөө орон нутаг болон төв суурин газруудад зохион байгуулах, хоёр үе шат бүхий санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх тухай төлөвлөсөн байна.

Ухаа худаг төслийн байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ нь үүсэж болзошгүй асуудлыг нарийвчлахаас илүүтэй ерөнхийчлөн, бусад хэрэгжиж буй төслүүдэд илүүтэй хамаатуулах байдлаар хийснээрээ учир дутагдалтай байна.

7. МАК, Цагаан суварга-БОНБНУ-ний тайлан. Уг тайлан нь Цагаан суварга хэмээх Монголын Алт Компани (МАК) зэс-молебдин олборлох уурхай, баяжуулах үйлдвэр, хаягдлын сан зэргийг байгуулах зорилготойгоор хэрэгжүүлэхээр Дорноговь аймгийн Мандах сумын Сэрвэн Сухайт гэдэг газар хэрэгжүүлэх төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой арга хэмжээнүүдийг төлөвлөсөн байна.

Төсөл хэрэгжсэнээр ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэнэ гэж үзэж байгаа ч, орон нутгийн иргэдийн ажил мэргэжлийн үр чадвар хангалтгүйн улмаас шууд бус ажил эрхлэлт, богино хугацааны ажил эрхлэлтийг илүүтэй нэмэгдүүлнэ гэж үзсэн байна. ажил эрхлэлттэй холбоотойгоор уг төсөл хэрэгжсэнээр янз бүрийн үндэстэн (тэр дундаа монгол болон хятад ажилчдын) ажилчдын хооронд соёл, ёс заншлын үл ойлголцол гарах, ажилчдын хотхон шаардлага хангахгүй байхаас зөрчил, маргаан, эсэргүүцэл гарах, ажлын байрны шаардлага, дүрэм журмыг зөрчих зэрэг сөрөг үзэгдлүүд гарч болзошгүй гэжээ.

Мөн хүн амын тоо олширсноос нийгмийн үйлчилгээ (боловсрол, эрүүл мэнд), дэд бүтцийн дарамт, үнийн өсөлт, архидалт, биеэ үнэлэлт, гэмт хэрэг зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийн гаралт ихсэнэ гэж үзсэн байна. Үүний эсрэгээр хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг төлөвлөсний дотор шинэ сумын төлөвлөлтийг багтаан сум, орон нутагт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар шууд бус ажил эрхлэлт, нийгмийн дэд бүтцийн дарамтыг бууруулахаар төлөвлөжээ. Түүнчлэн төсөл хэрэгжих нутгаас 500 метрийн зайд нөлөөлөлд өртөх эрсдэл бүхий 10 орчим өрх, 3 километр байх 6 өрхийн эдийн засаг, мал аж ахуй, бэлчээр, нутагшилтад нөлөөлөх нөлөөг тооцон, нөхөн олговор олгох тухай нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллахаар тогтжээ. Нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөрийг олон улсын стандартын дагуу явуулахын зэрэгцээ, үр нөлөөний талаар нарийвчлан судлах шаардлага бийг дурдсан байв.

Хүн ам олширсноос уугуул нутгийн хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй болохыг авч үзээд, мөн нутгийн иргэд ба төслийн гэрээт хамгаалалтын албаны ажилтнуудын хооронд зөрчил тэмцэл гарч болзошгүй тул хамгаалалтын албаныханд хүний эрхийн чиглэлээр сургалт явуулах нь зүйтэй хэмээн үзсэн байв. Уг уурхайн төслөөс байгаль орчин болон хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд хамгийн сөргөөр нөлөөлөх тоосжилтын асуудлыг хөндсөн атлаа тоосжилтын менежмент, замын хөдөлгөөний дүрмээр уг асуудлыг шийдэхээр төлөвлөсөн нь учир дутагдалтай байв.

8. Дэлхийн банк. Монгол орны уул уурхайн салбараас байгаль орчин болон нийгмийн салбарт үзүүлж буй үр нөлөө (2006). Энэхүү бүтээл нь 2003 онд хийгдсэн ажлын туршлага, 2005 онд үргэлжлүүлэн хийсэн судалгааны үр дүнд тулгуурлан бичигджээ. Энэ нь Эрдэнэтийн зэсийн үйлдвэр, Заамарын алтны уурхай, Түргэн голын ай сав, Шарын голын нүүрсний уурхай, Бор-Өндөрийн хайлуур жоншны уурхай, Багануур болон Адуунчулууны нүүрсний уурхайн байгаль орчин хийгээд нийгмийн байдалд үзүүлэх нөлөөнд дүн шинжилгээ хийсэн байна. Уг судалгаа нь монгол орны уул уурхайн салбар, тэр дундаа гар аргаар алт олборлож буй үйл ажиллагааны байгаль орчин болон нийгэмд үзүүлж буй нөлөөг тодруулах, хууль эрх зүйн болон салбарын бүтэц, зохион байгуулалтын тоймыг гаргах, улмаар үр ашигтайгаар ашиглахад туслах чиглэлүүдийг санал болгох зорилготой аж.

Эрдэнэт, Багануур зэрэг хотуудаас харахад тухайн нутагт оршин буй уурхай нь ихээхэн үүрэгтэй болохыг харуулж байна гэж үзсэн ч, өнөөгийн уул уурхайн салбар нь хөдөөгөөс хот руу хүн ам, баялагийн шилжилт хийгдэх гол нөхцөл болж байна гэж үзжээ. Хэдийгээр уурхайн үйл ажиллагаа нь дагавар сууринг дэмжих боловч, тэдгээр суурин нь уурхайгаас бүрэн хамааралтай болж байгааг ажигласан байна. Уурхай хаагдсаны дараагаар дагуул суурингийн хүн амын ахуй, амьжиргаанд хүнд цохилт болох эрсдэлтэй гэжээ. Ийнхүү уул уурхайн салбарт хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн хангамж, орон нутгийн хөгжил, газар ашиглалт зэрэг албан ёсны уурхайгаас дэмжиж болох нийгмийн олон асуудлууд орхигдож байгааг цохон тэмдэглэсэн байна.

Гар аргаар алт олборлох явдал нь хууль бус хэдий ч, орон нутгийн болон иргэдийн амьжиргаанд бодит эх үүсвэр болж байгаа ач холбогдолтой гэж үзсэний зэрэгцээ хүүхдээ сургууль завсардуулахгүйгээр алт олборлож байна гэж үзсэн бусад судалгаануудаар дахин баталгаажуулалт хийхийг шаардаж байна.

9. Хөх тэнгэр Хөгжил консорциум. Оюу толгой төслийн эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ: Орон нутгийн судалгаа (2010).

Оюу толгой болон бусад уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөгөөр Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Баян-Овоо, Манлай зэрэг сумдын хүн амын эрүүл мэндийн байдалд үзүүлэх нөлөөг тодруулахад анхаарсан байна. Судалгааг ганцаарчилсан ярилцлагын аргад тулгуурлан явуулсан ба дээрх сумдын холбогдох албан тушаалтнууд болох нийт 51 хүнтэй ярилцжээ. Ингэхдээ нийгмийн бусад салбар боловсрол, дэд бүтэц, зах зээл, мөн байгаль орчны өөрчлөлттэй холбон авч үзсэн байна. Энэ судалгаагаар

- Даланзадгад, Ханбогд сумдад хүн ам нэмэгдэн ирснээр эмнэлэг, боловсролын үйлчилгээ, дэд бүтэц, зах зээл дэх өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдснээр уугуул иргэдийн уул уурхайн үйлдвэрлэлээс өмнөх нөхцөл байдалд сөргөөр нөлөөлнө гэж үзжээ.
- Оюу толгойд ажил эрхлэх болсноор ажилтны гэр бүлийн орлого нэмэгдэж, үр хүүхдийнхээ боловсрол, эрүүл мэндэд зарцуулах мөнгөн дүн өсөж эерэг нөлөө үзүүлж байгаа ч сумдын иргэд гол төлөв цалин багатай ажил эрхэлдэг нь хүн амын амьжиргааны түвшинд мэдэгдэхүйц өсөлт бий болгохгүй байна гэжээ.
- Улаанбаатар-Өмнөговь-Таван толгой-Шивээ хүрэн-Гашуун сухайтын замын нөхцөл муу байгаатай холбоотойгоор зам тээврийн ослын тоо өссөн. Мөн эцэг эхийн хараа хяналтгүй хүүхдүүд (эцэг эх нь наймаанд явсан, уурхайд олон хоногоор ажилладаг, хөдөө малтай байдаг) машин, мотоцикль жолоодож, хөдөлгөөнд оролцож гэмтэх, зөрчилд холбогдох явдал гарч байна. Мөн өмчийн хулгай байнга гарч, ихсэж байна.
- Уурхай ашиглаж эхлэхээр усны нөөц багасна гэж ярилцлагад оролцогчдын дийлэнхи хувь нь үзжээ. Мөн сүүлийн жилүүдэд усны нөөц багасаж, сумын мал услахад хүрэлцээтэй байсан худаг амархан шавхагддаг, хайгуулаар цэгээ тогтоогоод өрөмдөхөд ус гарахгүй байгаа зэрэг нь усны нөөц багасаж байгааг харуулж байна гэж олон нийт үзэж байгаа тул усны нөөцийг зөв тогтоож, баталгаажуулахыг зөвлөжээ.
- Нүүрсний тээвэрлэлттэй холбоотойгоор хөрс эвдэрч, хог хаягдлын улмаас бохирдон, агаарт тоосонцорын хэмжээ нэмэгдэж байна.
- Уул уурхайн салбарын үйл ажиллагааны эрчимтэй хөгжилтэй зэрэгцэн хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөж, хүнсний хомсдолд орж болзошгүй хэмээн иргэд үзсэн ба хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн чанарт тавих хяналт сул байгаатай холбогдуулан тодорхой зөвлөмжүүдийг гаргажээ.
- Шилжилт хөдөлгөөн, удаан хугацаагаар гэрээс хол ажилладаг зэрэг нь БЗХӨ нэмэгдэхэд нөлөөлж байна гэж оролцогчид үзсэнийг дурдсан ба БЗХӨ-өөр өвчлөгсөд эмнэлэгт ирж үзүүлэх нь ховор, ихэвчлэн урьдчилан сэргийлэх үзлэгээр өвчнийг илрүүлдэг байна. Аймгийн хэмжээнд ДОХ бүртгэгдээгүй байна гэжээ.

4. Уул уурхайн асуудлыг хүний хөгжилтэй холбон авч үзсэн судалгаа

2011 оны Хүний хөгжлийн илтгэл Уул уурхай ба тогтвортой хүний хөгжил сэдвээр бичигдсэнтэй холбоотойгоор уг илтгэлийг бичихэд шаардагдах эх бичгийг бэлтгэхээр судлаач Б.Алтанцэцэг, Ч.Энхзаяа нар ажиллажээ.

10. *Б.Алтанцэцэг. Уул уурхай ба тогтвортой хүний хөгжил (илтгэлд зориулсан эх материал).* Монгол улсын Хүний хөгжлийн илтгэл 2011. Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү: байгаль орчин, хүний хөгжил. Эх бичигт дурдсанаар уул

уурхайн салбар эрчимжих болсон үеэс хүний хөгжлийн индекс (ХХИ) ямагт нэмэгдэж байгааг, уул уурхай зонхилдог бүс нутгийн ХХИ зонхилдоггүй бүс нутгийнхаас өндөр байгааг онцолсон байна. Учир нь нэг хүнд ногдох орлого нэмэгдсэн, хүн амын эрүүл мэнд сайжирсантай холбон үзжээ.

Гэхдээ ХХИ-ийг ихээхэн явцуу болохыг дурьдаад уул уурхайгаас үүдэлтэй эрүүл мэндэд тулгамдаж буй дараах асуудлуудыг хөндсөн байна. Тухайлбал, уул уурхайн албан болон албан бус салбарын үйл ажиллагаагаар агаарын тоосжилт, дуу чимээ их хэмжээгээр нэмэгдэж, азотын давхар ислийн агууламж хэтэрсэн байна. Эдгээр нь хүн, амьтны эрүүл мэндэд шууд нөлөөлөхөөс гадна уурхайн орчимд гарах осол аваарыг нэмэгдүүлэх сөрөг үр дагавартай гэжээ. Мөн Өмнөговь аймгийн хэмжээнд хамгийн түгээмэл 10 өвчлөлтийн нэгдүгээрт амьсгалын тогтолцооны өвчин орж байгаа бөгөөд 2007 оны байдлаар 10000 хүн ам тутамд 1148.5 өвчлөлт бүртгэгдсэн байна. Энэ нь улсын хэмжээтэй харьцуулахад амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл Өмнөговь аймагт 3.5 дахин их байна. Мөн Дархан-Уул аймгийн Хонгор, Төв аймгийн Жаргалант, Борнуур сум, Өмнөговь аймагт мөнгөн усны хэмжээ зохистой хэмжээнээс давж, энэ нь гажигтай ураг төрөхөд хүргэж байгааг онцолсон байна. Иймд уул уурхайн салбарын үйл ажиллагаа хүний эрүүл мэнд болон ургийн төрөлтөд ийнхүү сөргөөр нөлөөлснөөр үндэсний аюулгүй байдлыг алдагдуулж, амьжиргааны чадавхи, амьдралын чанарыг муутгаж улмаар Монголын өнөөгийн болон ирээдүйн хүний хөгжилд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэжээ.

Уул уурхайн компаниуд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг харилцан адилгүй түвшинд хэрэгжүүлдэг байна. Цөөн тооны уурхайнуудын хувьд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хариуцсан албан тушаалтан, их, бага эмчийг орон тоогоор ажиллуулан орон тооны бус зөвлөл, комисс байгуулж, сургалт зохион байгуулах, хяналт тавих, зааварчилгаа өгөх зэрэг ажлыг хийж хэвшүүлсэн байна. Харин бусад алтны уурхайнуудын хувьд аюулгүйн ажиллагааны зааварчилгаанд гарын үсэг зуруулах, ажлын хувцас олгох, нормын сүү, тараг өгөх төдийгөөр хязгаарладаг байна. Машин тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа алдагдах, техникийн баримт бичгийг журмын дагуу хөтөлдөггүй, шөнийн нөхцөлд орчны гэрэлтүүлэггүй ажиллах, цахилгааны холболт ил задгай, тоног төхөөрөмжийн хаалт хамгаалалт байхгүй зэрэг аюулгүй ажиллагааны наад захын горим алдагдах явдал байдаг байна. Түүнчлэн ихэнх компаниудын ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл маш хангалтгүй байдгаас мэргэжлээс шалтгаалсан өвчлөл уурхайчдын дунд өндөр тархалттай байхад хүргэж байна хэмээн дүгнэжээ.

Хөдөө орон нутагт ажлын байр хомсдон, амьжиргааны боломж хязгаарлагдаж ядууралд орсон олон хүн ямар нэгэн орлогын эх үүсвэр хайж байсан үед уул уурхайн салбар нь олон мянган Монголчуудыг орлогын эх үүсвэрээр хангаж, орон нутгийн амьжиргаанд ихээхэн хувь нэмэр болж байгааг тэмдэглэсний зэрэгцээ албан бусаар олборлогчдын эрүүл мэнд нь муудах, хүүхдийн хөдөлмөрийг ашиглах, улмаар хүүхдүүд сургууль завсардах, архи дан согтуурах зэрэг уг салбарын үйл ажиллагаатай холбоотой сөрөг нөлөөллүүд байна. Мөн өмнө хийгдсэн судалгаанууд нь олборлогчдын нийгэм, эдийн засгийн байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг хэдий ч уг салбарын орон нутгийн хүн ам, байгаль орчин, эдийн засагт үзүүлж буй нөлөөний талаар орхигдуулсан байдаг, албан бус секторын эдийн засаг, нийгэм, байгаль орчин, хүний хөгжилд үзүүлж буй нөлөөг үндэсний хэмжээний түүвэр судалгаагаар бодитой үнэлж гаргах нь энэ салбарыг орон нутагт ажил эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөшүүрэг болгоход

чиглэсэн бодлого, зохицуулалтыг тодорхойлоход туйлын ач холбогдолтой мэдээллээр хангах юм гэжээ.

Уг судалгаа нь орлогын өсөлт, орлого хуваарилалтад дүн шинжилгээ хийсний үр дүнд ДНБ-ний хэмжээ өссөн атлаа ядуурал 1 пунктээр ч буурч чадаагүй байгаа, тэр дундаа хөдөөгийн ядуурлын түвшин өссөн тул уул уурхайн салбарын хөгжлийн үр шимийг ядуу иргэд, хөдөө орон нутгийнхан хангалттай хүртэж чадахгүй байна гэж дүгнэжээ. Түүнчлэн уул урхайн салбар эрчимжсэнтэй холбоотойгоор засаглалын байдал муудаж, иргэдийн оролцоо туйлын хангалтгүй байна гэж үзсэн байна.

11. *Ч.Энхзаяа. Албан бус уул уурхай ба хүний хөгжил (илтгэлд зориулсан эх материал)*. Монгол улсын Хүний хөгжлийн илтгэл 2011. Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү: байгаль орчин, хүний хөгжил. Уг эх бичигт Монгол Улс дахь албан бус уурхай нь ядуурлаар өдөөгдсөн, орлогын эх үүсвэр хайж амьдралаа залгуулах хүмүүсийн үйл ажиллагаанаас үүсэж хөгжсөн ба өрхүүдийн наад захын хэрэгцээг хангахуйц мөнгөн орлогыг баталгаатайгаар хангаж буй эдийн засгийн салбар хэмээн үзсэн байна. Албан бус уурхайчдын нэлээдгүй нь мал маллах, төрийн алба хаших зэрэг үндсэн ажлынхаа хажуугаар эрхэлж байгаа нь тэдгээрийн орлогын хэмжээг нэмэгдүүлэх, үндсэн аж ахуйдаа хөрөнгө оруулах зэрэг эерэг үр нөлөөтэй болохыг тодруулжээ.

Бичил уурхай төслийн (2009) судалгаагаар 10 хүн тутмын нэг нь гэмтэж бэртсэн байдаг ба оюун ухаан самуурах, мөнгөн усны хор уршгаас гадна архидалтын дон, бэлгийн замаар халдварлах өвчнүүд, нүд гэмтэх, багтраа өвчин, чанга дуу авианаас дүлийрэх, хүнд юм өргөснөөс булчин шөрмөс татах зэргээр эрүүл мэндээрээ хохирч байгааг, мөн 2006 онд хийгдсэн судалгаагаар албан бус уурхай эрхлэхээс өмнөх үетэй харьцуулбал эрүүл мэндийн байдал муудсан хэмээн хариулагчид тал орчим хувийг эзэлж байсныг оруулсан байна. Хэдийгээр орлогын эх үүсвэр болж, орлого нэмэгдүүлж байгаа ч, хүний эрүүл мэнд зэрэгт сөргөөр нөлөөлж байгаа тул хүний хөгжилд сөрөг нөлөөтэй байна хэмээн дүгнэжээ.

БҮЛЭГ 3. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТОЙМ ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хуулийн дүн шинжилгээг хийхдээ уул уурхай, байгаль орчин, газар, нийгэм-эдийн засаг, хүний эрүүл мэндийн харилцааг зохицуулсан 50 гаруй хуулиас уул уурхай үйл ажиллагааны нөлөөллөөс хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулсан Ашигт малтмалын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Эрүүл мэндийн тухай, Байгаль хамгаалах тухай, Газрын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулинд уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүний эрхэд үзүүлж буй нөлөө, зохицуулагдаагүй харилцаа (Gap analysis) зэрэг сэдэв агуулгын хүрээнд дүн шинжилгээ хийв.

Холбогдох хуулийн шинжилгээгээр уул уурхайгаас хүн, нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар хэрэгждэггүй, сул заалтууд нийтлэг байгааг дараах матрицаас харж болно.

Матриц 3.1. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа зарим хуулинд уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэм, хүнд үзүүлэх нөлөөллийн зохицуулалт, хэрэгжилт

Хууль	Хүн, байгаль орчныг хамгаалах заалт	Хуулийн хэрэгжилт
Байгаль хамгаалах	3-р бүлэг, 14-р зүйл. Байгаль хамгаалах талаарх Засгийн газрын бүрэн эрх	-Цогцэций, Ханбогд суманд тоос тоосжилт, бэлчээрийн талхдал зөвшөөрөгдөх

<p>тухай</p>	<p>Засгийн газар нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой нөлөөлөл бүхий үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан өмчийнх нь хэлбэрийг үл харгалзан зогсоох;</p> <p>3-р бүлэг, 16-р зүйл. Аймаг, нийслэлийн ИТХ-ын болон Засаг даргын бүрэн эрх</p> <p>-Аймгийн ИТХ нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;</p>	<p>хэмжээнээс давсан ч авч байгаа арга хэмжээ байхгүй</p> <p>-Аймгийн ИТХ-аас байгаль хамгаалах ба нөхөн сэргээх ажилд баталсан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээлэл ил тод биш.</p>
	<p>4-р зүйл. Байгаль орчныг хамгаалах талаарх иргэний эрх, үүрэг</p> <p>1. Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь эрхийг эдэлнэ: 1/ гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх; 2/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах, байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;</p>	<p>-Судалгаанд хамрагдсан 3 сумын түвшинд уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас эрх ашиг нь хамгийн ихээр хөндөгдөж байгаа малчдад учирсан хохирлыг тэдний оролцоотойгоор бодитойгоор үнэлсэн тооцоо судалгаа хомс байна.</p> <p>-Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумын иргэд малчид уул уурхайн сөрөг нөлөөгөөр байгаль орчин доройтож байгааг эсэргүүцэн нутаг усаа хамгаалахаар ТББ-д нэгдэж эхэлж байна.</p>
	<p>10 дугаар зүйл. Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээ</p> <p>2/ байгаль орчин, түүний баялгийн талаар хүн ам, сонирхогч аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангах;</p> <p>11 дүгээр зүйл. Байгаль орчны судалгаа, шинжилгээ, түүний санхүүжилт</p> <p>1. Улсын болон бүс нутгийн хөгжлийн баримжааг тодорхойлох, нэн ховордсон амьтан, ургамлыг нөхөн сэргээх, өсгөн үржүүлэх, хөрс, ус, агаарыг хамгаалах болон хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах талаарх судалгаа, шинжилгээний ажлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.</p>	<p>-Хангалтгүй</p>
<p>Ашигт малтмалын тухай хууль</p>	<p>11-р зүйл Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт</p> <p>11.1.3 Нийгэм-эдийн засгийн бүхий л хүрээнд нөлөөлөх байгалийн хүчин зүйл болоод хүний үйл ажиллагаанд геоэкологийн судалгаа хийж үнэлгээ өгөх</p> <p>11.1.10 Уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах</p> <p>11.1.15.цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох, дахин олгох, цуцлах, шилжүүлэх, барьцаалах, талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан өгөх, шилжүүлэх ажиллагааг олон нийтийн хяналтын дор явуулах нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>АМГ-ын 2010 оны жилийн тайланд 2 заалтын хэрэгжилтийг хангасан тухай мэдээлэл байхгүй байна.</p>
	<p>Хайгуулын лиценз эзэмшигч ААНБ орон нутаг нөхөн сэргээлт хийх нийт зардлын 50 хувийг байршлуулах</p> <p>43-р зүйл. Ажиллах хүчний талаар тавигдах шаардлага</p>	<p>-Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа, түүний зарцуулалтын мэдээлэл ил тод биш</p> <p>-ОТ ХХК болон туслан гүйцэтгэх компанид ажиллаж буй хятад ажилчдын тоо 7000-д</p>

43.1 Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно.

43.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.

43.3 Энэ хуулийн 43.2-т заасан төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж боловсролын болон эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаарх журмыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

41-р зүйл. Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх

41.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.

8-р зүйл. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрх

8.1.2 Агаарыг хамгаалах, бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх;

8.1.4 Агаар бохирдуулах бодисын хаягдал, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эх үүсвэрийн тооллогыг агаарын чанарын мэргэжлийн албаны орон нутаг дахь салбартай хамтран нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

8.1.8 хот, тосгон, бусад суурин газрын агаарын бохирдлын хэмжээ, урьдчилсан мэдээг өдөр тутам нийтэд мэдээлэх;

хүрсэн мэдээ байгаа, хэрэв бодитой бол гадаад ажилчны ажлын байрны төлбөр тухайн суманд төвлөрч боловсрол, эрүүл мэндийн салбарт зарцуулагдсан талаар мэдээлэл ил тод биш

-Хятад ажилчдын тооны талаар бодитой мэдээлэл дутагдалтай байна.

-Хуульд ийм заалт байгаа ч нөлөөллийн бүс тогтоосон, хохирлын жишиг үнэлгээг тогтоосон хууль байхгүй байна.\малчид өвөлжөөнөөс гадна нийтийн эзэмшил хэлбэрээр бэлчээр ашиглаж байгаа, бэлчээрт учруулсан хор хохирлыг тооцох\

-Хохирол, нөхөн олговрын хэмжээг зах зээлийн үнэ, нөхөн оруулалтын үнээр тогтоосон туршлага манай улсад бараг байхгүй байна.

-2011-2012 онд Оюу толгой ХХК, Ханбогд сумын ЗДТГ хамтран нөлөөллийн бүс тогтоож нүүлгэн шилжүүлэх, нөхөн төлөх зохицуулалтын арга хэмжээг эрх ашиг нь хөндөгдсөн талуудтай зөвшилцөн шийдвэрлэх зарчмаар ажиллаж байна.

- Цогтцэций сумын захиргаанд тоосжилт хэмжих багаж байхгүй.

-Энержи ресурс ХХК сумын төвийн 4 цэгт хэмжилт хийдэг ч хэвийн хэмжээнд байна гэсэн үзүүлэлт гардаг.

-Сумын засаг захиргааны байгууллагын төлөөлөл, иргэд, малчид тоос тоосжилт их, түүний сөрөг нөлөөний жишээ баримт олныг хэлж байгаа ч тоос тоосонцорын хэмжээ, түвшингийн талаар тодорхой мэдээлэлгүй байна.

-Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага Агаарын тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллахгүй байна.

-Ханбогд, Цогтцэций суманд тоосжилт агаарын чанарын стандартад заасан хэмжээнээс давжээ. (ОТ ХХК, 2012)

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, захиргааны байгууллага, аймаг сумын ИТХ, Засаг дарга нар хуульд заасан бүрэн эрхээ хангалттай түвшинд хэрэгжүүлж чадахгүй байна.

-Цогтцэций, Ханбогд сумын хүн амын дунд уул уурхайн сөрөг нөлөөллөөс шалтгаалсан төрөл бүрийн өвчлөл нэмэгдсээр байхад мэргэжлийн байгууллагын иж бүрэн оношилгоо судалгаа, судалгааны ажлыг захиалан хийлгээгүй байна. \2011 онд НЭМХ,

Агаарын тухай хууль

Эрүүл мэндийн тухай

4-р зүйл. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчим

4.1.1 Төр хүн амын эрүүл мэндийг төрийн онцгой анхаарал, ивээлд авах; хүн амын эрүүл мэндийн байдлыг судлах, хянах, үнэлэх, эрэлт хэрэгцээг үндэслэн эрүүл мэндийн салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох;

8-р зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1.2.хүн амын эрүүл мэндийн байдлыг судлах, хянах, үнэлэх, эрэлт хэрэгцээг үндэслэн эрүүл мэндийн салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох;

8.1.6.хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх үндэсний хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцох;

8.1.7.эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг захиалан гүйцэтгүүлэх;

8.1.8.эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх;

10-р зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийнТөлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

10.1.2 Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн асуудлаар Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэн дүгнэлт өгөх;

10.1.4.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний хамтын оролцоог хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

11-р зүйл.Бүх шатны Засаг даргын бүрэн эрх

11.1.2 Харьяалах нутаг дэвсгэртээ хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөр, төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

12.1.5 **Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь** харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх.

Газрын тухай

50-р зүйл. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах нийтлэг шаардлага

50.1. Газар эзэмшигч, ашиглагч нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар дараахь шаардлагыг биелүүлнэ:

50.1.1. газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцах;

50.1.2. ашигт малтмал олборлох, барилгын материал бэлтгэх, төмөр зам, авто зам тавих, эрэл хайгуул, сорилт туршилт, шинжилгээний ажил хийх болон бусад хэрэгцээнд зориулан ухаж ашигласнаас эвдэрч гэмтсэн газрыг тухай бүр өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээж, засаж тохижуулж байх;

50.1.3. газар, түүний баялаг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахдаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;

50.1.4. ойн төгөл, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйл бүхий

Хөх консерциум ТББ Ханбогд суманд эрүүл мэндийн нөлөөллийн чанарын судалгааг хийсэн\

-Нөлөөллийн бүс дэх хүн амын дундах харшил, амьсгалын зам, тоосжилт, халдварт, мэргэжлээс шалтгаалах өвчин, БЗДХ зэрэг өвчний тандалт судалгаа хийгээгүй байна.

АХБ, МУЗН зэрэг олон улсын болон дотоодын ТББ-ын хэрэгжүүлсэн төслийг эс тооцвол орон нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллагаас төлөвлөгөө, төсөв боловсруулж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа хомс

-Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумын бэлчээрийн талбайн 70 гаруй хувь нь талхлагдсан.

-Оюу толгой, Энержи ресурс болон нүүрсний тээвэрлэлтийн компани хөрс, бэлчээрийг талхалсан.

ОИН.МН
СУДАЛГААНЫ САН

газрыг хамгаалах;

50.1.5. бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт байгаль орчинд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахгүй байх.

52 дугаар зүйл. Бэлчээр, түүнийг зохистой ашиглах, хамгаалах

52.1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батална.

52.2. Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ. Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно.

34-р зүйл. Газар эзэмших гэрээ, түүнийг байгуулах журам

34.6.9. Газар эзэмших гэрээнд эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах нөхцөл, журмыг тусгана

Төрийн хяналт шалгалтын тухай хууль

5 дугаар зүйл. Хяналт шалгалт хийх нийтлэг үндэслэл, журам

5.3. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар ноцтой аюул болон их хэмжээний хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналт шалгалтыг мэргэжлийн хяналтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр энэ хуулийн 5.2-т заасан удирдамжгүйгээр хийж болно. (5.2.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийнэ)

10-р зүйл. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, түүний нийтлэг бүрэн эрх

10.9.7 хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох, шаардлагатай зүйлийг ариутгах, хоргуйжүүлж цэвэршүүлэх, тухайн барилга байгууламж, машин, тоног төхөөрөмжийн

-Хяналт шалгалтын байгууллагын эрх үүрэг нь хуульд тодорхой туссан ч өнөөг хүртэл Цогтцэций, Ханбогд суман дахь шороон замын тээвэрлэлтээс бий болж байгаа тоос тоосжилт, замын тээврийн осол хэвээр хүний эрүүл мэндэд ноцтой хор хохирол учруулсан хэвээр байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ашиглалтыг зогсоох, холбогдох бүтээгдэхүүнийг худалдах, борлуулахыг хориглох, устгах буюу зохих шаардлагад харшлахгүй бол өөр зориулалтаар ашиглах шийдвэр гаргах, энэ тухай олон нийтэд зарлан мэдээлэх.

10.9.8 хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах.

Байгаль хамгаалах тухай хууль нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршдог ба байгаль орчныг хамгаалахтай холбогдох хууль тогтоомжид Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Усны тухай, Рашааны тухай, Байгалийн ургамлын тухай, Ойн тухай, Агаарын тухай зэрэг 20 гаруй хууль, эдгээр хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм, журмууд багтдаг. Судалгаанд хамрагдсан иргэд, орон нутгийн удирдлага, мэргэжлийн хүмүүсийн өгсөн мэдээллээр, уул уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль экологийн унаган төрх алдагдсан, тоос тоосжилт агаарын чанарын стандарт түвшнээс давсан, усны түвшин эрс багасан, хөрс, ургамлын бүрхэвч, бэлчээр талхлагдсан, нөхөн сэргээлтийг хангалтгүй хийдэг, хүн мал эрүүл аюулгүй орчинд аж төрөх эрх нь зөрчигдсөн гэснээс үзвэл хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Жишээ 3.1

Энержи ресурс, Эрдэнэс таван толгой, Жижиг таван толгой компани ашиглалт, тээвэрлэлтийн лицензтэй. Үүнээс гадна эдгээр компанийн гэрээт тээвэр хийдэг 50 гаруй компани газар бэлчээрийг талхалж байна. Малчдын асуудал хамгийн хүнд байна, малын бэлчээргүй боллоо. Байгаль орчин сүйдэж байна, тоос тоосжилт хэрээс хэтэрсэн. Уул уурхайн компаниуд нөхөн сэргээлт хангалтгүй хийдэг.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, ЗДТГ-ын дарга)

Туслан гүйцэтгэх компаниуд хар зам дагаад малын бэлчээр дээр зөвшөөрөлгүй кемп барьдаг. 50 сая төгрөгөөр торгуулчихаад одоо нүүлээ гэсээр 2 жил болдог. Компаниуд зөвшөөрөлгүй ус ашигладаг, зөвшөөрөлгүй карьер үүсгэж элс хайрга шороо авдаг. 5 толгой транс компани дүүрэн хятад ажилчинтай. Тоолох гээд очихоор бодит тоо гардаггүй. ИТХ, Засаг дарга нар олон газартай, 100 хувь хятад ажилчид бүхий нүүрсний компанитай. Тээврийн хэрэгслэлийн татвараа суманд төлдөггүй. Манай сумынхан уул уурхайн нөлөөгөөр малгүй, ажилгүй, орлогогүй болж байна. Уул уурхайн компаниуд хуулийн хүрээнд ажиллаж байгаа эсэхэд орон нутгийн засаг захиргааны байгууллагын тавих хяналт маш муу, уул уурхайн компанитай хувийн эрх ашгаар хамтарч ажилладаг. Манай суманд хот төлөвлөлт байхгүй. Сумын уугуул иргэд нь газар эзэмших эрх байхгүй. Сум хөгжүүлэх сан гэж байдаг гэсэн, энэ талаар иргэд огт мэдээлэл байхгүй. Иргэдийн эрүүл орчинд амьдрах эрх нь зөрчигдөж байна, уурхай хоёрхон километрийн зайд байна. Хүүхдүүд амьсгалахад хэцүү боллоо. Сум орон нутаг, төр засгийн зүгээс авч байгаа арга хэмжээ алга байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Багийн засаг дарга)

Дээрх жишээнээс харахад Үндсэн хууль, Байгаль хамгаалах тухай хууль, Байгаль хамгаалах багц хууль, Эрүүл мэндийн тухай, Газрын тухай, Ашигт малтмалын

тухай хуулиудын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулаад зогсохгүй хуулийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй аймаг, сумын ИТХ, Засаг дарга нар тодорхой арга хэмжээ авахгүй байгааг илтгэсэн жишээ баримтыг судалгаанд хамрагдсан орон нутгийн албан хаагч нар өгчээ.

Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэм, хүнд үзүүлэх нөлөөлөлтэй холбогдох хуулийн заалтын биелэлт хангалтгүй байгаа ч байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 2012 оны 5-р сард шинэчлэн баталж, шинэчлэн баталсантай холбогдуулан Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар болсон нь сайшаалтай.

Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршдог. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэ хуулийн нэр томъёонд стратеги үнэлгээ, бодлого хөтөлбөр төлөвлөгөө олон нийт зөвлөлдөх байгуулга, аюул ослын үнэлгээ зэрэг ойлголтуудыг шинээр оруулсан нь байгаль орчин, хүн, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг цогц байдлаар авч үзжээ.

Матриц 3.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулинд орсон өөрчлөлт

Одоогийн хууль	Шинэчилсэн хуульд орсон өөрчлөлт
Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ	1.Стратегийн байгаль орчны үнэлгээ 2.Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ 3.Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ	4. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ а/ ерөнхий үнэлгээ б/нарийвчилсан үнэлгээ
-	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах
Байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны шинжилгээний хөтөлбөр	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
-	Эрсдэлийн үнэлгээ
-	Газрын тос болон уул уурхайн төслүүд нь нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөөг тухайн үйл ажиллагаа дуусч хаалт хийхээс 3 жилээс доошгүй хугацааны өмнө боловсруулах
Үнэлгээний шаардлага биелүүлээгүй төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээг хангалтгүй хийсэн албан тушаалтан- 50,0, аж ахуйн нэгж байгууллага – 200,0-250,0	-Байгаль орны үнэлгээг буруу хийгдсэн нь тогтоогдвол үнэлгээний эрх цуцлах - Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөр торгох
	Олон нийтийн оролцоо -санал авах -олон нийтэд мэдээлэх -хэлэлцүүлэг зохион байгуулах -сайдын баталсан журам байх
/ 12 хоног /	Үнэлгээний дүгнэлт /14 хоног/

Хууль тогтоомжид нийцээгүй техник технологи нь байгаль орчинд халтай, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй төслийг буцаах	-техник технологи үйл ажиллагаа нь байгаль орчинд илэрхий халтай, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, төрөөс баримталж байгаа бодлого, стратеги үнэлгээний дүгнэлт болон холбогдох хууль тогтоомжид нийцээгүй төслийг буцаах
Үнэлгээний комиссыг байгаль орчны ТЗТБ-ын шийдвэрээр томилно.	Мэргэжлийн зөвлөл байгаль орчны ТЗТБ-ын дэргэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудлыг зохицуулах мэргэжлийн зөвлөл ажиллана

Эх үүсвэр: Байгаль орчин ногоон хөгжлийн яам

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоо хяналт тавих гэдэгт үнэлгээний явцыг олон нийтэд мэдээлэх, үнэлгээний тайланд санал авах, хэрэгжилтэнд хяналт тавих, хянан магадлагаа хийхтэй холбогдсон зохицуулалт ялангуяа орон нутгийн иргэдийн оролцоог ашигт малтмал олборлох боловсруулах төслийг хэрэгжүүлэхэд идэвхжүүлэх, мэдээлэлээр хангах санал авах боломжийг тусгасан нь нөлөөллийн бүс дэх иргэд, малчид оролцох боломжийг анх удаа энэ хуулиар зохицуулж өгчээ.

Энэ хуульд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудлыг зохицуулах, үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаа болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний тухай асуудлыг оруулсан байна. Мөн хуулийн 7.7-д Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, аргачлалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаа болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана гэж тодорхой заасан байна. Энэ заалтыг үндэслэн холбогдох төрийн байгууллага (ЭМЯ, БОНХЯ) нөлөөллийн үнэлгээ хийх журам, аргачлалыг боловсруулж батлахаар ажиллаж байна. Өнөөдрийг хүртэл эрүүл мэндийн салбарын хууль, бодлогын баримт бичигт уул уурхайн үйл ажиллагааны эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөлөлд үнэлгээ хийх зохицуулалт тусгагдаагүй байсан билээ.

Түүнчлэн уул уурхайн үйл ажиллагааны улмаас нөлөөллийн бүсэд нутаглаж буй малчин өрхийн газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх маш ихээр зөрчигддөг бөгөөд үүнтэй холбогдож газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын асуудал хөнддөг. Уул уурхайн салбар хөгжөөд 10 гаруй жил болж байхад уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийг тогтоох, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн асуудлыг зохицуулсан хууль байхгүй байсаар байна. Ашигт малтмалын тухай хуулийн 41.1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасан. Цаашид хохирлын үнэлгээг тооцох аргачлал, журам, хохирлын үнэлгээг хийх байгууллагын талаарх зохицуулалт шаардагдаж байна. Иймд хуулийн зохицуулалтыг улам боловсронгуй болгох эсвэл бие даасан хуулиар зохицуулах хэрэгцээтэй байна.

Харин АХБ-ны Нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлж, ашиглах төслийн хүрээнд “Газар албадан чөлөөлөх тухай” хуулийн төслийг боловсруулж санал авах, хэлэлцүүлэх шатанд явж байгаа ажээ. Газар албан чөлөөх тухай хуулийн төслөөр хуулийн үзэл баримтлал, газар албадан чөлөөлөх зорилго, газар албадан чөлөөлөлтөд өртөх объект, газар албадан чөлөөлтөд өртөгч, нөхөн олговор, газар албадан чөлөөлөх үйл ажиллагаа, газар албадан хүчээр чөлөөлөх гэсэн харилцааг зохицуулахаар тусгажээ.

БҮЛЭГ 4. ГУРВАНТЭС, ХАНБОГД, ЦОГТЦЭЦИЙ СУМЫН МАЛЧДАД УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ

4.1. Малчин өрхийн нийгэм-эдийн засгийн байдал

Уул уурхайн нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа 50 малчин өрхийн нийгэм-эдийн засгийн үзүүлэлтийг Хүснэгт 4.1-т харуулав. Өрхийн нийгэм, хүн ам зүйн байдлыг тодорхойлохдоо насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай хүний тоо, ажил эрхэлдэг орлоготой хүний тоо, ажилгүй хүний тоо, МАА-д байнга ажилладаг хүний тоо зэрэг гол үзүүлэлтийг авч үзсэн болно.

Хүснэгт 4.1. Өрхийн гишүүдийн эдийн засгийн идэвхийн байдал, сумдаар

Ам бүлийн тоо	Гурвантэс	Ханбогд	Цогтцэций	Нийт
Насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай хүний тоо				
Байхгүй	-	-	1	1
1	1	1	1	3
2	10	15	10	35
3	1	1	3	5
4	4	1	1	6
Дундаж	2.50	2.11	2.44	2.35
Ажил эрхэлдэг орлоготой хүний тоо				
Байхгүй	5	6	4	15
1	6	9	6	21
2	5	3	6	14
Дундаж	1.45	1.25	1.50	1.41
Ажилгүй хүний тоо				
Байхгүй	11	6	10	27
1	2	6	4	12
2	3	5	2	10
3+	-	1	-	1
Дундаж	1.60	1.58	1.33	1.50
МАА-д байнга ажилладаг хүний тоо				
Байхгүй	3	5	6	14
1	7	5	7	19
2	5	8	3	16
3+	1	-	-	1
Дундаж	1.54	1.62	1.30	1.45
Өрхийн тоо	16	18	16	50

Судалгаанд оролцогчдын өгсөн мэдээллээс харахад, Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сумдын уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа болон нөлөөлөлд өртсөн өрхийн гишүүдийн хувьд малчин өрхөд насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай 2 хүн байхад, үүнээс нэг нь ямар нэгэн орлоготой ажил

эрхэлж, харин нэг нь ажилгүй байна. Хөдөөгийн малчин өрхүүдийн орлогын гол эх үүсвэр болсон МАА-н салбарт байнга ажиллаж буй хүн амын тоо төдийлөн өндөр биш байгаа нь судалгаанд хамрагдсан 50 өрхийн 14 нь МАА-д байнга ажилладаг хүн байхгүй гэжээ.

Жишээ 4.1

Манай нутаг МАК, Өмнийн говийн элс компанийн ашиглалтын лицензийн талбайд орсон. Мал маллах нөхцөлгүй болж байна. Нүүх ч газаргүй боллоо. Цэдэнгийн ус гэдэг газар буух нутаг, хүн мал уух усгүй болоод байна. Мал дордоод аргагүйн эрхэнд төв рүү орсон.

(Ганцаарчилсан ярилцлага, Гурвантэс сум, Урт багийн малчин)

Бэлчээрийн бүс нутагт уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа нь малын тооны бууралтад төдийгүй малчны тоо буурахад их нөлөөлж байна. Ер нь л уурхай, зуд хавсраад малын тоо эрс буурсан.

(Ганцаарчилсан ярилцлага, Гурвантэс сум, Удирдах ажилтан)

Малчин өрхийн тоо цөөрөхөд уул уурхайн үйл ажиллагаа нөлөөлж байгааг чанарын судалгаанд оролцсон малчид онцолж байлаа. Ханбогд, Цогтцэций сумын нутгийн иргэд уул уурхайн компанид ажил хөдөлмөр эрхлэх болсныг тогтмол орлоготой байх, уул уурхайн үйлдвэрлэлийн хөгжилтэй холбон тайлбарлах хандлагатай байгаа нь уул уурхайн компаниудын ажилтнуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын дүн харуулж байна.

Жишээ 4.2

Уул уурхайн хөгжлийг дагаад нутгийн залуучууд төв суурин газар бараадаж уурхайд ажиллаж байна. Нэгэнт уул уурхайд ажиллах хүсэлтэй байгаа хүмүүсийг малаа малла гэх нь утгагүй. Хуучин чинь малчин хүнийг ажилгүйд тооцдог байсан юм биш үү.

(Ганцаарчилсан ярилцлага, Энержи ресурс ХХК, ОНХХ-ийн ажилтан)

Малчид орлогоо бодож уул уурхайн компанид ажилд орж байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Оюу толгой ХХК-ийн ОНХХ-ийн ажилтан)

Уул уурхайд ажилд орж байгаа нь нэг талаараа сайн, нөгөө талаараа бэлчээрийн МАА-д сөрөг нөлөөтэй.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Сийрэст багийн малчин)

Судалгааны дүнгээс харахад, малчид уул уурхайд ажиллаж байгааг уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөгөөр мал маллаж амьжиргаагаа залгуулах аргагүй болсноор тайлбарлаж байхад уул уурхайн компанийн ажилтнууд уул уурхайн үйлдвэрлэлийн хөгжил, орлогын тогтмол эх үүсвэртэй болох гэсэн малчдын сонирхол хэрэгцээтэй холбон тайлбарлаж байна.

Хүснэгт 4.2. Уул уурхайн компанид ажил эрхэлж малчин өрхийн гишүүдийн тоо, сумдаар

Ам бүлийн тоо	Гурвантэс	Ханбогд	Цогтцэций	Нийт
Уул уурхайн салбарт ажиллаж байгаа хүний тоо				
Байхгүй	16	15	7	38
1	-	3	8	11
2	-	-	1	1
Өрхийн тоо	16	18	16	50

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд хамрагдсан 50 өрхөөс 12 хүн уул уурхайн компанид ажил эрхэлж байна. Жишээ нь Гурвантэс сумын нутаг дэвсгэр дээр МАК, Чинхуа МАК, Өмнийн говийн элс (South Gobi Sands) зэрэг томоохон нүүрсний компаниуд үйл ажиллагаа явуулдаг ч тус сумаас судалгаанд хамрагдсан 16 малчин өрхөөс эдгээр нэр дурдсан уул уурхайн компанид нэг ч хүн ажил эрхлээгүй байлаа. 2004 онд Чинхуа МАК, 2007 онд МАК компани Гурвантэс суманд нүүрс олборлож, эхэлснээс хойш сумын хүн амын тоо өдгөө 7000-д хүрсэн байхад, тус компанийн 401 ажилтны 48 нь Гурвантэс сумын харъяат иргэд байна. Орон нутгаас цөөн ажилчин авч байгаа шалтгааныг тэдний уул уурхайн үйлдвэрлэлд ажиллах мэргэжлийн ур чадвар хангалтгүйтэй холбон тайлбарласан нь орон нутгийн удирдлага, уул уурхайн компанийн удирдлагатай хийсэн бүлгийн ярилцлагын дүн харуулав.

Уул уурхайн салбарт орон нутгийн иргэдийг ажиллуулахад анхаарал хандуулах шаардлагатай зорилтот үйл ажиллагааны нэг нь орон нутгийн иргэдийн мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, МСҮТ-ийг бий болгох зэрэг арга хэмжээг төр засаг, салбарын яамд хамтран хэрэгжүүлэх хэрэгцээ тулгамдах шинжтэй болж байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компани, орон нутгийн захиргааны байгууллага уул уурхайн салбарт ажиллах мэргэжилтэй ажилчин бэлтгэх сургалтад малчин өрхийн гишүүдийг төдийлөн хамруулдаггүйг бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлагад оролцсон малчид тэмдэглэж байв. Уламжлалт бэлчээрийн МАА нь уул уурхайгаас улам бүр хараат болж байгаа малчдын хувьд амьжиргаагаа залгуулахын тулд уул уурхайн компанид ажиллах сонголтыг хийхээс аргагүй нөхцөл байдалтай болж байна.

Хөдөөгийн малчин өрхийн хувьд өрхийн орлого мал аж ахуйгаас ихээхэн хамааралтай, нийт орлогод МАА-аас олох орлогын хэмжээ голлох байр суурийг эзлэх хандлагатай байдаг. Судалгаагаар, малчин өрхүүдийн малын тоо толгойн мэдээллийг цуглуулсан ба багцалсан байдлаар Хүснэгт 4.3-т үзүүлэв.

Хүснэгт 4.3. Өрхийн малын тоо, сумаар

Малын тоо	Гурвантэс	Ханбогд	Цогтцэций	Нийт
100 хүртэл	8	3	10	21
101-300	6	10	5	21
300-500	-	5	1	6
501 ба түүнээс дээш	2	-	-	2
Өрхийн тоо	16	18	16	50
Дундаж малын тоо	281,2	211,5	107,9	200,7

Уул уурхайн нөлөөллийн бүсэд нутаглаж буй нийт өрхийн 42 хувь нь 100-аас доош, 42 хувь нь 101-300, 12 хувь нь 301-500, үлдсэн 4 хувь нь 500-аас дээш тооны малтай өрхүүд байна.

Малын тоог судалгаанд хамрагдсан 3 сумаар харьцуулан үзвэл, Гурвантэс сумын нөлөөллийн бүс дэх малчин өрхийн малын тоо Ханбогд, Цогтцэций сумтай харьцуулахад ойролцоогоор 2 дахин их байв. Гурвантэс сумаас судалгаанд хамрагдсан малчин өрхүүд хамгийн олондоо 2020, Ханбогд сумаас судалгаанд хамрагдсан малчин өрхүүд хамгийн олондоо 500, Цогтцэций сумаас судалгаанд хамрагдсан малчин өрхүүд хамгийн олондоо 374 малтай хэмээн мэдээлсэн нь дээрх дүгнэлтийг давхар баталгаажуулж байна. Гурвантэс сумтай харьцуулахад

Ханбогд, Цогтцэций сумын нөлөөллийн бүс дэх малчид уул уурхайн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөлөлд илүү өртөж байгааг судалгааны баримт харуулж байна.

Жишээ 4.3

Малчин өрх айл дунжаар 100 орчим малтай болсон, уурхайгаас өмнө захын айл 200-300 малтай байсан. Уул уурхайн сөрөг нөлөөнд хамгийн их хэлмэгддэг хүмүүс малчид. Тоос тортог ихтэй байна гээд түүхий эд нь гологддог. Малын үс нэл шороо, тоос тортог болсон. Мал, малын мах шинжилдэг лаборатори хэрэгтэй байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Багийн засаг дарга)

Хүмүүс МАА-гаа орхиж байна. Энэ жил манай баг 1370 ботго авсан, өмнөх жилтэй харьцуулахад өссөн ч, малаа өсгөх ямар ч бололцоогүй болсон. Малчид малаа мөнгө болгоё, тэмээ мал маллах аргагүй боллоо гэж байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Гавилууд багийн малчин)

Уул уурхайн үйл ажиллагаанаас болж МАА устаж алга болохгүй. Харин уламжлалт бэлчээрийн МАА-н хэлбэр нь арай өөр болох болов уу. Суурин хэлбэрт шилжих гэх мэтээр. Жишээ нь үхрийн ферм эрхэлж эхэлж байгаа малчин ч байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Оюу толгой ХХК-ийн ОНХХ-ийн ажилтан)

Судалгаанд хамрагдсан сумдын хувьд 2010 оны зуднаар малын тоо эрс буурсан, 2011 онд бага зэрэг өссөн гэсэн хариултыг малчид өгч байгаа ч малчид, орон нутгийн удирдлага уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр бэлчээр талхлагдан, ургамлын гарц муудаж, усны түвшин багасч байгаа нь малын тоо толгой, ашиг шимийн бууралтад дам байдлаар нөлөөлж байна гэж үзлээ. Ерөнхийдөө малчид, орон нутгийн удирлагын өгсөн мэдээллээр, анх уурхайн үйл ажиллагаа эхэлж байх үетэй харьцуулахад уул уурхайн нөлөөллийн бүсэд нутагладаг малчин өрхийн малын тоо толгой, ашиг шим буурсан хандлага ажиглагдаж байна. Түүнчлэн 2010 онд Оюу Толгойн захиалгаар Монголын бэлчээрийн менежментийн холбоо Ханбогд сумын малчдын дунд явуулсан санал асуулгын дүнгээр мал аж ахуйгаас хөндийрөх чиг хандлагатай байгааг үзүүлж байгаа боловч энэ үйл явц маш аажим явж байгааг тэмдэглэжээ¹.

Энэхүү судалгаагаар уул уурхайн нөлөөллийн бүсэд нутаглаж буй малчин өрхүүдийн мал аж ахуйн бус орлогын эх үүсвэрийг тодруулсныг дараах хүснэгтэд үзүүлэв. Малчин өрхүүд МАА, цалин, өрхийн жижиг бизнес зэргээс орлогоо бүрдүүлдэг байна. Эдгээрээс өрхийн орлогын дийлэнхийг бүрдүүлдэг, хамгийн гол эх үүсвэр аль нь болохыг авч үзвэл, нэгдүгээрт МАА-аас олох орлого, хоёрдугаарт, уул уурхайн компанид ажил эрхэлсний цалин хөлс тус тус орж байна.

Хүснэгт 4.4. Өрхийн мал аж ахуйн бус бусад орлогын эх үүсвэр

Мал аж ахуйн бус бусад орлогын эх үүсвэр	Хариулагчдын тоо	Хувь	Эрэмбэ
Дэлгүүр	5	10.0	II

¹ ОТ ХХК, БОННБУ, Газар ашиглалтын суурь үнэлгээ, 2012

Сүү, мах худалдсанаас олох орлого	4	8.0	III
Цайны газар	1	2.0	IV
Дугуй засварын газар	-	0.0	
Газар тариалан	1	2.0	V
Цалин \Уул уурхайн компани\	12	24.0	I
Уул уурхайн компанид мах, сүү, бусад хэрэгцээт зүйлс нийлүүлсний орлого	-	0.0	
Байхгүй	11	22.0	

Судалгаанд хамрагдсан малчид 100 хувь мал аж ахуйгаас олох орлого өрхийн орлогод гол байр суурь эзэлдэг гэж хариулсан ба 11 оролцогч мал аж ахуйгаас өөр орлогын эх үүсвэр байхгүй гэж хариулснаас харахад нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа малчин өрхүүдийн амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй хэвээр байгааг харуулж байна. Харин цалин нь өрхийн орлогын хоёрдахь ач холбогдолтой үзүүлэлт болж байгаа нь сүүлийн жилүүдэд малчин өрхийн гишүүд уул уурхайн ажиллах болсон нь нөлөөлж байгаа ажээ. Ялангуяа нөлөөллийн бүс дэх малчин өрхийн амьжиргаанд цалин нь мал аж ахуйн орлогын дараа орохуйц орлогын гол эх үүсвэр болсон нь Оюу толгой, Энержи ресурс ХХК-ууд нөлөөллийн бүсэд орсон малчин өрхийн нэг гишүүнийг байнгын ажлын байраар хангах дэмжлэгийн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой байна.


Жишээ 4.4

Манайх Оюу толгойн ХХК-ийн онгоцны буудал, гүний хоолойн шуудуу татах үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн айл. Манай хөгшин бид хоёр өнгөрсөн 3 дугаар сараас эхэлж нөлөөллийн бүсийн замын цэвэрлэгчээр ажиллаж байна. Би 380 ам долларын, эхнэр 300 ам долларын цалин авч байгаа.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Гавилууд багийн малчин)

Тухайлбал Оюу толгой ХХК нь Ханбогд сумын ЗДТГ-тай хамтран Оюу толгой ХХК-ийн Барилгын төслийн үйл ажиллагааны 11 нөлөөлөлд өртсөн тус сумын 89 малчин өрхийг тогтоож, эдгээр нөлөөлөлд өртсөн малчин өрхийн гишүүдэд 5-6 төрлийн дэмжлэг үзүүлж байгаагийн дотор байнгын ажлын байртай болох гэсэн сонголт орсныг ганцаарчилсан ярилцлагад оролцсон уул уурхайн компани, орон нутгийн удирдлагын төлөөлөл тэмдэглэж байв. Ханбогд, Цогтцэций сумын хувьд уул уурхайн нөлөөлөлд өвөлжөө, хаваржаа, зуслангийн бэлчээр нь орсон зарим малчин өрхийн гишүүдийг Оюу толгой, Энержи ресурс ХХК зам цэвэрлэгч, үйлчилгээний туслах ажилчин зэрэг ажлын байраар хангаж, сарын 300-500 мянган төгрөгөөр цалинжуулж байгаа нь цалин малчин өрхийн амьжиргааны эх үүсвэрт голлох байр суурь эзлэхэд нөлөөлжээ. Гэвч Ханбогд, Цогтцэций сумын уул уурхайн нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа малчид үе уламжлан нутаглаж ирсэн газар нутгаа хойч үедээ байгалийн унаган төрхөөр нь үлдээх нөхцөлгүй болсон, 4 улирлаар нүүх малын бэлчээргүй болж МАА-гаа эрхэлж чадахгүйд хүрч байгаатай харьцуулбал 300-500 мянган төгрөгний цалин өгч байгаа нь хангалтгүй хэмээн үзэж байгаа нь цөөн бус тохиолдож байлаа.

Уул уурхайн нөлөөллийн бүсэд нутаглаж буй айл өрхүүдийн өрхийн орлогын хүрэлцээг 44 хувь нь дунд зэрэг, 24 хувь нь тааруу, 24 хувь нь боломжийн, 6 хувь нь огт хүрэлцдэггүй, 2 хувь нь хангалттай сайн гэж хариулснаас үзвэл малчин өрхүүдийн орлого төдийлөн хүрэлцээтэй байж чадахгүй байгааг харуулж байна.




Судалгаанд хамрагдсан 3 малчин тутмын нэг нь өрхийн амьжиргааны түвшнээ дунд болон тааруу хэмээн үнэлжээ. Уул уурхайн салбар Монгол улсын эдийн засгийн голлох салбар болсон ч малчны амьжиргааны үндэс болсон МАА-д ихээхэн халгаатай байна. Ерөнхийдөө малчны амьжиргаа нь бэлчээр болон усны нөөцөөс шууд хараат учраас байгаль орчны доройтол нь малчдын хувьд хүндээр тусч байна. Малчидтай хийсэн ярилцлагын явцад ажлын байраар хангагдаж тогтмол цалин авч байгаа нь түр зуурын амь аргацаасан арга хэмжээ харин МАА-гаа эрхлэх нь бидний тогтвортой амьжиргаа гэж үзэх хандлага түгээмэл ажиглагдаж байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Ерөнхийдөө малын тоо, малчдын тоо аажмаар буурч, малчид МАА-гаас хөндийрөх чиг хандлагатай байгааг малчид уул уурхайн үйлдвэрлэлд бэлчээрийн МАА шахагдаж байгаагаар тайлбарласан бол харин уул уурхайн компанийн ажилтнууд уул уурхайн хөгжлийн нөлөөгөөр малчид мал аж ахуйгаас тогтмол цалинтай ажил, жижиг бизнес рүү шилжиж байгаагаар тайлбарлаж байгааг судалгааны дүн харуулж байна.

Хүний эрхийн төлөв байдал

Уул уурхайн нөлөөллийн бүсэд нутаглаж буй Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумаас судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 96 хувь нь уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөгөөр хүний эрх зөрчигдөж байгааг хүлээн зөвшөөрсөн хариулт өгчээ.



Хүснэгт дэх мэдээллээс харахад, байгалийн нөөцөөс шууд хамааралтай уламжлалт бэлчээрийн МАА эрхэлдэг Ханбогд, Цогтцэций сумаас судалгаанд хамрагдсан хоёр малчин тутмын нэг нь уул уурхайн үйл ажиллагаа хүний эрхийг маш ихээр зөрчиж байна гэж үзлээ.

Хүснэгт 4.5 Уул уурхайн үйл ажиллагааны улмаас Таны эрх хэр зэрэг зөрчигдөж байна вэ? (нөлөөллийн бүсэд нутагладаг малчдын өгсөн хариулт)

Сонгосон үзүүлэлтээр	Гурвантэс	Ханбогд	Цогтцэций	Нийт
Маш их зөрчигдөж байна	31.3	50.0	56.3	46.0
Зарим талаараа зөрчигдөж байна	43.8	50.0		42.0
Барга зөрчигддөггүй	18.8	0.0	31.3	8.0
Мэдэхгүй байна	6.3	0.0	6.3	4.0
Малчдын тоо	16	18	16	50

Судалгаанд оролцсон Гурвантэс сумын малчдын 75.1 хувь, судалгаанд оролцсон Ханбогд сумын малчид бүгд, судалгаанд оролцсон Цогтцэций сумын малчдын 87.6 хувь нь өөрсдийнхөө хүний эрх зөрчигдөж байгааг үйлдвэр, уурхайн тээврийн авто замын дагуу олон салаа зам гарч, тоосжилт ихсэж, малын бэлчээр, ус хомсдон, хуурайшиж хүн, мал амьдрах нөхцөлгүй болсонтой холбон тайлбарласан ба судалгааны төлбөрт мэдээлэл цуглуулах үеэр малчдын өгч байгаа тайлбар бодитой байсныг баталгаажуулж байлаа.

Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ нөлөөллийн бүсэд нутаглаж буй малчид эдэлж чадаж байгаа эсэхийг тодруулсан судалгааны үр дүнг Зураг 4.3-т үзүүлэв.



Судалгаанд хамрагдсан нөлөөллийн бүс дэх нийт малчдын 96 хувь нь Үндсэн хуулиар баталгаажсан эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс шалтгаалан зөрчигдөж байна гэж хариулсан нь бусад хүний эрхийн зөрчилтэй харьцуулахад хамгийн өндөр давтамжтай илэрчээ. Үүний дараагаар уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас

амьжиргааны гол эх үүсвэр болсон МАА-гаа эрхэлж чадахгүйд хүрч байгаа, хүний өдөр тутмын үндсэн хэрэглээ болсон цэвэр усаар хангагдах буюу амьдралын хүрэлцээтэй түвшинд амьдрах эрхээ эдэлж чадахгүйд хүрч байгаа, мал аж ахуйгаа эрхлэх гол хэрэгсэл болох өвөлжөө, хаваржааны газраа уул уурхайн лицензийн талбайд алдаж газар эзэмших эрхээ эдэлж чадахгүйд хүрч байна гэж нийт судалгаанд хамрагдсан малчдын талаас илүү хувь нь үзэж байна.

Хүснэгт 4.6 Уул уурхайн үйл ажиллагааны улмаас Үндсэн хуулиар олгогдсон эрхүүд зөрчигдөж байна гэж хариулсан малчдын эзлэх хувь

Сонгосон үзүүлэлтээр	Гурвантэс	Ханбогд	Цогтцэций	Нийт	Эрэмбэ
Амьд явах	6.3	38.9	12.5	20.0	VIII
Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх \МАА эрхлэх, цэвэр усаар хангагдах\	62.5	72.2	81.3	72.0	II
Эрүүл аюулгүй орчинд амьдрах	93.8	94.4	100.0	96.0	I
Эрүүл мэндээ хамгаалуулах	25.0	50.0	31.3	36.0	V
Оршин суух газраа чөлөөтэй сонгох	31.3	72.2	62.5	56.0	III
Газар эзэмших, ашиглах \өвөлжөө, хаваржааны газраа ашиглан МАА эрхлэх	62.5	66.7	37.5	56.0	III
Орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах	18.8	83.3	62.5	56.0	III
Шийдвэр гаргахад оролцох	31.3	66.5	18.8	40.0	IV
Саналаа хэлэх	12.5	66.7	18.8	34.0	VI
Мэдээлэл авах	18.8	38.9	18.8	26.0	VII
Малчдын тоо	16	18	16	50	

Уул уурхайн нөлөөллийн бүсэд нутаглаж буй Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумын малчдын Үндсэн хуулиар баталгаажсан амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, эрүүл аюулгүй орчинд аж төрөх, газар өмчлөх, оролцох, мэдээлэл авах эрхийн төлөв байдал, хэрэгжилтийг судалсан судалгааны үр дүнг танилцуулж байна.

4.2 Уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэхэд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө

ХАА-н салбарын 90 хувийг МАА эзэлдэг, дотоодын нийт бүтээгдэхүүний 30 орчим хувийг үйлдвэрлэдэг хөдөө аж ахуйн салбар, тэр дундаа ажиллах хүчний 30 орчим хувийг шингээдэг бэлчээрийн мал аж ахуйн салбарт сөрөг нөлөө аль хэдийнээ үзүүлээд эхэлснийг энэ чиглэлээр хийсэн олон судалгааны дүн харуулж байна. Хэдийгээр манай улс уул уурхайн салбараас олох орлого нь Монголын макро эдийн засагт үр өгөөжөө өгч их наядаар тоологдох хэмжээнд хүрсэн боловч бүс нутгийн байгаль орчин, уугуул иргэд, малчдын эрүүл мэнд, орлого, МАА-д хэр хэмжээний сөрөг үр дагавар, хор хохирол учруулж байгааг тооцох шаардлага бий болж байгааг судалгааны дүн харуулж байна. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсэд нүүдлийн МАА эрхлэхэд тохирсон экосистем, нүүдлийн МАА-н аж төрөх ёс, зан заншил, уламжлал доройтож үгүй болоход хүрвэл үүнийг их наядаар дахин сэргээх боломж байгаа эсэхэд төр засгийн бүх түвшинд анхаарлын гадна орхигдсоор байна.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактаас

“Аливаа ард түмнийг ямар ч тохиолдолд оршин тогтнох хэрэглүүрээс нь салгаж үл болно” Иргэд газар нутгаасаа аргагүйн эрхэнд шахагдан нүүх, хүчээр нүүлгэх, хөөн зайлуулах зэргээр халдашгүй байх эрх зөрчигдөх, эрхээ хамгаалах зорилгоор мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох эрх нь хаалттай, шударга шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх, зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэх эрхүүд мөн хангагдахгүй байна.

(ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, 2007)

Гурвантэс, Цогтцэций, Ханбогд суманд хийсэн судалгааны дүнгээс ерөнхийд нь дүгнэж үзвэл өнөөдөр уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр Цогтцэций, Ханбогд сумдад улалмжлалт бэлчээрийн МАА эрхлэхэд туйлын хүнд нөхцөл байдалтай байгаа нь ажиглагдаж байна. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр малчин хүний Үндсэн хуулиар баталгаажсан эрхүүд нь давхар зөрчигдөж байна. Малчин хүн өөрийн нутаг усандаа эзэн байх, уугуул нутаг усандаа 4 улирлаар мал аж ахуйгаа эрхлэх, өвөлжөө бууцаа эзэмших, хүн мал цэвэр усаар хангагдах, МАА-гаа эрхлэн амьжиргааны хүрэлцээтэй түвшинд аж төрөх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, МАА-гаа ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх эрх нь цаасан дээр үлдэж байгааг судалгааны дүн харуулж байна.

Жишээ 4.5

Хэдэн үеэрээ нутаглаж ирсэн газар нутаг дээрээ Монгол хүн явах ч эрхгүй болж байна. Дээрээс шийдвэр гарсан, энэ манай компанийн эзэмшил нутаг болсон гээд ухаад эхэлдэг. Уул уурхай байгаагүй байсан бол ус гол, бэлчээр, онгон байгаль, ан амьтан хэвээрээ байх байсан. Энэ сайхан нутаг ус, онгон байгаль, газар нутгаа хэзээ ч урьдын хуучин хэвээр нь бий болгож чадахгүй.

(Бүлгийн ярилцлага, Гурвантэс сумын малчид)

Судалгаанд хамрагдсан Гурвантэс сум, багийн удирдлагын өгсөн мэдээллээр нийт газар нутгийн 70 хувь нь хайгуул, ашиглалт олборлолтын лицензийн талбайд орсон, үлдсэн хувь нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт ордог багтдаг байна. Малчдын өгсөн мэдээллээр, уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр мал нь уух ус, бэлчих бэлчээр нутаггүй, нутгийн иргэд нь газар нутаг дээрээ малаа маллан чөлөөтэй хариулах, отор нүүдэл хийх эрхгүй болжээ.

Жишээ 4.6

Шинэ газар мал идээшихгүй асар их хугацаа орно, хөдөлмөр орно. Нутаглаж байсан газраас 4 километр байсан. Мал хуучин буурь руугаа гүйгээд тэр хооронд нь нааш цааш туусаар мал их зутардаг. Хашаа саравч, зуны сууц модон амбаар барьсан.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Цагаанхад багийн малчин)

Хоёрхон жишээнээс харахад уламжлалт бэлчээрийн МАА-н амин сүнс болсон бэлчээрийн даац, багтаамж уул уурхайн хор уршгаар хүрэлцээгүй болсныг илтгэж байна. Уул уурхайн нөлөөгөөр малчид малтайгаа уул уурхайд шахагдан олон жил нутагласан өвөлжөө бууц, газар нутгаа орхин нүүхэд хүрч байна. Эсвэл малаа цөөлөх, цөөрсөн хэдэн малаа айл дээр тавих гарцаагүй нөхцөлд байдалд уул уурхай оруулж байна гэж судалгаанд хамрагдсан малчид үзэж байна.

Жишээ 4.7

Оюутолгойн хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд 2011 онд өөрийн ашиглалтын зөвшөөрөлтэй талбайгаас гадна “Зэс баяжуулах үйлдвэр”-т хэрэглэх усыг 70 км газраас татах, ус дамжуулах шугамын барилга байгууламж барих, нисэх онгоцны буудал шинээр байгуулах, Оюутолгойн талбайгаас Хятад улсын хил хүртэл 220 квт-ын шугам татах, хилийн Гашуунсухайт боомт хүртэл 96 км хатуу хучилттай зам тавих зэрэг хөрөнгө оруулалтын зориулалтаар Ханбогд сумын нутагт ихээхэн хэмжээний газар ашиглах болсноор тус сумын малчдын малын бэлчээрийн талбайг багасгахад хүрч байна. Ханбогд, Цогтцэций сумдад малын бэлчээрийг хомсдоход нөлөөлж байгаа томоохон хүчин зүйлийн нэг нь сумдын нутгаар гарч байгаа улсын чанартай, олон салаа авто замын дагуу үүсч байгаа тоосжилт болж байна. Дээр нь эдгээр томоохон уул уурхайн компанийн туслах гүйцэтгэх гэрээт компанийн тээвэрлэлт, нүүрсний тээвэрлэлт гүйцэтгэж байгаа компаниуд гаргасан замаар бус малын бэлчээр бүхий газраар дураараа зам гаргаж байгаад малчид шүүмжлэлтэй хандаж байв.

(Эх сурвалж: ЗГХЭГ, Бүрэн эрхэт төлөөлөгчийн ажлын албаны жилийн тайлан, 2011)

Гүний хоолойгоо 3 м ухаад хаядаг. Мал ухсан нүх, суваг шуудууг мал мэдэж гарч чаддаггүй, хоригдоод байж байдаг. Малчин бид малаа гарцаар нь гаргахын тулд 4.5 км ухсан нүхийг нь дагаад гарам гарцыг нь хайгаад явдаг. Тэгж байтал өөдөөс машин давхиж ирээд мал үргээдэг. Одоо ч газар нутгаа ч танихаа байлаа. Манайх 200 гаруй бог малаа Цэций рүү явуулсан. Энэ чинь нутаг орноо орхиод нүүснээс ялгаа юу байхав дээ.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Баян багийн малчин)

Ханбогд, Цогтцэций сум нь тэмээ, бог малын бэлчээр зонхилсон бэлчээрийн МАА-н үйлдвэрлэлийн гол нутаг байсан бол чанарын судалгаагаар уул уурхайн нөлөөгөөр нийт бэлчээрийн 80 гаруй хувь нь талхлагдалд орж малын тоо толгой цөөрч, мал аж ахуй эрхэлдэг малчны тоо хүртэл цөөрснийг сум багийн удирдлага тэмдэглэж байв. Жишээ нь Цогтцэций сумын Цагаан-Овоо, Сийрэст багийн нийт малчдын тоо гуравны нэгээр цөөрснийг тус багийн засаг дарга нартай хийсэн ярилцлагын дүн харуулж байна.

Жишээ 4.8

Би 1971 оноос хойш мал малласан. Одоо 30 хүрэхгүй тооны малтай үлдсэн. Зуд, уул уурхай хоёр хавсарч малгүй болсон. Миний нутагладаг бууцны хажууд Энержи ресурс компани 1 км хүрэхгүй газарт ухсан. Миний өвөлжөө бууцыг авахын тулд компани өөрсдийн саналыг тулгасан. Одоо өвөлжөөгүй, усгүй болсон. Төрөлх нутгаасаа нүүж сум руу орохоос өөр аргагүй болсон. Одоо сумын төвд байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Сийрэст багийн малчин)

Энержи ресурс 60 жилээр эзэмшиж байгаа өвөлжөөний газар дээрээс бууц хороог дураараа нүүлгээд явсан. Малын бэлчээрээс дураараа карьерийн шороо авдаг. Энд хүний эрх гэж байна уу? Одоо мал маллах аргагүй болсон, өвөлжөө бууц, хороо ч байхгүй болсон. Ийм газар адуу мал ч тогтохгүй, дуу чимээ, тоос нөхцөлгүй, малаа услахын тулд 20-30 км газар явж усалдаг боллоо. Олон малтай байсан, одоо мал гэхээр юмгүй болоод цөөн хэдэн малаа \67\ айлд тавьсан.


(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Сийрэст багийн малчин)

Бүх малчидтай хүчээр нөлөөллийн бүс тогтоосон гэрээ хийсэн. 10 сая төгрөг аваад бэлчээр дуусч байна. Хэдэн саяар үнэлэх аргагүй бэлчээрийг хэдэн малчдын толгойг эргүүлж байгаад гарын үсэг зуруулдаг. Компани нөлөөллийн бүс тогтоох, нөхөн олговорын хэмжээг өөрсдөө тогтоодог, вант улс шиг дураараа загнадаг.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавхлант багийн малчин)

Судалгаагаар нүүдлийн МАА-н хэв шинжийг илэрхийлсэн малчдын нүүдэл хоорондын зайг уул уурхайн үйлдвэрлэл эхлэхээс өмнө болон уул уурхайн

үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрс эрчимжсэний дараа үетэй харьцуулан судлахад дараах үр дүн гарчээ.



Говийн малчид жилдээ олон удаа отор нүүдэг хийдэг мал маллагааны онцлог арга барилтай ард түмэн. Уул уурхайн үйлдвэрлэл эхлэхээс өмнө судалгаанд хамрагдсан малчид жилдээ дунджаар дор хаяж 4 удаа нүүдэллэдэг, хамгийн их нүүдэг малчин өрх жилдээ 14 удаа нүүдэллэж МАА эрхэлдэг байсан бол уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр нийт оролцогчдын 60 хувь нь нүүх нутаг бэлчээргүй болсон, жилдээ 1-2 удаа нүүвэл 4 улирлаар нүүсэнд тооцогдох ийм хэмжээнд хүрснийг судалгаа харуулж байна. Судалгааны мэдээлэл цуглуулах үеэр судалгаанд хамрагдсан зарим айлууд зуны дэлгэр цагаар өвөлжөөндөө сууж байгаа дүр зураг нийтлэг ажиглагдаж байсан ба энэ нь нийтээрээ ашигладаг уламжлалтай зуслан, намаржаа, хаваржаагаа уул уурхай компаниуд алдсан эсхүл ашиглахын аргагүй болтол нь талхалж машины зам гарсантай нь холбоотой байна. Мөнтүүнчлэн Оюу толгой төсөл-БОННБҮ-ийн тайлангийн баримт бичигт (2012) “аймаг, сумд оршин суудаг малчид улирлаар нүүх нь улам бүр цөөрч, төв суурин газар суурьших нь нэмэгдэж байна. Өнөөгийн байдлаар дунджаар, нийт малчдын зөвхөн 34 хувь нь отор нүүдэл хийж, нүүдэлчин хэв маягаа хадгалан амьдарч байна. Малчид жилдээ бэлчээр, усны хүртээмж болон чанарыг даган 3-5 удаа нүүдэллэдэг” гэж дүгнэснээс үзвэл 4 улирлаар бэлчээр сэлгэдэг бэлчээр ашиглалтын уламжлалт хуваарьт өөрчлөлт гарч байгааг харуулж байна.

Нүүдлийн ахуй соёлыг илэрхийлдэг, 4 улирлаар ус, бэлчээрийн соргогийг дагаж нүүдэг нүүдэлч уламжлалтай малчид уул уурхайн нөлөөгөөр хагас суурин маягаар МАА-гаа маллахад хүрснийг тоон болон чанарын судалгааны дүн харуулж байна. Хэрэв Цогтцэций сумын нутгаар нүүрс тээвэрлэх зорилгоор Төмөр зам тавигдвал тус суманд хөндөгдөөгүй үлдсэн бэлчээрийн газар сүйтгэгдэж МАА-н ирээдүй бүрхэг болно хэмээн олон хүмүүс үзэж байсныг тэмдэглэж байна.

Жишээ 4.9

Манайх уурхайгаас өмнө 30 гаруй адуу, 600 бог, 100 тэмээ, 20 үхэртэй байсан, одоо 100 бог, 30 тэмээтэй. Уул уурхай, зудаас болж мал үхэх нь үхэж, алдахыг нь алдаж, дайжиж үхэх нь үхсэн. Манай унагатай гүү зам гарах гэж байгаад эхтэйгээ дайрагдсан. Малын өвчлөл ихэссэн. Тоосноос болж малын нүд сохорч байна. Манайхыг орон нутгийн удирдлагатай нийлж хүчээр нүүлгэсэн. Хуучин нэг талдаа 10 км-т манай мал бэлчдэг, 4 км газарт усаа уучихдаг байсан. Одоо 3 айлын мал 5 км-т бэлчиж байна. Одоо 1 км газар тоосон дунд малаа услаад буцаагаад авчирч байна. Мал маллах аргагүй болсон, дээд зэргээр бэлчээр байхгүй боллоо. Малчид мал маллах аргагүй болоод ажлын байр гарч магадгүй гээд төв рүүгээ орж байна. Малчид үнэхээр хохирч байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавхлант багийн малчин)

Ханбогд сумын хувьд Оюу толгой төслийн барилгын ажлын нөлөөгөөр хоол хүнс, өргөн хэрэглээний бүтээгдэхүүнээ авах, малын түүхийн эдээ борлуулахын тулд хол явахад хүрч байгаа, мал маллах аргагүй болж сумын төв рүү суурин амьдрахад хүрч байгаа талаар тус сумын Жавхлант, Гавилууд багийн малчидтай хийсэн ярилцлагын дүн харуулж байлаа. Жишээ нь бүлгийн ярилцлагад хамрагдсан тус багийн малчид нутагладаг бууцандаа байх нөхцөлгүй болж сумын төв рүү нүүж орсон. Хар хадны бууц өвөлжөөнд мал маллах аргагүй болж идээшиж дассан бууцнаасаа 30 км-ийн зайд ус муутай газар руу нүүсэн \малчдын хэлсэн үгээр “дүрвэсэн”, өөрийн өвөлжөө хаваржаагаа ашиглах аргагүй болсон, Хар хаднаас 7-8 айл тоосноос нүүж дайжсан гэх зэрэг мэдээллийг өгч байсан нь уул уурхайн үйлдвэрлэл нь малчдын амьдралын хэв маяг, амьжиргаанд төдийгүй МАА эрхлэхэд нь хүртэл ямархуу нөлөө үзүүлж байгаа нь харагдаж байна.

Жишээ 4.10

Айлуудын намаржаа бүгд Оюу толгой нисэх онгоцны буудалд орсон. Энэ талаар нутгийн иргэдтэй огт зөвлөлдөөгүй, нэг мэдэхэд л Засгийн газраар батлуулаад ирсэн. Намаржаа онгоцны буудлын талбайд орсноос болоод бэлчээр шахсан, одоо олон айл нэг дор шавааралдаад зусч байна. Одоо нүүх газар байхгүй, хаашаа явахаа мэдэхгүй байна. Манайхны бууц бэлчээр ургамлын гарц сайн, зах зээлтэй ойр урагшаа боомт руу 10 км яваад хүнс хоолоо авдаг байсан бол одоо 40-50 км явж байж идэж уух зүйлээ авдаг болсон. Манай Жавхлантын айлууд 20 км яваад ирдэг байсан бол наагуур нь хаалт тор татснаас болж 60 км явж ирдэг болсон үүнд бид их бухимдаж байна. Хүний бухимдал, стрессийг үнэлдэг бол үнэлүүлмээр их бухимдаж байна.

(Бүлгийн ярилцлага, Ханбогд сум, Жавхлант, Гавилууд багийн малчид)

Хэдийгээр мал хувийн өмч, газар төрийн өмч боловч нүүдлийн МАА-н соёл уламжлал, зан заншил төрийн хамгаалтад байгаа тул энэ асуудалд уул уурхайн компаниас гадна төрийн оролцоо илт үгүйлэгдэж байгааг энэ удаагийн төдийгүй удаа дараагийн судалгааны үр дүн харуулж байгаа билээ. Судалгаанд хамрагдсан малчдын үзэж байгаагаар урьд өмнө нь гарч байгаагүй үзэгдлүүд гарч байгаад малчид нэлээн эмзэглэж хандаж байгаа билээ. Тухайлбал чанарын судалгаанд хамрагдсан малчид нэг л мэдэхэд бууцыг нь тойруулаад ухах, бууц, малын бэлчээрээс нь карьерийн шороо авах, харж байхад нь сайр, уул толгодыг ухах төнхөх, хаваржаа намаржаа, зуслангийн хажууд нь өрөмдлөг хийх, усны эх, судсан дээр нь өрөмдлөг хийх зэргээр газар дэлхий, уул усаа шүтэж амьдардаг малчид, нутгийн иргэдийг бухимдуулсан бусармаг үйлдлүүдийг хийж байгаад дургүйцэж байлаа. Дээр нь суурин газрын хүн амыг бодвол малаа хариулан амгалан тайван амьдарч байсан малчдыг давхар сэтгэл зүйн дарамт нэрмэж байна.

Жишээ 4.11

Уугуул нутагтаа тайван байхаа больсон. Нүүрсээ баяжуулж байна гээд шатааж байна гээд бөөн утаа гаргадаг. Нүүрсээ ачиж, буулгаж, тээвэрлэж байна гээд бөөн тоос. Нутгаа солихоос өөр аргагүй байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Сийрэст багийн малчин)



Дээрх зурагт харуулсан судалгааны дүнгээр, уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр бэлчээрийн МАА-д бий болсон сөрөг нөлөөллийг харуулсан ба бэлчээрийн МАА эрхлэхэд хамгийн түрүүнд малын бэлчээр хомсдсон нь хамгийн их сөрөг нөлөө үзүүлж байна гэж нийт судалгаанд оролцогчид бүгд үзсэн бол хоёрдахь шалтгаанд ундны болон мал уух усгүй болсон гэж 98 хувь нь, гуравдахь шалтгаан нь хүн, мал, бэлчээр тоос түйрэнд нэрвэгдсэн гэж 90 хувь нь тус тус үзсэн ба эдгээр нь МАА эрхлэхэд хамгийн их сөрөг нөлөө үзүүлж буй эхний гурван шалтгааны тоонд орж байна. Үүний дараагаар нийт судалгаанд хамрагдсан малчдын 88 хувь нь уул уурхайн сөрөг нөлөөллийн улмаас нүүх нутаггүй, бэлчээргүй болсон гэж үзсэн өндөр хувийг эзэлж байна.

Чанарын судалгааны дүнгээр, уул уурхайн компаниудад зун, намар, хаврын бэлчээрээ үндсэндээ алдаж, өвөлжөөний газартайгаа үлдэж байгаа нь нийтлэг ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл уул уурхайн компаниуд зуслан, намаржаа, хаваржааны бэлчээр зэрэг малчдын уламжлалт хэлбэрээр нийт дундаа ашигладаг бэлчээр нутагт нь илүүтэй халдаж байгаа юм.

Жишээ 4.12

Хүнд даацын машин бэлчээр сүйтгэж тоосжилт их, бут ургамал мал идэхийн эцэсгүй болсон. Бэлчээрээ алдаж байгаа тул уул уурхайгаас хожиж байгаа юм алга. Уул уурхай сум орон нутгийг хөгжүүлээд байгаа ч юм алга.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Цагаан-Овоо багийн малчин)

50 жилийн дараа уурхай хаагдана. Малгүй хүмүүс хоосон нүхтэй үлдэнэ. Тэр үед малгүй, МАА байхгүй. Бидний хойч ирээдүй ажилгүй амьдралгүй хүмүүс үлдэнэ. Бидэнд дэвжиж байгаа юм алга, эрүүл байсан хүн, мал өвчтэй болж байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Гавилууд багийн малчин)

Матриц 4.1 Уул уурхайн үйл ажиллагааны бэлчээрийн МАА эрхлэхэд үзүүлж нөлөө

Гурвантэс	Ханбогд	Цогтцэций
- Мал ханиад өвчнөөр түгээмэл өвдөх болсон	- Бэлчээргүй болсон тул уламжлалт МАА эрхлэх боломжгүй болж байна.	- Малын өвчлөл газар авсан Бэлчээрийн даацгүй болж МАА эрхлэх аргагүй болсон
- Усгүй, бэлчээрийн газаргүй болсон .	- Мал уурхайн ухсан нүх, суваг шуудууг давж гарч чадалгүй унаж үхэх нь түгээмэл болсон	- Өөрийн эзэмшлийн бууцандаа буух боломжгүй болсон
- Улаан тоосонд МАА эрхлэхийн аргагүй нөхцөлд байна.	- Онгоцны буудал, гүний хоолой, шугам татах хоолойн хавийн малын бэлчээр байхгүй болсон	- Өвөлжөөгөө орхиж дайжиж нүүсэн
- Зуслан цөлжөөд өвөлжөөндөө зусдаг болсон	- Дуу чимээ, тоос түйрэнд мал, хүнгүй амьдрах аргагүй болсон	- Тоос түйрэн нийт нутгийг хамарч мал хүн байхын эцэсгүй байдалд орсон бэлчээргүй болсон
- Ургамлын төрөл зүйл хомсдсон, хөрс талхлагдсан	- Нүүх нутаггүй болсон	- Гүний усгүй болсон
- Мал бэлчих газаргүй болсон	- Өвөлжөө бууцаа хэрэглэх боломжгүй болсон	- Бэлчээрийн МАА эрхлэх аргагүй болсон
- Буух, нүүх нутаггүй болж мал маллах аргагүй болсон	- Ус хомсдож байгаль орчин сүйрч байна.	- Говийн модлог ургамал ургахаа больсон
- Малын бэлчээр МАК, Өмнийн говийн элс ХХК-ийн талбайд орж талхлагдсан	- Хүнд даацын машин тэрэг бэлчээрийг талхалж дууссан	- Тоосжилтын нөлөөгөөр говийн ургамал хөрс доройтсон
- Бэлчээрийг нүүрс тээвэрлэлтийн хүнд даацын машин талхалж замбараагүй зам гаргасан	- Зуслангийн газар өндөр хүчдлийн газарт орж зуслангүй болсон	- Өвөлжөө бууцны хажууд өрөмдөж, ухсан
	- Бэлчээргүй, усгүй, ургамалгүй МАА эрхлэх аргагүй болсон	- Бэлчээр усгүй болоод мал цөөрсөн
	- Малын өвчин ихэссэн	- Малгүй болсон
	- Мал маллахад хүнд болсон \малын хулгай\	- Өвөлжөө, хаваржаа намаржаа зуслангаасаа дайжсан
		- Байгаль орчинд үзүүлж сөрөг нөлөөнөөс болж бэлчээрийн мал маллахад хүнд болсон, уламжлал алдагдаж байна.

Эх сурвалж: Чанарын судалгааны үр дүн

Жишээ 4.13

Зуслангүй болсон. Өвс ногоо ургахаа ч байсан. Нүүх газар нутаггүй болсон. Мал олон байх нөхцөлгүй болсон.

(Ганцаарчилсан ярилцлага, Гурвантэс сум, Урт багийн малчин)

Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа малчид үе уламжлаж өдий хүрч ирсэн уламжлалт бэлчээрийн мал аж ахуйгаа эрхлэн хөгжүүлж, ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээдэг ховор түүх, соёл уламжлалд сөрөг үр дагавраа үзүүлж байгааг тоон болон чанарын судалгаагаар ажиглагдлаа.

Уул уурхайн үйл ажиллагааны уламжлалт бэлчээрийн МАА-д учруулж буй сөрөг үр дагаврын талаар сум, аймаг, үндэсний хэмжээнд хангалттай мэдээлэгддэг ч үүний мөрөөр хэрэгжүүлж буй арга хэмжээ байхгүй байгааг судалгаанд оролцогч талууд хэлж байлаа. Цаашид байдал энэ хэвээр үргэлжлэх үү, эсвэл сөрөг нөлөөллийг бууруулахад төр, мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллага, иргэд, олон

улсын байгууллага ямар хэлбэрээр оролцох вэ гэдэг тулгамдсан асуудал болж байгааг анхаарах шаардлагатай болж байна.

Жишээ 4.14

Малчдын зуны бэлчээр нь тэдний нутгийн харъяалал, өвөлжөөний газар нь хаана байдгаас үл хамааран тусгайлан нутаг заагаагүй, бүгдэд ижил тэгш нээлттэй байна. Хавар, зуны бэлчээр нутаг болон ус, хужиртай газрууд нь ямагт нийтэд нээлттэй байдаг. Сум, багийн Засаг дарга нар хуулийн энэ нөхцөл, заалтыг хэрэгжүүлж, улирлын чанартай нүүдэл суудал хийх боломжийг хангаж өгөх үүрэгтэй боловч тэдний зөвхөн цөөн хэсэг нь энэхүү эрх, үүргээ ухамсарладаг.

Эх сурвалж: ОТ ХХК, БОННБУ, 2012

Байгаль орчинд учирч байгаа шууд болон шууд бус хор хохирлыг тооцож үнэлдэгтэй \тусгай аргачлал\ адил бэлчээрийн газрын хохирлын эдийн засгийн үнэлгээ хийх, бэлчээрийн газрын алдагдлаас үүдэлтэй амьжиргааны түвшний үнэлгээ хийх, хүний эрүүл мэнд, малын эрүүл мэндэд үзүүлж байгаа хохирлын үнэлгээг хийж, аль болохоор бодит хохирлыг тооцон буруутай этгээд, байгууллагаар нь нөхөн төлүүлэх, урт хугацааны хохиролд тэтгэмж олгох асуудлыг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэхгүйгээр байдал дээрдэхгүй нь ойлгомжтой байна.

Малчдын өгсөн хариултаас харахад тэдний хувьд хамгийн их сэтгэл эмзэглүүлсэн асуудал нь уул уурхайн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөгөөр өсөж төрсөн нутагтаа эцэг эхээс өвлүүлж өгсөн өвөлжөө бууцандаа малаа маллан тайван амьдрах ямар ч аргагүй болсон хэмээн үзэж байна.

Өрнөдийн судлаачдын дунд “Монголын нүүдлийн соёл иргэншил төгсөх үү” сэдвээр явагдаж байгаа дискурс уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж байгаа Цогтцэций, Ханбогд, Гурвантэс суманд биелэлээ олох нөхцөл бүрджээ гэж үзвэл хэтрүүлэг болохгүй бизээ.

Судалгаанд хамрагдсан малчдын өгсөн мэдээллээр наад тал нь 5-10 жил, цаад тал нь 30-40 жилийн дараа байдал энэ янзаараа үргэлжилвэл говь нутаг уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөгөөр ус, бэлчээргүй болж, нүүдлийн МАА эрхлэх боломжгүй болно гэж үзэж байгааг судалгааны баримтууд харууллаа.

4.3 Нөлөөллийн бүсэд оршин суугаа малчдын газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхэд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.3-т: “Хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”, 16.18-д “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхтэй” гэж заасан ч уул уурхайн үйлдвэрлэлийн бүс нутагт нутаглаж байгаа орон нутгийн иргэдийн хувьд Үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөө хэрэгжихгүй байна. Үүний нэг жишээ нь уурхайн нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа малчин өрх Үндсэн хуулиар олгогдсон газар эзэмших эрхээ эдэлж чадахгүйд хүрч улмаар үе уламжлан нутаглаж ирсэн өвөлжөө бууцаа орхин нүүхээс аргагүй нөхцөл байдалд хүрч байгааг судалгааны баримтууд харуулж байна.

Малчны өвөлжөө нь өвөг дээдсээсээ өвөлж авсан орон гэр бөгөөд үр хүүхэддээ өвлүүлэх үндсэн хөрөнгө юм. Үр удамдаа өвлүүлэх нүүдлийн мал маллах бизнес ба үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг тооцолгүй зайлүүлснаас амьжиргаагүй, өвлүүлэх хөрөнгөгүй, нүүдлийн мал маллагааны соёлоо өв залгамжлуулах боломжгүй болсон өрхийн тоо өссөөр байна²

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 92 хувь нь уул уурхайн нөлөөллийн бүсэд орсон гэж хариулснаас Ханбогд сумын судалгаанд хамрагдсан малчид бүгд, Гурвантэс, Цогтцэций сумдын малчдын 87.5 хувь нь тус тус уурхайн нөлөөллийн бүсэд оржээ. Орон нутгийн удирдлага, малчид жилээс жилд нөлөөллийн бүсэд орж байгаа малчдын тоо өсч байна гэсэн мэдээлэлтэй байгаагаас үзвэл уул уурхайн үйлдвэрлэлийн цар хүрээ улам бүр тэлж, тэр хэмжээгээр бэлчээрийн МАА уул уурхайн нөлөөгөөр шахагдаж байна.

Жишээ 4.15

Гурвантэс суманд МАК, Чинхуа МАК, Өмнийн говийн элс, Зэлмэ, Жавхлант орд нүүрсний компанийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн 50 өрх, нөлөөлөлд өртөх магадлалтай 60 өрх, Ханбогд суманд Оюу толгой төслийн гүний хоолой, нисэх онгоцны буудал, цахилгаан дамжуулах шугам хоолой татах үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн 89 өрх, Цогтцэций суманд Энержи ресурс компанийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн 54 өрх байна. Түүнчлэн Цогтцэций суманд нүүрс олборлодог компаниудаас гадна нүүрс тээвэрлэдэг 50 гаруй компани үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр уул уурхайн компани болон уул уурхайн туслан гүйцэтгэх компаниудын үйл ажиллагааны нөлөөлөлд орсон малчдын тоог тооцож гаргаагүй байна. Нүүрс олборлодог, тээвэрлэдэг компани, гэрээт компаниудын зарим нь орон нутгийн зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, түр кемп барих, усны хайгуул хийх, өрөм тавих, түр зам гаргах, голын хайрга чулуу авах зэргээр түгээмэл тархацтай байгалийн ашигт малтмал ашиглах, карьер шуудуу ухах явдал түгээмэл ажиглагдаж байна. Хууль бус үйлдэлд хяналт тавих, хариуцлага тооцох зэргээр арга хэмжээ авч байгаа ч төдийлөн үр дүнд хүрэхгүй, орон нутгийн захиргааны байгууллагын эрх мэдлээс дээгүүр түвшинд зохицуулагдаж байгааг орон нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл тэмдэглэж байв.

(Судлаачийн ажиглалт)

Хүснэгт 4.7 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсэд орсон малчдын тоо

Малын тоо	Нийт судалгаанд хамрагдсан малчны тоо	Уурхайн нөлөөллийн бүсэд орсон малчны тоо
Гурвантэс	16	14
Ханбогд	18	18
Цогтцэций	16	14
Бүгд	50	46

Судалгаагаар нөлөөллийн бүс дэх малчин өрхийн газар эзэмших эрхийн хэрэгжилтийг судалж үзэхэд судалгаанд хамрагдсан малчин өрхийн дийлэнх нь буюу 96 хувь нь өөрийн эзэмшлийн өвөлжөөний газартай гэж хариулснаас 92 хувь нь өвөлжөөгөө цагаан гэрчилгээрээр эзэмшсэн, 22 хувь нь хаваржаагаа мөн цагаан гэрчилгээгээр эзэмшсэн байлаа. Харин судалгаанд оролцогчдын дийлэнх нь хаваржаа, намаржаа, зуслангийн газраа нийтийн эзэмшлийн зориулалтаар дундаа ашиглаж байна. Малчдын дунд өвөлжөө, хаваржааны газраа цагаан гэрчилгээгээр

² Байгаль орчин-уул уурхай - хүний эрхийн төлөв байдал, Монголын төрийн бус байгууллагын форум

60 жилээр эзэмшиж буй энэхүү хэлбэрээ өмчилсөн хэмээн ойлгож буй хандлага ч тодорхой хэмжээгээр ажиглагдаж байсан болно.

Хүснэгт 4.8 Өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн газраа эзэмшсэн гэж хариулсан малчдын эзлэх хувийн жин, сумдаар

	Гурвантэс	Ханбогд	Цогтцэций	Нийт
Өвөлжөө	100.0	100.0	75.0	92.0
Хаваржаа	6.3	50.0	6.3	22.0
Намаржаа	6.3	0.0	0.0	2.0
Зуслан	0.0	0.0	0.0	0.0
Өрхийн тоо	16	18	16	50

Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд нийт судалгаанд хамрагдсан нөлөөллийн бүс дэх малчдын 76 хувь нь аймаг, сумын төвд 0.5 га газар өмчилж авсан гэж хариулсан бол 23 хувь нь өмчилж аваагүй байсан ба ингэж хариулагчдын дотор Цогтцэций, Гурвантэс сумын судалгаанд оролцсон малчдын эзлэх хувь хэмжээ түлхүү байлаа. Ханбогд, Гурвантэс сумтай харьцуулахад Цогтцэций сумын нутаг дэвсгэрийн 50 гаруй хувийг нүүрсний ашиглалтын зөвшөөрөлтэй талбай эзэлж байгаа ба Цагаан-Овоо, Сийрэст багийн нутаг дэвсгэрийн 60-70 хувь нь мөн ашиглалтын лицензийн талбайд орсноор орон нутгийн малчид Үндсэн хуулиар олгогдсон газар эзэмших, өмчлөх, ашиглах эрхээ хэрэгжүүлэх аргагүй нөхцөл байдалд хүрчээ. Энэ талаарх мэдээллүүд ч чанарын судалгааны явцад түгээмэл дурьдагдаж байлаа.

Жишээ 4.16

Энэ хавийн айлууд намаржааны бэлчээргүй болсон. Бэлчээр их шахагдаж байна. Олон айлыг нэг дор шахсан. Нүүх ч газаргүй, тойроод айлууд байна. Арга хэмжээ авч байна гээд хэдэн цаас өгөөд амыг нь таглаж байна.

(Бүлгийн ярилцлага, Ханбогд сум, Жавхлант багийн малчид)

Манай өвөлжөөгүй болсон. Хаваржаа, намаржаа, зуслангийн бэлчээр лицензийн талбайд орсон. Өвөлжөөг хүчээр аваагүй ч өөрсдийн саналаа тулгасан, түүнийг нь хүлээж авсан. Нэг удаа нөхөн олговор авсан

(Бүлгийн ярилцлага, Цогтцэций сум, Сийрэст багийн малчин)

Тоон судалгаагаар дээрх мэдээллийг бататгах зорилгоор “Таны өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн газар уул уурхайн ашиглалтын лицензийн талбайд орсон уу?” гэсэн асуултаар авч үзсэн юм. Уг асуултанд хариулт өгсөн 50 малчны 34 нь буюу 62 хувь нь өвөлжөөний газар лицензийн талбайд орсон, 31 нь буюу 50 хувь нь зуслангийн газар лицензийн талбайд орсон, 25 нь буюу 56 хувь нь намаржааны газар лицензийн талбайд орсон, 28 нь буюу 46 хувь нь хаваржааны газар лицензийн талбайд орсон гэж хариулжээ.



Судалгаагаар анхаарал татсан үр дүн гарсан нь судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 46 малчин өвөлжөөний газраа албан ёсоор эзэмшсэн гэрчилгээтэй гэж хариулсан малчдын 30 нь өөрийн эзэмшлийн өвөлжөөний газраа лицензийн талбайд орсон гэж хариулсан нь нөлөөллийн бүс дэх орон нутгийн иргэдийн газар эзэмших эрх бодит байдалд хэрэгжихгүй байгааг харуулж байна. Жишээлбэл, Гурвантэс сумын судалгаанд оролцсон 16 малчин зохих хуулийн дагуу өвөлжөөний газраа 60 жилээр эзэмшсэн байхад уул уурхайн компанийн ашиглалтын лицензийн талбайд 13 малчны эзэмшлийн өвөлжөө бууц, хонд орсон байх жишээтэй ийм дүр зураг ажиглагдаж байна. Судалгааны дүнгээс харахад өвөлжөөний газраа 60 жилийн хугацаагаар эзэмших гэрээ байгуулсан Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумын 46 малчны дийлэнх нь буюу 65 хувь нь албан ёсоор эзэмшиж буй газар уул уурхайн компанийн эзэмшил газар гэж хариулжээ. Уул уурхайн компанид газраа алдсан малчдын дийлэнх нь уул уурхайн компани малчдын санал, шийдвэрийг харгалздаггүй гэсэн мэдээллийг өгч байсан ба энэ асуудлаар компани, малчдын хооронд маргаантай асуудал өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байна.

Судалгаагаар уул уурхайн компани дараах байдлаар орон нутгийн иргэдийн газар өмчлөх эрхэд шууд болон шууд бусаар халдахад дараах хүчин зүйл нөлөөлж байгааг чанарын судалгааны дүн, жишээ баримтад тулгуурлан багцлан харуулж байна.

1. Уул уурхайн болон уул уурхайн дэд бүтэц, барилга байгууламж барих,

Жишээ 4.17

Нутгийнханд алдаршсан 5 толгой гэж газар бий. Одоо гурвыг нь Оюу толгой онгоцны буудал хийнэ гэж буулгаад ухаад хоёр гүнзгий нүх хонхрууд болгосон. Оюу толгой манай багийн тэмээний бэлчээрийн нутаг байсан 5 километр газрыг бас хашаад авсан. Талхалсан газраа техникийн нөхөн сэргээлт хийж байна гээд тариан талбай шиг хагалаад хаячихсан.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавхлант багийн малчин)

60 жилээр эзэмшиж байгаа өвөлжөөний газар дээрээс хороо бууцыг хүчээр нүүлгэсэн. Ноднин малын бэлчээрээс карьерийн шороо авсан. Өвөлжөө хороо, газар нутаггүй болсон тул хаа л боломжтой газраа очдог ч адуу мал тогтохгүй байна. Мал бэлчээх газар нэг талдаа болсон.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Сийрэст багийн малчин)

- Уул уурхайн компани нөлөөллийн бүс тогтоож, нөлөөллийн бүсэд багтсан орон нутгийн иргэдэд нөхөн төлбөр, нийгмийн хөтөлбөрийг санал болгож тохиролцсноор өвөлжөө, бууцыг нь авах,

Жишээ 4.18

Манай компани нөлөөллийн бүсээ сунгасан. Нөлөөллийн бүсийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг гаргаж анх удаа тогтоосон. Уг нь Засгийн газрын хийх ёстой ажил байдаг, гэтэл хийх ёстой ажлаа хийдэггүй.

(Ганцаарчилсан ярилцлага, Оюу толгой ХХК-ийн ОНХХ-ийн ажилтан)

Оюу толгой өөрөө нөлөөллийн километрийг тогтоодог, төр засаг тогтоогоогүй. Нөлөөлөлд өртсөн айлууд нь бүрэн гүйцэт ороогүй. Жишээ нь манай Баян багт нөлөөлөлд орохоор 3-4 айл орхигдсон байгаа.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сумын Баян багийн Засаг дарга)

Нөлөөллийн бүсийн айлуудаа үнэн зөв тогтоогоогүй.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сумын Жавхлант багийн малчин)

- Уул уурхайн компани малчид болон орон нутгийн удирдлагатай хэлцэл тохиролцоо хийхгүйгээр малчны өвөлжөө бууц, хаваржаа, намаржаа, зуслангийн газарт үйлдвэр, уурхайн зориулалтаар карьер ухах, зам гаргах, ус татах зэргээр өвөлжөө бууцаа ашиглах нөхцөлгүй болгож улмаар дайжиж дүрвэх нөхцөл байдалд хүргэх,

Жишээ 4.19

Манай бууцыг тойроод 10-аад цооног байгаа, цооног бүрийн хооронд зам өндөр хүчдэл, гүний хоолой явж байгаа тул айл байхын эцэсгүй маш хүнд байна. Анх ийм үйл ажиллагаа явуулах гэж байгаагаа хэлээгүй гэтэл гэнэт кемп бариад ухаад эхэлсэн. Одоо болохоор Оюу толгой ХХК-ийн ОНХХ-ийн ажилтныг уулзуулсан гэдэг. 2011 оны 4-р сараас эхэлсэн хайгуул нь үргэлжилж байна. 2005 онд анх цооногоо ухаж эхэлсэн, нэг хэсэг хугацаанд орхисон байж байгаад одоо ухаад эхэлсэн. Газар дээрээ тоос нөхцөлгүй их. Мал ч байх ч арга алга.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавхлант багийн малчин)

- Нийтийн эзэмшлийн газар хувьчлагдаагүй гэх мэт Монгол улсын хууль эрх зүйн орчны сул талыг ашиглан иргэний өмчлөх, эзэмших, ашиглах эрхэнд халдах,

Жишээ 4.20

Хайгуулынхан тахилгатай овоон дээр машинтай явдаг, нэг л өглөө ухаад сэндийлсэн байдаг. Уулзахаар орон нутгаас эсвэл дээрээс (АМГ) зөвшөөрсөн гээд тамгатай бичиг үзүүлдэг. Монголын газар нутаг дарга нарын тамгатай бичгээр зүйл дуусч байна даа. Мал аж ахуй алга болох нь

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Гавилууд багийн малчин)

Уул уурхайн компани гэрийн хаяанд өрөмддөг. Хэлэхээр та нар дуугүй бай, энэ газар төрийн өмч гэж хэлдэг.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Гавилууд багийн малчин)

Малчид хэдэн үеэрээ өвөлжиж ирсэн бэлчээр гэдэг, гэтэл нийтийн өмч байдаг.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сумын Засаг даргын орлогч)

Хэдийгээр малчид өвөлжөө бууцаа хэдэн үеэрээ нутаглаж ирсэн миний өмч гэж ойлгодог ч өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн зориулалтаар эзэмшиж буй газар нийтийн өмч байгаа явдал нь уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байгаа бүс нутагт малчид газар эзэмших, өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд саад болж

байна. Зарим уул уурхайн компани малчдын намаржаа, хаваржаа, зуслангийн газар нийтийн өмч байгааг далимдуулан тэдний газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхэд халдах нь ердийн үзэгдэл болсныг дээрх жишээ баримт харуулж байна.

5. Орон нутгийн иргэдийн хууль эрх зүйн мэдлэг сул байдлыг ашиглах,

Жишээ 4.21

10 малчин нөлөөллийн шууд бүсэд орсон нөхөн олговор, хохирлыг нь барагдуулах ажил хийгээгүй. Өвдвөл эмчилгээ хийлгэнэ холбоотой байна, онгоцоор явуулна гэх мэтээр өвөлжөөг нь авчихсан. Одоо өвөлжөөг нь авсны дараа хаясан. Миний мэдэхийн 2-3 айлын амьдрал ахуй доройтож, гэр бүлийн гишүүд нь сэтгэл санаагаар унасан.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Цагаан-Овоо багийн малчин)

6. Засгийн газар, УИХ зэрэг төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэрээр уул уурхайн үйлдвэрлэлийн бүс дэх сум орон нутагт иргэдэд газар олгохыг түр хугацаагаар хориглосон шийдвэр гаргах,

Иргэдийн өмчлөх, эзэмших, ашиглах эрхэд халдаж байгаагийн нэг жишээ нь Засгийн газрын тогтоолоор Ханбогд, Цогтцэций сумдын төвийн иргэдэд хэрэглээний эдэлбэр газрыг улсын тусгай хэрэгцээнд авч тус сумын иргэд иргэдэд газар олгохгүй байгаад иргэд гомдоллож байсан бөгөөд уул уурхайн компанийн эзэд, Улаанбаатар хотоос үйлдвэр худалдаа эрхлэхээр нүүж ирсэн явуулын иргэдэд газар чөлөөтэй олгодог атлаа уугуул орон нутгийн иргэдэд газар олгохгүй байгаад шүүмжлэлтэй хандаж байгааг бүлгийн ярилцлагын дүн харуулж байв. Нийтийн эзэмшлийн газрыг эзэмших, ашиглах, өмчлөх шийдвэр гаргахдаа тухайн орон нутгийн иргэдийн саналыг авах, саналыг шийдвэр гаргахад харгалзаж үзэх тухай заалт байдаг ч бодит байдалд хэрэгжихгүй байгааг дээрх тохиолдол илэрхийлж байна.

Жишээ 4.22

Нутгийн уугуул иргэд газраа авч чадахгүй байна. Иргэддээ газар эзэмшүүлж ашиглуулдаггүй байж гадны иргэд, том компанийн захирал, баячууд, Таван толгойн захирлуудад морины жүчээний газрыг хэдэн га-гаар нь өгдөг. Нутгийн иргэд бидэнд газар эзэмших эрх байхгүй байна. Үйлдвэр үйлчилгээ эрхлэх, ногоо тарья гэсэн хүмүүс зөндөө байдаг. Газар олдохгүй байна. Нутгийн иргэдэд цахилгаангүй эзгүй газар өгдөг. Газар эзэмшил, өмчлөлийн асуудалд хяналт байхгүй, орон нутгийн удирдлага нь иргэнийхээ эрх ашгаас илүү уул уурхайн компанитай ойр ажилладаг, Жишээ нь гэхэд 4-5 хүнд арваад га газар хашаалаад өгчихсөн энүүхэн хойно байгааг та нар харж болно.

(Бүлгийн ярилцлага, Цогтцэций сум, Багийн засаг дарга)

Дээрх жишээнд харуулсантай төстэй жишээ баримтуудыг Цогтцэций сумын төвийн иргэд, малчид хүртэл олныг дурьдаж байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Цогтцэций, Ханбогд сумд ялангуяа Цогтцэций суманд жилээс жилд нүүрсний олборлолт нэмэгдэж байгаатай холбоотойгоор хайгуул болон ашиглалтын лицензийн талбайн хэмжээ нэмэгдэж байгаа, ирээдүйд нүүрсний олборлолтыг дагасан төмөр зам, авто зам, цахилгаан станц, үйлдвэрүүд ажиллаж эхлэхээр төлөвлөгдсөн нь улс орны хөгжил, бүтээн байгуулалт ч судалгаанд оролцсон малчдын хувьд МАА, малчдын ирээдүй бүрхэг болж байна гэж үзэхэд хүргэж байна. Ерөнхийдөө тус сумын нийт газар нутгийн 50 хувь нь нүүрсний хайгуулын болон ашиглалтын лицензийн талбайд орсон, Цагаан-Овоо, Сийрэст багийн нутаг

нь бэлчээрийн МАА эрхэлдэг гол бүс нутаг бөгөөд 70-80 хувь нь уул уурхайн барилга байгууламж, хайгуул, өрөм, кемп, хог хаягдал, уурхайн овоолго, уурхайн тээвэрлэлтийн олон салаа зам гаргасны улмаас хөрс, бэлчээр, ургамал нь талхлагдалд орж доройтсоныг бүлгийн ярилцлагын дүн харуулж байна.

Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүс дэх малчид, багийн засаг дарга, холбогдох мэргэжилтнүүдийн өгсөн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээгээр Ханбогд, Цогтцэций сумын иргэд газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгааг харуулаад зогсохгүй 60 жилийн гэрээгээр эзэмшсэн өвөлжөө, хаваржаа бууцаа хүртэл алдаж цаашид нүүдлийн соёл иргэншлийн илэрхийлэл болсон бэлчээрийн МАА уул уурхайн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөгөөр энэ бүс нутагт байх нөхцөлгүй байдалд хүрч байгааг судалгааны үр дүн баталгаажуулж байна.

Малчдын газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх зөрчигдөхийн зэрэгцээгээр Үндсэн хуулиар баталгаажсан оршин суух газар нутгаа чөлөөтэй сонгох, өв соёлоо хойч үедээ уламжлуулан үлдээх, өвөлжөө хаваржааны газраа ашиглан мал аж ахуйгаа эрхлэх, цэвэр усаар хангагдах зэрэг олон эрхүүд нь давхар хөндөгдөж байна. Судалгааны явцад малчдын эрх ашиг асар ихээр хөндөгдөж байгаа, байгаль экологийн тэнцвэрт байдал дахин сэргэхгүй түвшинд алдагдаж байгааг төр засгийн бүх түвшинд мэдэж байгаа хэрнээ өнөөг хүртэл арга хэмжээ авахгүй байгаад маш их бухимдалтай байсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Жишээлбэл Цогтцэций суманд Энержи ресурс, Таван толгой, Эрдэнэс таван толгой компани жилдээ 10 гаруй мянган тонн нүүрс экспортолж байхад нутгийн иргэд дөнгөж амин зуулгын 200-300 орчим малтай, амьжиргааны дунд болон дундаас доогуур түвшинд амьдарч байгаа төдийгүй эдгээр уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөгөөр орлогын гол эх үүсвэр болсон МАА-гаа, МАА-гаа эрхлэн хөтлөхөд ашигладаг өвөлжөө бууц, бэлчээрээ алдахад хүрснийг тоон болон чанарын судалгааны үр дүн харуулж байна.

Жишээ 4.23

Шууд биш юм гэхэд бага багаар, аажим аажмаар өвөлжөө, хаваржааны газраасаа хөөгдөж байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Цагаан-Овоо багийн малчин)

4.4 Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн төлбөрийн зохицуулалт

Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр газар чөлөөлж нүүлгэн шилжүүлэгдсэн, нөлөөллийн ангилал, нөхөн олговорын зохицуулалт, орон нутгийн малчдад иргэдэд учруулсан сөрөг нөлөө, хохирлын барагдуулалт Канад, Австрали улсад нөхөн төлбөрийг шийдэж буй сайн туршлагын хүрээнд дүн шинжилгээ хийв.

Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн улмаас судалгаанд хамрагдсан нийт 50 өрхийн тал хувь нь буюу 25 өрх өөрийн нутагладаг өвөлжөө бууцаа орхин, нүүн шилжих хөтөлбөрт хамрагдсаныг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 4.9 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан байдал, сумдаар

	Гурвантэс	Ханбогд	Цогтцэций	Нийт
Нүүлгэн шилжүүлэгдсэн өрх	5	10	10	25
Нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдаагүй өрх	11	8	6	25
Өрхийн тоо	16	18	16	50

Ханбогд сумын судалгаанд хамрагдсан 18 малчны 10 нь, Цогтцэций сумын судалгаанд хамрагдсан 16 малчны 10 нь тус тус нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрт хамрагдаж өөрийн эзэмшиж байсан өвөлжөө бууцаа чөлөөлж өгчээ. Монгол улсын хууль тогтоомжид газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн хууль байхгүй байгаа энэ нөхцөлд Оюу толгой³, Энержи ресурс компаниуд олон улсын стандарт баримтлан энэ ажлыг зохион байгуулж байгаа нь судалгааны дүнгээр харагдаж байлаа. Түүнчлэн нөлөөллийн бүсэд нутаглаж буй иргэдийн өгсөн мэдээллээр, нөлөөллийн бүс тогтоох, нөхөн төлбөр олгох, нүүлгэн шилжүүлэхдээ иргэдийн саналыг харгалзах байдал нь муу байгааг шүүмжилж байсан. Тухайлбал Оюу толгой, Энержи ресурс компани бусад уул уурхайн компанитай харьцуулахад түрүү жилээс Олон улсын санхүүгийн корпораци, FCC Европын сэргээн босголтын банкны стандартыг баримтлан орон нутгийн засаг захиргаатай хамтран нөлөөллийн бүсийг тогтоох ажлыг эхлүүлжээ. Нөлөөллийн бүс тогтоох эхний шатны ажилд иргэдийн оролцоог төдийлөн хангахгүй байгаа нь малчидтай хийсэн чанарын судалгааны дүн харуулж байгаа билээ. Нөлөөллийн бүсээ тогтоосны дараа иргэдтэй яриа хэлцэл, зөвшил хийх ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд зарим малчдын зүгээс маргаан гарч байгаа нь нөлөөллийг тогтоож эхлэх эхний үйл явцаасаа эхлэн нөлөөлөлд өртсөн малчдын оролцоог хангаж чадаагүйгээр тайлбарлагдаж байна.

Оюу толгой компанийн хувьд 2004 онд биет нүүлгэн шилжүүлэлтийг хийж нийт 11 айл нүүлгэн шилжүүлсэн бол 2010-2012 онуудад эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын хөтөлбөрийг орон нутгийн засаг захиргааны байгууллага, нөлөөлөлд өртсөн малчидтай оролцоотойгоор хэрэгжүүлж газар чөлөөлөлт, нөхөн олговрын асуудлаар иргэдтэй тохиролцох, тэдний саналыг тусгах чиглэлээр ажиллаж байгааг судалгаанд хамрагдсан орон нутгийн удирдлага, ОТ ХХК-ний ОНХХ-ийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын дүн харуулж байна. ОТ ХХК нь уурхай ашиглагдах хугацаа (27 жилээр тооцсон) ба уурхайн хаалтын дараах хугацааг хамарсан нөлөөллийн үнэлгээг хийж 2012 онд дуусгасан байна. ОТ ХХК-ний мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас үзвэл ОТ ХХК-ийн 4 төрлийн барилгын үйл ажиллагааний нөлөөлөлд өртөж байгаа нийт 89 малчин өрхийг тогтоосон ба ОТ ХХК-ийн “Газар ашиглалт ба нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн үнэлгээ”-ний тайланд бичсэнээр сумын удирдлагуудаас уг нөлөөллийн хориотой бүсийг 20 км-ээр тогтоохыг санал болгож байсан ч дараа нь Оюу Толгойгоос төслийн улмаас нүүлгэн суурьшуулах малчдын тоог багасгахын тулд 10 км-ээр тогтоосон⁴ гэжээ. Эндээс харахад малчин хүний санаа бодол тусна гэдэг хүндрэлтэй болох нь

³ Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ийн Удирдамжийн тайлбар: Нийгмийн ба байгаль орчны тогтвортой байдлын үйл ажиллагааны стандарт. Удирдамжийн тайлбар 5 ‘Газар чөлөөлөлт ба албадан нүүлгэн суурьшуулалт’ [2007 оны 7 сар]

⁴ Газар ашиглалт ба нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн үнэлгээ, ОТ ХХК, 2012

харагдаж байна, учир нь орон нутгийн удирдлага нөлөөллийн бүсийг 20 км-ээр тогтоох санал гаргасан ч ОТ ХХК өөрөө 10 км-ээр тогтоосон байгаагаас ингэж дүгнэж болох юм.

Ханбогд сумын малчид ОТ ХХК-ийн дараах үйл ажиллагааны нөлөөлөлд өртөнө гэж тооцсон байна. Үүнд:

- ОТ ХХК-аас Гашуун сухайтын зам барих
- Нисэх буудлын талбай
- Гүний Хоолойн усны усны цооногийн талбай ба ус дамжуулах хоолой
- Цахилгаан дамжуулах шугам

Дээр хэлсэнчлэн нөлөөллийн бүс тогтоох, нөлөөлөлд өртсөн малчинд учирсан эд хөрөнгийн болон бусад хор хохирлыг үнэлэх аргачлал, үнэлэх стандарт байхгүйгээс шалтгаалан уул уурхайн компаниуд зөвхөн биет нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээгээр хязгаарлаж байна.

Жишээ 4.24

2010 оноос олон улсын стандартаар эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөр хэрэгжүүлж, нутгийн иргэд, хувь хүмүүсийн оролцоог хангаж малчдын хэлэлцүүлгүүдийг удаа дараа зохион байгуулсан. Нөлөөллөө тогтоохдоо бага малын хөлөөр баримжаа авсан \5-6 км-т бэлчинэ гэж үзээд\ Өвөлжөө нь 3 км-т байгаа малчин өрхийг нөлөөллийн хамгийн хүнд нөхцөлд байгаа ангилалд оруулсан. Нөлөөлөлд ус, эрүүл мэндийн нөлөөллийн асуудлыг тусгаагүй. Эрүүл мэндэд нөхөн төлбөр өгөөгүй. Энэ олон компаниуд бүгд тоос гаргаж байгаа, аль нь хүний эрүүл мэндэд нөлөө үзүүлж байгааг ЭМЯ тогтоох байх.

(Ганцаарчилсан ярилцлага, ОТ ХХК, ОНХХ-ийн ажилтан)

Матриц 4.2 ОТ ХХК-ийн барилгын нөлөөлөлд өртсөн малчин гэр бүлийн амьжиргааг дэмжих арга хэмжээ

Нөлөөллийн ангилал	Нөлөөнд өртсөн гэр бүл	Нөлөөний төрөл	Хамрагдах малчин гэр бүл	Хамрагдах шалгуур нөхцөл	Дэмжлэгийн төрөл
В1. ОТ Ханбумбат онгоцны буудлын талбай	Онгоцны буудлын 5 км-ийн радиуст өвөлжөө бүхий малчин өрх	Бэлчээрээ алдсан Хурц гэрэл Дуу чимээ	Өрхийн төрөл: Ганц бие өрх Ам бүлээрээ Нийлмэл өрх	Онгоцны буудлын талбайгаас 5 км-т байрлах, зөвшөөрөлтэй, ашиглаж буй өвөлжөө ⁵ Тухайн өрх энэ төрлийн нөлөөлөлд өртсөн дээр санал нэгдсэн	Байнгын ажлын байр (1 ажлын байр 1 өрхөд) БА Боловсролын дэмжлэг: Өрхийн нэг оюутанд дээд боловсролын тэтгэлэг. Дунд сургуулийн одоо сурч буй сурагчдын хичээлийн бэлтгэл (жилд нэг удаа). БА Бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах төсөл: малчдад зориулсан уг хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэх, төслийг боловсруулах, үйл ажиллагаанд оролцох. БА Малчин өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр: Орон нутгийн бизнес болон эдийн засгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бий болох боломжуудад эн тэргүүнд хамруулах, БА Богино хугацааны сургалтын төлбөр (1 удаа, дотооддоо, 45 хоногоос доош)

V2.(A) ОТ Ханбумбат онгоцны буудлын талбай	Онгоцны буудлын 5- 8км-ийн радиуст өвөлжөө бүхий малчин өрх	Бэлчээр шахагдсан	Өрхийн төрөл: Ганц бие өрх Ам бүлээрээ Нийлмэл өрх	Онгоцны буудлаас 5 - 8 км байрлах, зөвшөөрөлтэй, ашиглаж буй өвөлжөө Тухайн өрх энэ төрлийн нөлөөлөлд өртсөн дээр санал нэгдсэн	Боловсролын дэмжлэг: Дунд сургуулийн одоо сурч буй сурагчдын хичээлийн бэлтгэл (жилд нэг удаа). ЭСВЭЛ Байнгын ажлын байр (1 ажлын байр 1 өрхөд) БА Бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах төсөл: малчдад зориулсан уг хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэх, төслийг боловсруулах, үйл ажиллагаанд оролцох. БА Малчин өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр: Орон нутгийн бизнес болон эдийн засгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бий болох боломжуудад эн тэргүүнд хамруулах,
(Б) ОТ Ханбумбат онгоцны буудлын талбай	Онгоцны буудлын 8-11 км-ийн радиуст өвөлжөө бүхий малчин өрх	Бэлчээр шахагдсан	Өрхийн төрөл: Ганц бие өрх Ам бүлээрээ Нийлмэл өрх	Онгоцны буудлаас 8 - 11 км байрлах, зөвшөөрөлтэй, ашиглаж буй өвөлжөө Тухайн өрх энэ төрлийн нөлөөлөлд өртсөн дээр санал нэгдсэн	Боловсролын дэмжлэг: Дунд сургуулийн одоо сурч буй сурагчдын хичээлийн бэлтгэл (жилд нэг удаа). ЭСВЭЛ Байнгын ажлын байр (1 ажлын байр 1 өрхөд) БА Бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах төсөл: малчдад зориулсан уг хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэх, төслийг боловсруулах, үйл ажиллагаанд оролцох. БА Малчин өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр: Орон нутгийн бизнес болон эдийн засгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бий болох боломжуудад эн тэргүүнд хамруулах,
C1. ОТ – ГС зам	ОТ – ГС замаас 500 м-т өвөлжөө бүхий малчин өрх	Бэлчээр, ус хуваагдсан Замын барилга, үйл ажиллагаа ны үед гарах дуу чимээ, замын хөдөлгөөн, болон их хэмжээний тоосжилт	Өрхийн төрөл: Ганц бие өрх Ам бүлээрээ Нийлмэл өрх	ОТ-ГС хүртэлх замын хоёр талд 500 метрийн зайнд байрлах, гэрчилгээтэй, ашиглаж буй өвөлжөө Тухайн өрх энэ төрлийн нөлөөлөлд өртсөн дээр санал нэгдсэн	Байнгын ажлын байр (1 ажлын байр 1 өрхөд) БА Өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр: : Орон нутгийн бизнес болон эдийн засгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бий болох боломжуудад эн тэргүүнд хамруулах, БА Боловсролын дэмжлэг: Өрхийн нэг оюутанд дээд боловсролын тэтгэлэг. Дунд сургуулийн одоо сурч буй сурагчдын хичээлийн бэлтгэл (жилд нэг удаа). БА Бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах төсөл: малчдад зориулсан уг хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэх, төслийг боловсруулах, үйл ажиллагаанд оролцох.
C2 /A/ ОТ – ГС зам	ОТ – ГС замын дагуу 500 м - 3.500км-т өвөлжөө бүхий малчин өрх	Бэлчээр шахагдсан Тоосжилт ихссэн	Өрхийн төрөл: Ганц бие өрх Ам бүлээрээ Нийлмэл өрх	ОТ-ГС замын хоёр талд 500 м – 3,5 км дотор байрлах, гэрчилгээтэй, ашиглаж буй өвөлжөө Тухайн өрх энэ төрлийн нөлөөлөлд өртсөн дээр санал нэгдсэн	Боловсролын дэмжлэг: Дунд сургуулийн одоо сурч буй сурагчдын хичээлийн бэлтгэл (жилд нэг удаа). ЭСВЭЛ Байнгын ажлын байр (1 ажлын байр 1 өрхөд) БА Бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах төсөл: малчдад зориулсан уг хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэх, төслийг боловсруулах, үйл ажиллагаанд оролцох. БА Малчин өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр: Орон нутгийн бизнес болон эдийн засгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бий болох боломжуудад эн тэргүүнд хамруулах


C2 /Б/ ОТ – ГС зам	ОТ – ГС замын дагуу 3,5км-т – 6,5 км-т өвөлжөө бүхий малчин өрх	Бэлчээр шахагдсан Тоосжилт ихссэн	Өрхийн төрөл: Ганц бие өрх Ам бүлээрээ Нийлмэл өрх	ОТ-ГС замын хоёр талд 3,5 км– 6,5 км дотор байрлах, гэрчилгээтэй, ашиглаж буй өвөлжөө Тухайн өрх энэ төрлийн нөлөөлөлд өртсөн дээр санал нэгдсэн	Боловсролын дэмжлэг: Дунд сургуулийн одоо сурч буй сурагчдын хичээлийн бэлтгэл (жилд нэг удаа). ЭСВЭЛ Байнгын ажлын байр (1 ажлын байр 1 өрхөд) БА Бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах төсөл: малчдад зориулсан уг хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэх, төслийг боловсруулах, үйл ажиллагаанд оролцох. БА Малчин өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр: Орон нутгийн бизнес болон эдийн засгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бий болох боломжуудад эн тэргүүнд хамруулах
D1. Цахилгаан дамжуулах шугам болон усны хоолойн талбай	Цахилгаан дамжуулах шугам болон Гүний Хоолойн усны хоолойн замын тогтсон нөлөөллийн бүст өвөлжөө бүхий малчин өрхүүд	Бэлчээр, ус хуваагдсан Усны хоолой, зам, цахилгаан дамжуулах шугамын барилга, үйл ажиллагааны үед гарах тоосжилт, замын хөдөлгөөн нэмэгдсэн Дуу чимээ	Өрхийн төрөл: Ганц бие өрх Ам бүлээрээ Нийлмэл өрх	Цахилгаан дамжуулах шугам эсвэл Гүний хоолойн усны хоолойн хоёр талд 1 км зайнд байрлах, гэрчилгээтэй, ашиглаж буй өвөлжөө (I үе) Гүний хоолойн усны хоолойн хоёр талд 3 км зайнд байрлах, гэрчилгээтэй, ашиглаж буй өвөлжөө (II үе) Тухайн өрх энэ төрлийн нөлөөлөлд өртсөн дээр санал нэгдсэн	Байнгын ажлын байр (1 ажлын байр 1 өрхөд) БА Боловсролын дэмжлэг: Өрхийн нэг оюутанд дээд боловсролын тэтгэлэг. Дунд сургуулийн одоо сурч буй сурагчдын хичээлийн бэлтгэл (жилд нэг удаа). БА Бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах төсөл: малчдад зориулсан уг хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэх, төслийг боловсруулах, үйл ажиллагаанд оролцох. БА Малчин өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр: Орон нутгийн бизнес болон эдийн засгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бий болох боломжуудад эн тэргүүнд хамруулах, БА Богино хугацааны сургалтын төлбөр (1 удаа, дотооддоо, 45 хоногоос доош)
D2.(A) Цахилгаан дамжуулах шугам болон) Гүний хоолойн 1-р хэсэг	Цахилгаан дамжуулах шугам болон Гүний Хоолойн усны хоолойн замын тогтсон нөлөөллийн бүст өвөлжөө бүхий малчин өрхүүд	Бэлчээр хуваагдсан Тоосжилт ихссэн	Өрхийн төрөл: Ганц бие өрх Ам бүлээрээ Нийлмэл өрх	Цахилгаан дамжуулах шугам болон Гүний хоолойн усны хоолойн (1-р шатны) хоёр талд 1 -2 км зайнд байрлах, гэрчилгээтэй, ашиглаж буй өвөлжөө (I үе) Гүний хоолойн усны хоолойн хоёр талд 3-5 км зайнд байрлах, гэрчилгээтэй, ашиглаж буй өвөлжөө (II үе) Тухайн өрх энэ төрлийн нөлөөлөлд өртсөн дээр санал нэгдсэн	Боловсролын дэмжлэг: Дунд сургуулийн одоо сурч буй сурагчдын хичээлийн бэлтгэл (жилд нэг удаа). ЭСВЭЛ Байнгын ажлын байр (1 ажлын байр 1 өрхөд) БА Бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах төсөл: малчдад зориулсан уг хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэх, төслийг боловсруулах, үйл ажиллагаанд оролцох БА Малчин өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр: Орон нутгийн бизнес болон эдийн засгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бий болох боломжуудад эн тэргүүнд хамруулах

D2(B) Гүний хоолойн 2-р хэсэг	Гүний Хоолойн усны хоолойн замын тогтсон нөлөөллийн бүст өвөлжөө бүхий малчин өрхүүд	Бэлчээр хуваагдсан Тоосжилт ихссэн	Өрхийн төрөл: Ганц бие өрх Ам бүлээрээ Нийлмэл өрх	Гүний хоолойн усны хоолойн хоёр талд 5 - 7 км зайнд байрлах, гэрчилгээтэй, ашиглаж буй өвөлжөө	Боловсролын дэмжлэг: Дунд сургуулийн одоо сурч буй сурагчдын хичээлийн бэлтгэл (жилд нэг удаа). ЭСВЭЛ Байнгын ажлын байр (1 ажлын байр 1 өрхөд) БА Бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах төсөл: малчдад зориулсан уг хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэх, төслийг боловсруулах, үйл ажиллагаанд оролцох БА Малчин өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр: Орон нутгийн бизнес болон эдийн засгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бий болох боломжуудад эн тэргүүнд хамруулах
E1. Зуны бэлчээр	Бүх багийн малчид	Бэлчээр, ус хуваагдсан, хумигдсан, хомсдсон	Орон нутгийн иргэд (Багийн Засаг даргаар төлөөлүүл нэ)	Малчин өрх / хувь хүний нөлөөнд өртсөн байдлын талаар Иргэдийн нийтийн хурлаар зөвшилцөнө	Нийтийг хамарсан цаг үеийн дэмжлэг: орон нутгийн иргэд болон багийн засаг даргын саналыг үндэслэн харилцан зөвшилцсний үндсэн дээр дэмжлэг үзүүлэх /жишээ нь БАХ-р дамжуулан хуучин худаг ус сэргээх, шаардлагатай газар худаг ус гаргах, хадлан малын тэжээл өгөх/ БА Бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах төсөл: малчдад зориулсан уг хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэх, төслийг боловсруулах, үйл ажиллагаанд оролцох. Хөтөлбөрийг тухайн баг болон өрхийн түвшинд зориулан боловсруулна.
F1.A Одоогоор ашиглаагүй өвөлжөө	Төслийн дээр дурдсан нөлөөллийн ангилалд ашигладаггүй өвөлжөө бүхий өрхүүд (гэрчилгээ эзэмшигч)	Хавсарсан нөлөө (Цагаан хадны орчим) Бусад	Өрхийн төрөл: Ганц бие өрх Ам бүлээрээ Нийлмэл өрх	Тухайн өвөлжөөний гэрчилгээтэй 2009 оны 10-р сарын 6-ний өдрөөс хойш ашиглаагүй өвөлжөө Тухайн өрх энэ төрлийн нөлөөлөлд өртсөн дээр санал нэгдсэн	Боловсролын дэмжлэг: Өрхийн нэг оюутанд дээд боловсролын тэтгэлэг ЭСВЭЛ Дунд сургуулийн одоо сурч буй сурагчдын хичээлийн бэлтгэл (жилд нэг удаа). БА Байнгын ажлын байр (1 ажлын байр 1 өрхөд) ЭСВЭЛ Богино хугацааны сургалтын төлбөр (1 удаа, дотооддоо, 45 хоногоос доош)
F1.B Одоогоор ашиглаагүй өвөлжөө	Төслийн дээр дурдсан нөлөөллийн ангилалд ашигладаггүй өвөлжөө бүхий өрхүүд (гэрчилгээ эзэмшигч)	Хавсарсан нөлөө Бусад	Өрхийн төрөл: Ганц бие өрх Ам бүлээрээ Нийлмэл өрх	Тухайн өвөлжөөний гэрчилгээтэй 2009 оны 10-р сарын 6-ний өдрөөс хойш ашиглаагүй өвөлжөө Тухайн өрх энэ төрлийн нөлөөлөлд өртсөн дээр санал нэгдсэн	Боловсролын дэмжлэг: Өрхийн нэг оюутанд дээд боловсролын тэтгэлэг ЭСВЭЛ Дунд сургуулийн одоо сурч буй сурагчдын хичээлийн бэлтгэл (жилд нэг удаа). ЭСВЭЛ Байнгын ажлын байр (1 ажлын байр 1 өрхөд) ЭСВЭЛ Богино хугацааны сургалтын төлбөр (1 удаа, дотооддоо, 45 хоногоос доош)
F2. Бусад	Одоогоор тогтоогдоогүй боловч төслийн үйл ажиллагаанаас шалгаалан ирээдүйд үүсэх сөрөг нөлөө	Хэрэв тогтоогдвол тодорхойлох	Өрх эсвэл нутгийн иргэд	Нөлөөлөлд өртсөн талаар тухайн хувь хүн, сумын захиргаа болон компанийн зүгээс зөвшилцсөн байна	Тухай бүр шийдвэрлэнэ. Тухайн нөлөөний төрлөөс хамааран дээр дурдсан багц эсвэл хослолыг зөвшилцөнө.

Эх сурвалж: Оюу ХХК, ОНХХ

Анх Оюу толгой төсөл 10-аад айлыг нүүлгэн шилжүүлсэн ч эдгээр айл өрх нь дахин нүүлгэн шилжүүлтэд орсноос шалтгаалан нүүлгэх арга хэмжээг аль болох авахгүй байх бодлого баримталж байгааг Оюу толгой төслийн ОНХХ-ийн ажилтан дурьдаж байлаа. Гэвч тухайн нөлөөллийн онцлог, үргэлжлэх хугацаа, үр дагавар зэргээс хамаарч шийддэг ажээ.

Уул уурхай хөгжсөн, хүний эрхэд суурилсан хандлагаар асуудлыг шийддэг улс орнуудын туршлагаар уул уурхайн компани нь орон нутгийн иргэд, уугуул иргэдтэй зөвшилцөөгүй цагт, тэдний хүсэл сонирхолыг бүрэн хэмжээгээр тусгаагүй цагт уул уурхай үйл ажиллагаагаа огт эхэлдэггүй байна. Учир нь тэрхүү байгалийн баялгийг авч байгаа газрын уугуул иргэд, орон нутгийн эрх ашгийг хамгийн түрүүнд авч үздэг, тэдний хүсэл сонирхол, хэрэгцээг зөвшилцсөний дараа олборлолт, ашиглалтын үйл ажиллагааг явуулдаг байна.



Зурагт харуулснаар Гурвантэс, Цогтцэций сумын малчидтай компанийн удирдлага бараг тохиролцдоггүй гэж үзсэн бол Оюу толгой төслийн нөлөөллийн бүсэд орсон малчин өрхийн дийлэнх нь буюу 90 хувь нь нүүлгэн шилжүүлэлт хийхдээ малчидтай тохиролцдог, саналыг авдаг хэмээн үзэж байгааг илэрхийлж байна. Харин Ханбогд сумын чанарын судалгаанд хамрагдсан малчид нөлөөллийн бүс тогтоох, нөхөн олговрын хэмжээ тогтоохдоо эхэлж малчидтай зөвлөлддөггүй хэмээн хариулж байлаа.

Жишээ 4.25

Нөлөөллийн бүс тогтоохдоо орон нутгийн иргэдийг оролцуулдаггүй. Нөлөөллийн бүсээ 500 метрээр тогтоодог. Бидэнтэй зөвшилцдөггүй.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Цагаан-Овоо багийн малчид)

Нөлөөллийн 20-иод айл байна. Тохиролцоонд хүрэхгүй байна. Иргэд замбараагүй их мөнгө нэхдэг. Малчид хохирч байгаа нь үнэн л дээ. Нэг айл гэхэд л 150-200,0 сая төгрөг нэхдэг.

(Ганцаарчилсан ярилцлага, Гурвантэс сум, Баясах багийн Засаг дарга)

Нөлөөллийн бүсийг тогтоож, багийн нийтийн хурал, сумын ИТХ-аар хэлэлцүүлсэн. Одоогийн байдлаар Оюу толгой төслийн нөлөөлөлд өртсөн 80 гаруй айл байгаа ба онгоц буудал, гүний хоолой, шугам татах хоолойн нөлөөлөлд өртсөн айлуудыг тогтоосон. Бүх айлуудтай нь уулзаж, танилцуулсан. Одоогоор айл нэмж гарч ирээд байгаа. 500м-11 км хүртэл нөлөөллийг ангилсан. Нисэх онгоц 5-8 км, 8-11км, Оюу толгой Гашуун сухайт 500-3,5км, шугам татах хоолойны нөлөөллийг 3,5 км- 6 км-аар тус тус тогтоосон. Гарын үсэг зурдаггүй айлууд их мөнгө шаарддаг, тэгсэн атлаа үндэслэлээ тайлбарлаж чаддаггүй малчид байдаг. Малчид өмчлөх хүсэлтэй ч хуулиа мэддэггүй, Оюу толгой ХХК олонхийн саналаар асуудлыг шийдэж байна. 80 гаруй айл гэрээнд гарын үсэг зураад нөхөн төлбөр, амьжиргааг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж байгаа.

Гурвантэс, Ханбогд сумдтай харьцуулахад Цогтцэций сумын малчид нүүрсний уурхайн хайгуул, ашиглалтын \нүүрсний тээвэрлэлт\ нөлөөлөлд хамгийн их өртөж, эрх ашиг нь зөрчигдөж байна. Энержи ресурс компанийн нүүрсний зам, уурхайн кемп, ус татах хоолой барьж байгуулах үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн 54 өрх байгаагаас 20 гаруй айл өрх нь нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрт хамрагдсаныг чанарын судалгааны дүн харуулж байна. Энержи ресурс ХХК-ийн ажилтны өгч байгаа мэдээллээр төмөр замын нөлөөлөлд өртөнө гэж тооцоолж байгаа 30 орчим малчин өрхүүд нэмэгдэхээр байна.

Цогтцэций сумын малчид өнөөдрийг хүртэл малчид болон багийн засаг дарга нар Энержи ресурс компанийн нүүлгэн шилжүүлэлтийн бодлогод шүүмжлэлттэй хандсан бөгөөд нөлөөллийн бүс тогтоохдоо орон нутгийн оролцоог хангадаггүй, зөвшилцдөггүй, хохирлыг барагдуулах арга хэмжээ авахдаа хойрго ханддаг хэмээн үзэж байгааг бүлгийн ярилцлагын судалгааны дүн харуулж байлаа. Жишээлбэл, судалгаанд хамрагдсан Энержи ресурс ХХК-ийн нөлөөлөлд өртсөн 10 гаруй айл (өвөлжөөг нь авсан, өвөлжөөг нь дайрч зам явсан) нөлөөллийн шууд бүсэд орсон ч нөхөн олговор олгоогүй, хохирлын асуудлыг шийдээгүйг тэмдэглэж байв.

Жишээ 4.26

Анх 2009 онд манай компани уурхайн ашиглалтын талбайд байсан 13 өрхийн гэрчилгээтэй өвөлжөө, 3-4 өрх дундаа уудаг худгийг малчидтай зөвлөн нүүлгэн шилжүүлсэн. Нөлөөллийн бүсээ 500 метрээр тогтоосон. Биет хөрөнгийг нь өмнөхөөс нь дордуулахгүйгээр шинээр нүүлгэн шилжүүлсэн. Малчид мөнгө авахыг хүссэн ч анхнаасаа өгөхгүй гэдгийг тохирсон. Одоо автозам, төмөр замын нөлөөлөлд өртсөн 70 гаруй айл байгаа. Манай компанийн хувьд нүүлгэн шилжүүлэлт бол эцсийн шийдэл гэдэг зарчмыг барьж байгаа. Уул уурхайн ашиглалтын явцад авто зам, барилгын үйл ажиллагааны нөлөөллийн бүсийг 1 км-ээр тогтоосон. Малчид 1 км-ээр хязгаарлах нь буруу гэж үзэж байгаа. Шороон замаар олон компани явж тоос үүсгэж байгаа, хэнээс нь болоод байна вэ гэдгийг иргэд, малчид ойлгодоггүй. Манай туслан гүйцэтгэх 10 компани, тэдний туслан гүйцэтгэх 30 гаруй компани байгаа, манайхаас тэдэнтэй гэрээ хийхдээ малчны өвөлжөө хаваржаа, кемп, хог хаягдлын асуудлыг тусган гэрээ байгуулдаг. Өнөөдөр Монгол улсад хүний эрхийг зөрчдөг байдал нийтлэг болсон асуудал, түүнээс биш уул уурхайн үйл ажиллагаа явагдсанаар хүний эрхийн зөрчил үүсээгүй.

(Ганцаарчилсан ярилцлага, Энержи ресурс ХХК, ОННХ-ийн ажилтан)

Тоон болон чанарын судалгааны дүнгээс харахад, Оюу толгой, Энержи ресурс ХХК-ийн ажилтнууд малчдын оролцоотойгоор нөлөөллийн бүсээ тогтоосон, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын хэмжээг зөвшилцлөөр шийдвэрлэж байгаа гэсэн мэдээллийг өгч байгаа ч нутгийн малчид, Ханбогд сумын орон нутгийн удирдлага 20 км-ээр тогтоох хүсэлт гаргасан ч эцэстээ Оюу толгой ХХК нөлөөллийн бүсээ 10 км-ээр, Энержи ресурс ХХК 1 км-ээр нөлөөллийн бүсээ тогтоосныг малчид хүлээн зөвшөөрөхгүй байгаа зэргээс үзвэл эдгээр компаниуд малчид, орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурласан гэж үзэхэд хүндрэлтэй байна. Түүнчлэн уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн төрөлд хүний эрүүл мэндэд учирч буй нөлөөллийг огт оруулж тооцохгүй байгааг судалгааны дүн харуулж байна. Ийм нөхцөл байдал үүсэхэд хууль эрх зүйн орчин байхгүй, төрийн бүх шатны байгууллага, мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагаа сул байгаатай холбоотой байна.

Уул уурхайн компанийн ажилтнуудтай хийсэн ярилцлагаас харахад, нөлөөлөлд өртсөн малчдад биет, эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн төлбөрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ч малчдын эрүүл мэнд, малын эрүүл мэндэд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж байгаа нөлөөллийн талаар огт анхаарал хандуулахгүй байна.

Уул уурхайн компани нүүлгэн шилжүүлэлтийн бодлого стандарт байгаа бол судалгаанд хамрагдсан сумдын нутгийн өөрөө удирдах болон засаг захиргааны байгууллагад энэ талаар ямар бодлого, журам байгаа эсэх, оролцоо хэр зэрэг байгааг малчдаас асуулгын аргаар бусад оролцогчдоос бүлгийн ярилцлагын аргаар тодруулсан юм.

Хүснэгт 4.10 Нөлөөллийн бүсийн сумдын орон нутгийн захиргааны байгууллагад нүүлгэн шилжүүлэлтийн бодлого байдаг эсэх

	Гурвантэс	Ханбогд	Цогтцэций	Нийт
Нүүлгэн шилжүүлэлтийн бодлого, арга хэмжээ байхгүй Мэдэхгүй	-	5	4	9
Өрхийн тоо	16	13	15	41
	16	18	16	50

Судалгаанд хамрагдсан 50 малчны дийлэнх нь буюу 41 нь сум орон нутгийн засаг захиргааны байгууллагад уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр эрх ашиг нь хөндөгдсөн орон нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор талаарх бодлого, арга хэмжээг мэдэхгүй гэж хариуллаа. Бүлгийн ярилцлагад оролцсон орон нутгийн засаг захиргааны төлөөлөл нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, хохирол барагдуулах нь малчин, компани хоорондын асуудал гэж үзэх хандлага нийтлэг илэрч байсан бөгөөд энэ харилцааг зохицуулсан хууль эрх зүйн орчин байхгүй, хааяа нэг газрын хуулиар зохицуулна гэж үзсэн хэдий ч энэ хуулийг ашиглаж шийдсэн тохиолдол огт байхгүй байлаа.

Судалгаанд хамрагдсан Гурвантэс суманд нүүрсний компаниудын явуулж буй үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл Урт, Баясах, Тост багийн нутагт нутаглаж буй нутгийн иргэд, малчид өртөж байгаа ч уул уурхайн компаниудын сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа учир дутагдалтай байгааг дараах жишээ харуулж байна.

Жишээ 4.27

Манай өвөлжөө МАК-ийн отвалаас 1хөрс хуулалтын овоолго\ 50 метрийн зайд байгаа. Байх аргагүй болоод өөрсдөө төв орж, хэдэн малаа аавынх руугаа нүүлгэсэн. 2011 онд МАК-тай өвөлжөөний асуудлаар уулзахад өргөдөл бичиж өг, МАК-ийн ерөнхийлөгчид танилцуулна гэсэн. Өргөдөл бичиж өгсөн. 2012 онд МАК-тай дахин уулзахад өргөдлийг танилцуулсан, энэ жил дахиад л Ерөнхийлөгчдөө танилцуулна гэсэн.

(Ганцаарчилсан ярилцлага, Гурвантэс сум, Урт багийн малчин)

Нүүрсний зам дагуу, уурхайгаас урагш айл байхгүй. 2 малчин манай лицензийн талбайд байдаггүй ч бид уулзаж санал бодлыг нь сонсоод Газрын тухай хуулиар хохиролгүй болох асуудлыг нь шийдэхээр болсон байгаа.

(Ганцаарчилсан ярилцлага, Гурвантэс сум, МАК-ийн уурхайн дарга)

Гурвантэс сумын Урт багийн малчдын өвөлжөөнд МАК-ийн хөрс хуулалтын овоолго 50 метрт ирчихээд байхад МАК компани ямар ч арга хэмжээ авалгүй 2 дахь жилийн нүүр үзэж байгаа төдийгүй уурхайн удирдлага уурхайн орчим нэг ч малчин айл

байхгүй гэсэн хариултыг өгч байсан билээ. Гурвантэс сумын газрын даамалтай хийсэн ярилцлагаар уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын талбайд болон талбай орчимд 80 гаруй айл байгааг тэмдэглэж байв. МАК компанийн хувьд уурхайн нөлөөлөлд өртсөн малчин өрхийн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын асуудлыг хөндөхөөсөө илүүтэйгээр сум орон нутагт оруулж буй хандив, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаар орлуулж авч үзэх хандлага илэрч байв.

Хэдийгээр уул уурхайн компаниуд олон улсын стандарт, удирдамжийг баримтлан газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай ч хүний хамгийн үнэт капитал болсон эрүүл мэнд болон малчны амьжиргааны амин сүнс болсон ус, усны нөөцөд уул уурхайн үзүүлж буй нөлөөллийг оруулалгүй орхисон нь учир дутагдалтай байна. Уул уурхайн олон жилийн үйл ажиллагааны сөрөг нөлөө нь хүний эрүүл мэнд, хүний амьжиргаа, болон байгалийн нөөцүүдэд хэр зэрэг нөлөө үзүүлж байгааг олон жилийн туршийн хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг хийх, улмаар хохирлыг тооцох, үүн дээрээ үндэслэн хохирлын стандартыг гаргаж ирэх шаардлага манай улсын хувьд нэн тулгамдсан асуудал болжээ гэдгийг судалгааны дүнд үндэслэн дүгнэж байна. Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас хүний эрүүл мэнд, малчин хүний амьжиргааны гол хэрэглүүр болсон малын эрүүл мэнд, малын тооны бууралт, ашиг шим, бусад эд хөрөнгийн алдагдалд хариуцлага хүлээх уул уурхайн компани олдохгүй байх нөхцөл байдалтай байна. Уул уурхайн компаниуд бүгд тоос тоожилт бий болгоход нөлөөлж байгаа атлаа бие бие рүүгээ түлхэх хандлага ажиглагдаж байна.

Иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй төрийн бүх шатны байгууллагуудын хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага, оролцоо туйлын хангалтгүй байгаа нь уул уурхайн сөрөг нөлөөллийн улмаас хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг уул уурхайн компаниуд тооцохгүй байх боломжийг олгож өгч байна.

Нөхөн төлбөрийн зохицуулалт

Асуулга судалгаанд хамрагдсан малчдын өгсөн мэдээллээр, нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрт хамрагдсан 25 малчнаас нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдснаар нөхөн төлбөр авсан эсэх, нөхөн төлбөр авах гэрээ байгуулсан эсэхийг тодруулан судлахад ердөө 15 малчин нөхөн төлбөр авч байгаагаас 10 нь Ханбогд сумын малчин, 5 нь Цогтцэций сумын малчин байлаа.

Хүснэгт 4.11 Нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрт хамрагдсан малчдын нөхөн төлбөр авсан талаарх мэдээлэл

	Гурвантэс	Ханбогд	Цогтцэций	Нийт
Нөхөн төлбөр				
Авсан	-	90.9	49.1	15
Аваагүй	100.0	9.1	50.1	10
Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо санал малчны саналыг авсан эсэх				
Тийм		30.0	20.0	4
Үгүй	-	70.0	80.0	11
Гэрээ хийсэн эсэх				
Тийм		100.0	40.0	12
Үгүй			60.0	3
Өрхийн тоо	-	10	5	15

Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо малчдын саналыг авдаггүй болох нь нөхөн төлбөр авч байгаа малчдын дөнгөж 20 хувь нь бидний саналыг авсан гэж хариулснаас харагдаж байсан ба уул уурхайн компани өөрөө нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосны дараа малчдад санал болгох, тулгах хэлбэрээр зохицуулж байгаа нь тэдэнтэй хийсэн чанарын судалгаанаас харагдаж байсан юм.

Оюу толгой төсөл нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрт хамрагдан нөхөн төлбөр авч байгаа малчидтай нэг болон түүнээс жилээр гэрээ байгуулдаг байна. Гэрээг нөлөөллийн зэргээс хамааруулан 1-12 жилээр хүртэл байгуулсан байлаа. Жишээ нь 3 малчин нэг жилээр, 6 малчин таван жилээр, нэг малчин 12 жилээр нөхөн олговор авах гэрээ хэлцэл байгуулсан байна.

Хүснэгтэд харуулснаар Ханбогд, Цогтцэций сумын нийт 15 өрх нөхөн төлбөр авч байна. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо иргэдийн саналыг харгалздаггүй гэсэн хариултын хувийн жин өндөр илэрсэн болно. Судалгааны оролцогчдын мэдээллээс харахад жилд олгож байгаа нөхөн олговрын хэмжээ 1.5 саяаас 7 сая төгрөгний хооронд хэлбэлзэж байгаа ба ОТ ХХК бэлэн мөнгө, ажлын байраар хангах хэлбэр, нийгмийн хамгааллын арга хэмжээний хэлбэрээр зохицуулж байгаа бол Энержи ресурс компанийн хувьд бэлэн мөнгө өгөхөөс татгалзаж худаг ус гаргах, хашаа саравч барьж өгөх, ажлын байраар хангах зэргээр мөнгөн бус хэлбэрээр нөхөн олговрын асуудлыг шийдэж байна. ОТ ХХК нь нөхөн төлбөрөөс гадна шууд нөлөөлөлд өртөж өвөлжөөгүй болсон малчдад нэг удаагийн нөхөн олговор олгосон ба хамгийн дээд тал нь нэг өрхөд 20 сая төгрөг өгчээ.

Жишээ 4.28

Бэлчээрээ булгаалгасан. Өвөлжөө, хаваржаагаа мөнгөөр үнэлэхийн аргагүй. Өөрийнхөө өвөлжөө хаваржаатай баймаар байна. ОТ ХХК өвөлжөө бууцыг 15 сая төгрөг гэж тогтоосон. Бид эргээд ус, бэлчээр, газар нутгаа 15 саяар дахин худалдаж авна гэж байхгүй. Нөлөөлийн бүсээ нэг мэдэхэд л тогтоосон байдаг. ОТ ХХК-аас гэрээ өгсөн, гарын үсгээ зураагүй байгаа. Гарын үсэг зурахыг байнга шахдаг. 80-аад айлаас 10-аад айл гарын үсгээ зураагүй байгаа.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Баян багийн малчин)

Одоогоор ОТ ХХК-ийн 4 төрлийн нөлөөлөлд 89 айл байгааг ажлын хэсэг хэлэлцэж тогтоосон. Эзэнгүй байгаа хондыг хүртэл оруулсан. Манай компанийн зүгээс малчидтай гэрээ байгуулах, малчдын эрх ашгийг хамгаалах үүднээс хуульчийн бүх зардал мөнгийг төлж авчирсан. Одоогоор гарын үсгээ зураагүй 7 айл байгаа.

(Ганцаарчилсан ярилцлага, ОТ ХХК, ОНХХ-ийн ажилтан)

Ханбогд сумын хувьд 89 малчин өрхийн өвөлжөө бууц, хаваржаа, намаржаа, зуслангийн бэлчээр, худаг ус нь ОТ ХХК-ийн гүний хоолой, цахилгаан дамжуулах шугам, нисэх буудал, зам барих үйл ажиллагааны нэг болон түүнээс дээш нөлөөлөлд орж, бэлчээрээ алдах, бэлчээр шахагдах, бэлчээр ус хуваагдах, замын хөдөлгөөн, барилгын тоос тоосжилт, дуу чимээний нөлөөлөлд өртсөн гэж үзэн 82 айлд эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийх гэрээ байгуулаад байгаа байна. Компани малчидтай зөвшилцөх замаар гэрээ байгуулж байна гэж үзсэн бол малчдын хувьд тулган шаардах, шахалтанд оруулах арга замаар гарын үсэг зуруулсан гэж үзсэн нэг хэсэг байхад юу юу ч үгүй үлдэж байхаар оногдох зүйлээ авъя гэж үзээд зурсан гэх малчид ч судалгааны явцад таарч байлаа.

Оюу толгой ХХК нь нөлөөлөлд өртсөн малчин өрхийг ажлын байраар хангаж байгаа бөгөөд 300-400 мянгаар цалинжуулах, их дээд сургуулийн хүүхдийн төлбөр төлөх, хүүхдийн хичээлийн хэрэглэл авч өгөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Жишээ 4.29

60 жилээр эзэмшсэн өвөлжөө, хаваржаа Оюу толгой төслийн нөлөөлөлд 2 удаа орсон. Онгоц буудал, гүний хоолойн нөлөөллийн бүсэд ороод нөхөн олговор 13.500.000 төгрөг авсан. Нутаг усаа тавьж өгчихөөд ийм мөнгө авч байна. Энэ мөнгө амьжиргаагаа дээшлүүлэхэд хаанаа ч хүрэхгүй мөнгө. Малаа өсгөж байсан бол сайхан амьдарч байх байсан. Үнэхээр их хохирч байна. Айлууд мал маллах аргагүй болоод төв рүү орж ажилгүй хүний тоонд орж байна даа.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавхлант багийн малчин)

Зун намрын бэлчээрээ алдсан. Зуслан намаржаа онгоц буудлын талбайд орсон. Дээрээс зөвшөөрсөн, энд онгоцны буудал баригдана шүү л гэсэн. Бэлчээр нутаг хомсдож, малаа цөөлж байгаа. Оюу толгойгоос 7.5 сая төгрөгний нөхөн олговор өгсөн. Энэ мөнгөөр нь банкны зээлээ дарсан. Манайхыг ажлын байраар хангасан. Сардаа 450 мянган төгрөгний цалин авдаг

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Гавилууд багийн малчин)

Уул уурхайн үйл ажиллагааны хор хохирлыг хамгийн их амсаж байгаа Цогтцэций сумын нөлөөлөлд өртсөн гэж хариулсан малчдаас дөнгөж 5 малчин нөхөн олговор авч байгаагаас хоёр малчин нэг жилийн гэрээ хийсэн үлдсэн гурав малчинтай огт гэрээ хийгээгүй гэж хариулжээ. Эндээс харахад нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын бодлогын хувьд компаниуд харилцан адилгүйгээр нийгмийн хариуцлагаа ухамсарлаж байна. Ялангуяа жилдээ 10 гаруй мянган тонн нүүрс экспорлодог Энержи ресурс, Таван толгой, Эрдэнэс таван толгой компани бүхэл бүтэн нэг сумын 4000-5000 гаруй иргэний эрүүл саруул аж төрөх, амьжиргааны хүрэлцээтэй түвшинд аж төрөх, газар нутгаа чөлөөтэй сонгон мал аж ахуйгаа эрхлэх, газар өмчлөх, амьд явах эрхэд нь сөрөг үр дагавар үзүүлж байгаа атлаа нийгмийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй компанийн бодлого, арга хэмжээ хангалтгүй түвшинд байгаа нь судалгаанд оролцогчдын өгсөн мэдээллээс харагдаж байна. Тэрчлэн судалгаанд хамрагдсан малчид нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, хохирол барагдуулах чиглэлээр компанийн авч байгаа арга хэмжээнд сэтгэл хангалуун бус байгаагаа байнга илэрхийлж байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Жишээ 4.30


Нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан 14 айлд 11 худаг ус гаргасан ч одоо ажиллаж байгаа нь нэг л худаг, бусад нь усгүй болгосон.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавхлант багийн малчид)

Чинхуа МАК 6 малчныг нүүлгэн шилжүүлсэн, нэгд нь хашаа байшин барьж өгсөн, нөгөөд хашаа худаг барьж өгсөн. Аваар осол их гардаг, гэрийнх нь гадуур машинтай давхиж зам гаргадаг. Хавь ойрын 2-3 айл өвөлжих аргагүй болсон, бэлчээр усгүй болсон айлууд нөхөн төлбөр нэхдэг. Нөхөн олговор, үнэ мөнгөө тохирдоггүй.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавхлант багийн малчид)

Эдгээр компаниудын хэрэгжүүлж буй бодлого уул уурхайн үйлдвэрлэл эхлэхээс өмнөх амьжиргааны түвшинтэй харьцуулахад хэр зэрэг үр дүнтэй байгааг тодруулах зорилгоор “Нөхөн төлбөр таны өмнөх амьжиргаатай харьцуулахад хэр үэрэг баталгаатай арга хэмжээ болж чадсан бэ?” гэдэг асуултаар тодорхойлсон юм.



Нөхөн төлбөр авч байгаа Ханбогд, Цогтцэций сумын 15 малчин бүгд авч буй нөхөн төлбөртөө сэтгэл дундуур байгаа нь 40 хувь нь өмнөх амьжиргаатай харьцуулбал бага, 33 хувь нь дунд зэрэг, 27 хувь нь маш бага байна гэж үзэж байгаагаас харагдаж байна. Чанарын судалгаанд хамрагдсан малчид нутаг ус, бэлчээр, ус, ургамал дээр нь МАА-гаа эрхэлж чадахгүйд хүрч байгаатай харьцуулбал уул уурхайн компаниудын өгч байгаа нөхөн төлбөр бага байна хэмээн үзэж байлаа.

Судалгааны дүнгээс харахад уул уурхайн сөрөг нөлөөлөлд өртсөн малчид бэлэн мөнгө, ажлын байраар хангагдах, хүүхдийн сургалтын төлбөр, хичээлийн хэрэглэл, шатахуун түлшээр хангуулах зэрэг хэлбэрээр нөхөн төлбөр авч байгааг судалгааны дүн харуулж байгаа ба авч буй нөхөн төлбөртөө төдийлөн сэтгэл хангалуун бус байгаагаа бэлчээрийн МАА-гаа эрхэлж чадахгүйд хүрч, өвөлжөө бууцгүй болсонтой холбон ойлгож байгаа нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл хэзээ нэгэн цагт уурхай хаахад МАА эрхлэхээс өөрөөр амьдрах ур чадварт суралцаагүй малчдын хувьд нөхөн төлбөр нь амьжиргааны тогтвортой эх үүсвэр биш хэмээн үзэж байлаа.

Хэдийгээр авч буй нөхөн төлбөртөө сэтгэл хангалуун бус байгаа ч нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрийн талаарх малчдын санаа бодлыг судалсан судалгааны дүнг доорх хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 4.12 Нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан малчдын нүүлгэн шилжүүлэлийн үр дагаврын талаарх малчдын санаа бодол (n=25)

Өөрчлөлт	Хувь	Бэрхшээл	Хувь
Малын хашаа саравч	26.3	Мал идээшиж дассан газраасаа нүүсэн	40.0
Худаг ус	33.3	Үе уламжлан нутагласан өвөлжөө бууцаа алдсан	40.0
Ажлын байр	73.3	Малын хашаа саравч тохь тух муу	13.0
Хүүхдийн сургалт	33.3	Холоос малаа усалдаг болсон	13.3
Бэлэн мөнгө	26.7	Малын тоо цөөрсөн	33.3
Ямар ч өөрчлөлт гараагүй, сөрөг нөлөөтэй арга хэмжээ болсон	6.7	Өрхийн орлого буурсан	20.0
		Бэлчээрийн МАА-гаа эрхлэх аргагүйд хүрсэн	86.7

Тайлбар: Олон сонголттой хариултын хувилбараар хариулав.

Нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрт хамрагдсан нөлөөллийн бүс дэх айл өрхүүдийн хувьд уул уурхайн компанид ажлын байраар хангагдсан тохиолдлын эзлэх хувь давтамж нийт хариултуудын дотор өндөр ажиглагдлаа. Нөлөөлөлд өртсөн малчдыг замын цэвэрлэгч, мэдээлэл, зар түгээх ажлын байраар хангаж байгаа нь Ханбогдын жишээн дээр түгээмэл илэрч байлаа. Цогтцэций сумын хувьд хашаа, саравч барьж өгөх, худаг ус гаргах, ажилд оруулах зэрэг арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүлсэн нь судалгааны дүнгээс тодорхой байна.

Нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрт хамрагдан нөхөн төлбөр авч байгаа 25 айл өрхийн дийлэнх нь буюу 13 малчин бэлчээрийн МАА-гаа эрхлэх аргагүй нөхцөл байдалд орсныг өөртөө тулгарч байгаа бэрхшээлийн тоонд оруулсан нь өндөр давтамжтай илэрч байгааг хүснэгтээс харж болно. Судалгааны үр дүнгийн шинжилгээр судалгаанд хамрагдсан бүх малчид энэ л асуудалд хамгийн их сэтгэл дундуур байгаа нь тоон болон чанарын судалгаагаар илэрч байгаа билээ. Түүнчлэн орон нутгийн удирдлага ч үүнийг хүлээн зөвшөөрсөн мэдээллүүдийг өгч байсан болно.

Уул уурхайн компаниудын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн төлбөрийн зохицуулалт, үйл ажиллагааг судалсан судалгааны дүнгээс харахад эхний шатанд компани үнэлгээ судалгаа, бодлого, арга хэмжээгээ боловсруулсны дараа малчдыг оролцуулж хэлэлцүүлэг зохион байгуулах, санал авах зэргээр оролцооны механизмыг хэрэгжүүлж байгаа нь малчинд төдийгүй компанид ч хүндрэл үүсгэж байгаа нь харагдаж байна. Оюу толгой, Энержи ресурс ХХК нь нөлөөллийн бүс тогтоох, нөлөөлөлд өртсөн малчдын өвөлжөө хаваржаа, эд хөрөнгийн нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо малчидтай зөвшилцөлд хүрсэн арга замаар шийдэж чадахгүй байгаа нь судалгаанд хамрагдсан компанийн ажилтнууд, малчдын өгсөн мэдээллээс харагдлаа. Оюу толгой ХХК-ийн хувьд орон нутгийн ЗДТГ-тай хамтран ажилласан нь сайн туршлага ч малчдын оролцоог орон нутгийн удирдлагыг оролцуулсаны адил түвшинд эхнээс нь оролцуулж зөвшилцөөгүй нь малчид нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын арга хэмжээнд сэтгэл ханамжгүй үлдэхэд хүргэжээ.

Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээс гадна өмнө байсан амьдралын нөхцөл байдлыг дордуулж байна уу эсвэл сайжруулж байна уу, эзэмшиж байгаа өвөлжөө, тэрхүү эзэмшиж байгаа газартаа өмчилж буй эд хөрөнгөнд нь ямар нөлөө үзүүлэх, хөрөнгө нь хэдээр үнэлэгдэх вэ гэдэг асуудлыг эрх ашиг нь хөндөгдөж байгаа тал буюу малчинтай заавал ярилцаж, зөвшилцөж байж шийдсэний дараа уул уурхайн компанийн үйл ажиллагаа явагдах ёстой. Уул уурхайн төсөл, барилга, тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь тухайн малчны эзэмшил, өмчлөл дэх эд хөрөнгө, аюулгүй байдлыг дордуулсан үйл ажиллагаа явуулбал зөвшөөрөхгүй байх эрх нь бий. Хэрэв энэ эрхийг нь уул уурхайн компаниуд хангахгүй тохиолдолд Үндсэн хуульд заасанчлан төрийн захиргааны байгууллагууд иргэнийхээ хөндөгдсөн эрхийг хангаж хамгаалах үүргийг хүлээх ёстой.

Цаашид уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн малчдын нөхөн олговрын зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ нүүн шилжихэд нь туслалцаа үзүүлэх, нүүн шилжих хүртэл байх нөхцөл байдлыг хангах, амьжиргааг дэмжих зэрэгтэй нь хамтад нь шийдвэрлэх шаардлагатай байна.

Нөхөн олговор

Алдсан газар, үл хөдлөх хөрөнгийг нөхөн орлуулалтын эсхүл зах зээлийн үнийн аль их байгаагаар тооцож учирсан хохирол, алдагдлыг нөхөн олгоход шаардлагатай мөнгөн дүн болон цалин хөлс, аж ахуйн үйл ажиллагааны ашиг, нүүх, завсрын үеийн ба амьжиргааг дэмжих туслалцааг хэлнэ.

Нөхөн олговрын үнэлгээ

- Зах зээлийн үнэ
- Нөхөн орлуулалтын үнэ- Алдсан газар, үл хөдлөх хөрөнгийг дахин бий болгоход шаардагдах хөрөнгийн хэмжээг буюу алдсан хөрөнгөтэй ойролцоо хэмжээ, чанар, нөхцөл байршилтай барилга байгууламжийг бий болгох үнэ цэнэ

Нөхөн олговрын төрлүүд

- Нүүлгэн шилжих туслалцаа гэдэгт унаа тээвэр, ачих буулгах, очих газрыг бэлдэх, хөгжүүлэх газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийг шилжүүлэх татвар, хураамж зэрэг захиргааны зардал
- Завсрын үеийн туслалцаа гэдэгт нүүн шилжих хүртэлх байх орон байр, нүүн шилжихээс шалтгаалан алдаж буй цалин хөлс, аж ахуйн үйл ажиллагааны ашиг
- Амьжиргааг дэмжих арга хэмжээнд нүүн шилжсэний дараах амьдралаа хэвийн болгон тохижиж бизнесийн үйл ажиллагаагаа дахин эхлүүлж тогтворжуулах, мал сүрэг шилжин очсон нутаг оронд идээших дасах хугацаанд үзүүлэх туслалцаа, бууц хөрсөн хуримтлуулах, бизнес эрхлэх, ажил хөдөлмөр эрхлэх-сургалт мэргэжилмэргэшил олгох

Эх сурвалж: Газар албадан чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн баримт бичиг, АХБ-ны Нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлж, ашиглах төсөл, 2012

Дээрх хуулийн төслийн хэлэлцүүлгийн баримт бичгээс харахад уул уурхайн компаниуд нөлөөлөлд өртсөн орон нутгийн малчдад нүүлгэн шилжих үе, нүүн шилжих завсрын үе болон амьжиргааг дэмжих зэрэг нөхөн олговрын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хэрэгцээтэй ажээ.


4.5 Нөлөөллийн бүсэд оршин суугаа малчдын болон малын эрүүл мэндэд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө

Эрүүл мэндийн яам, Фрейзерийн их сургуулийн “Ханбогд суманд уул уурхайн салбарын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх” (2011) тандалт чанарын судалгаагаар Өмнөговь аймгийн уул уурхайн нөлөөллийн сумдад хүн амын өвчлөлийн шалтгаанд амьсгалын эрхтэн тогтолцоо, хоол боловсруулах тогтолцоо, шээс бэлэгсийн тогтолцоо, цусны эргэлтийн тогтолцоо, бэртэл хордлого тэргүүлж байгаа нь улсын дүнтэй адил түвшинд байна гэж дүгнэжээ. Өмнөговь аймгийн эрүүл мэндийн газрын мэдээгээр, аймгийн хэмжээнд нас баралтын шалтгааны хамгийн их хувийг амьсгалын замын өвчлөл эзэлж, бэртэл хордлогийн шалтгаант нас баралт нэмэгдсэн, Цогтцэций, Ханбогд сумын иргэд тоосжилтоос үүдэлтэй амьсгалын зам, уушгины өвчлөлөөр аймагтаа тэргүүлж байгааг тэмдэглэжээ.

2010 оны “Хүний хөгжлийн илтгэл”-ийн илтгэлд “Уул уурхай ба тогтвортой хөгжил” нэмэлт судалгааны тайланд Өмнөговь аймагт түгээмэл 10 өвчний нэгдүгээрт амьсгалын тогтолцооны өвчин орж байгаа бөгөөд 2007 онд 10000 хүн ам тутамд 1148.5 өвчлөлт бүртгэгдсэн байсан бол 2009 онд 2188,8 болж даруй хоёр дахин өсчээ. Энэ үзүүлэлтийг улсын хэмжээний нийт ийм төрлийн өвчлөлтэй харьцуулахад 3.5 дахин их байгаа нь харуулж байна.

Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций сумын нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ууд Үндсэн хуулиар баталгаажсан хүний амьд

явах, эрүүл аюулгүй орчинд аж төрөх, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг ноцтойгоор зөрчиж байгааг тоон болон чанарын судалгааны үр дүн давхар баталгаажуулж байна. Цогтцэций сумаас Цагаанхад баг хүртэл нийт 245 километр нүүрсний зам дагуу нутаглаж буй Ханбогд, Цогтцэций сумын малчдын амь нас, эрүүл мэнд, амьдрах нөхцөлд нүүрсний олборлолт, тээвэрлэлтийн компаниуд хэр зэрэг сөрөг нөлөө үзүүлж байгааг дараах зурагт харуулав.



Судалгаанд хамрагдсан хоёр малчин тутмын нэг нь уул уурхайн нөлөөллийн бүс орчим болон малчдын өвөлжөө, хаваржаа, намаржааны бэлчээрийг дайран өнгөрч байгаа тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөний улмаас тоос тоосжилт ихсэж хүн, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Судалгаанд оролцсон малчдын дийлэнх нь буюу 96 хувь нь нүүрсний зам дагуу нутаглаж буй орон нутгийн иргэд зам тээврийн ослоор бэртэж гэмтэн, дайруулдаг, судалгаанд хамрагдсан малчдын 66 хувь нь мөн дээрхийн адил шалтгаанаар мал бэртэж гэмтэн дайруулдаг гэсэн хариултыг өгчээ.

Жишээ 4.31

Мал дайруулах ердийн үзэгдэл. Мал дайрчихаад мөнгө цаас өгөхөөсөө өгөхгүй нь их. Өрөмдлөгийн үйл ажиллагаа явуулахдаа нүх ухаад ус хийдэг. Өрөм дуусаад явахдаа нөхөн сэргээлтээ хийдэггүй, айлын мал өрөм тавьж байсан усанд нь орж үхдэг. 2010 онд Оюу толгой ХХК-ийн нисэх онгоцны буудлын талбайг уснаас хамгаалсан суваг руу миний анх удаагаа ботголох гэж байсан ингэ орж үхсэн. Оюу толгой ХХК-ийн Олон нийттэй харилцах хэлтэст мэдэгдэж тэд ирж үзээд үнээ тохирьё гэсэн. Миний ботго манай гэр бүлд их ашиг өгөх байсан тул 5 сая төгрөгөөр үнэлэхэд Оюу толгой ХХК 800.000 төгрөг гэсэн. Би ботгоныхоо үнийг нэмнэ гээд 1,6 сая төгрөг авсан.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавхлант багийн малчин)

2012 онд Оюу толгой төслийн агаарын чанарын суурь судалгааны дүнгээр нүүрсний зам дагуу болон уул уурхайн орчим нутагладаг малчид нарийн ширхэгт тоосонцороор амьсгалж, эрүүл мэндийн хувьд эрсдэлт нөхцөл бүрэлдсэнийг хүлээн зөвшөөрснийг харуулж байна.


Тэрчлэн уул уурхайн компанийн химийн бодисын хэрэглээ, хадгалалт, устгал зайлуулалтын мэдээлэл ялангуяа хүн, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй бодис байгаа эсэхэд хяналт тавьж байгаа мэргэжлийн байгууллага, орон нутгийн удирдлага байхгүй байна. Ашигт малтмалын тухай хууль, Агаарын

тухай, Химийн хорт бодис хэрэглэх тухай, Ариун цэврийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний тухай хуулинд төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг заасан ч хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг давхар харуулж байна.

Шороон замаар хийгдэж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хаягдал хадгалах байгууламж, уурхайн бүтээн байгуулалт, барилгын үеийн тоосжилт, уурхайн хаягдал чулуулгийн овоолго, талхлагдсан говийн эмзэг хөрснөөс 1-100 хүртэлх микрон хэмжээтэй нарийн ширхэгт тоосонцор үүсдэг ба үүнийг хүн, мал амьсгалснаар хүний мөгөөрсөн хоолойд гэмтэл учруулж уушгины бронхит үүсгэдэг. Нарийн ширхэгтэй тоосонцор нь хүний уушгинд үлдсэнээр амьсгалах эрхтэнг гэмтээдэг. Уул уурхайд ашиглагдаж байгаа дотоод шаталтат тоног төхөөрөмжүүд (уурын зуух, цахилгаан станц) болон хүнд оврын тээврийн хэрэгслүүд зэрэг эх үүсвэрээс хорт бодис агаарт ялгардаг. Агаарт NO₂, SO₂ болон CO зэрэг бодисын хэмжээ ихэссэнээр хүний эрүүл мэнд доройтож, эрсдэлд ордог. Ерөнхийдөө талхлагдсан бэлчээр, уул уурхайн хайгуул, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихтэй газруудад болон зам, хайгуулын түр суурин, өрмийн талбай зэрэг хөндөгдсөн газруудын орчимд тоосжилтын агууламж өндөр гарчээ.

(Эх сурвалж: Агаарын чанарын суурь үнэлгээ, Оюу толгой төсөл, 2012)

Гурвантэс, Ханбогд сумтай харьцуулахад Цогтцэций сумын иргэдийн эрүүл мэндэд уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөө илүү ажиглагдаж байгааг аймаг, сумын эрүүл мэндийн статистик үзүүлэлт давхар баталгаажуулж байна.



Цогтцэций суманд нүүрсний тээвэрлэлтийн замын осол, уул уурхайн үйлдвэрлэлийн ослын тоо зөвхөн нэг жилийн дотор 5 дахин нэмэгдсэн, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл мөн нэг жилийн дотор 2.5 дахин нэмэгдснийг харвал нөлөөллийн бүсэд нутагладаг иргэдийн эрүүл мэндэд уул уурхайн үзүүлэх хор хохирол асар их болсныг харуулж байна. Цаашид сумын түвшинд зам тээвэр, үйлдвэрийн осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлого, амьсгалын замын өвчин, халдварт өвчин, тоосжилт, тоосонцор, харшил, нүдний өвчин зэрэг уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөс шалтгаалсан өвчлөлийн мэдээллийг сум, багаар нь ангилан бүртгэлжүүлэх шаардлагатай байна. Ерөнхийдөө уул уурхайн нөлөөллийн бүс болох Ханбогд, Цогтцэций суманд уул уурхайн сөрөг

нөлөөлөлтэй холбоотой асуудлаар эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, хүний эрхийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, судалгааны байгууллага, төрийн бус байгууллага хяналт шалгалт, судалгаа хийдэг ч нөхцөл байдал сайжрахгүй улам бүр дордож байгааг судалгаанд оролцогчид тэмдэглэж байв.

Жишээ 4.32

Манай эмнэлэг Цогтцэций сумын 4047 ам, явуулын 8200 хүнд үйлчилж байна. Тоосжилт, осол аваар, амьсгалын замын өвчин их байна. Сумын төвөөр хүнд даацын машин их явдаг. БЗДХ өвчлөл их байна. ДОХ гарахад ойрхон болж байна. Манай сумын эрүүл мэндийн үзүүлэлтээр нэгдүгээгт осол, хоёрдугаарт амьсгалын өвчин орж байна. Мөн уул уурхайн компаниуд хүмүүсийг уртасгасан цагаар ажиллуулснаар даралт, зүрх, цусан хангамжийн дутагдал өвчин ихэссэн. Олон дарга нар ирдэг. Олон удаа судалгаа авч байсан. Үр дүн алга, одоо хүртэл өөрчлөгдсөн юм алга. Энэ судалгаа үр дүнгээ өгөөсэй л гэж найдаж байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Эмнэлгийн эрхлэгч)

Өглөө, оройдоо тоосонд булагдаад л амьдарч байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Гавилууд багийн малчин)

ОТ төслийн “Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал” суурь үнэлгээний тайланд⁶ Өмнөговь аймагт амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин нь үндэсний түвшнээс илүү өндөр хувьтай байгаа ба эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүд санаа зовоож буй усны чанар муудсанаас үүдсэн хоол боловсруулах системийн өвчлөлт болон тоос шорооноос шалтгаалсан астма, бронхит өвчнүүд ихэссэнийг нэмж нэрлэсэн бол нутгийн малчидтай хийсэн ярилцлагаар тоос шороотой орчин болон усны чанар муудсантай холбоотойгоор эрүүл мэнддээ санаа зовж байгааг дурьджээ.

Судалгааны явцад мэдээлэл өгсөн оролцогч талууд уул уурхайн сөрөг нөлөөллийн хүн, малын эрүүл мэндэд үзүүлж байгаа олон жишээ баримтыг хэлж байсан ч өнөөдрийг хүртэл уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр малын дотор эрхтэн өвчилсөн, гажигтай төл төрсөн, мал хордож үхснийг мэргэжлийн байгууллагын нотолгоонд суурилсан дүгнэлтээр тогтоосон тохиолдол байхгүй байна. Иймд уул уурхайн шууд болон шууд бус нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ, орчны нийгмийн нөлөөллийн үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллага нь цаг алдалгүй хийх нь нэн тулгамдсан асуудал болсныг судалгаанд оролцогчдын өгсөн мэдээлэл харуулж байна.

Жишээ 4.33

Хүн малын эрүүл мэнд маш их дордож байна. Аваар осол ч их гарч байна, уурхайнууд маш их нууцалдаг. Хүний эрүүл мэндэд санаа тавьж хийж хэрэгжүүлж байгаа ажил огт байхгүй. Оюу толгой өөрийн замаа байнга усалдаг, гэтэл нутгийн ард иргэдэд босгосон тоосны төлөө ямар ч арга хэмжээ авдаггүй.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавхлант баг)

Хонь ямаа тас хар болсон. Ноос нь даагддаггүй. Нүүрс, тоос шороо шигсэн байдаг. Мал саахаар малын дэлэн хөх, гар тас хар болдог.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Сийрэст багийн малчин)

Энержи ресурс, 5 толгой трансн жолооч нар цэвэр усны сав, ариун цэврийн цаасаа шууд хаядаг. амны ус авдаг худагт нүүрстэй гараа шууд угаадаг, худгийн ам тагладаггүй.

⁶ ОТ ХХК, БОННБУ, 2012

Хог хаягдал маш их. Айлын худгийн амыг дайрдаг.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Гавилууд багийн малчин)

Хүнд даацын машин, механизмуудын тээвэрлэлтээс үүссэн тоос шороо бэлчээр дэх ургамлыг дарж, бохирдуулдаг.

(ОТ ХХК, БОННБУ, 2012)

Судалгаагаар уул уурхайн компани хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тухайн уул уурхайн орчинд амьдарч байгаа иргэдийн эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлэх вэ, сөрөг нөлөөллийг бууруулахын тулд юу хийх, нөлөөллийг бууруулахад хэр хэмжээний хөрөнгө оруулалт хийх, зэрэг асуудлын талаар мэдээлэл өгч эдгээр асуудлын хүрээнд тэдэнтэй зөвлөлдөж, харилцан тохиролцдог практик огт байхгүй байна. Уул уурхайн компани ажилчдынхаа эрүүл мэндийг хариуцдаг атлаа нутаг орных нь баялгийг аваад дээр нь эрүүл мэндэд нь тооцоолох боломжгүй хор хөнөөл учруулж байгаа ийм нийтлэг дүр төрх сүүлийн 4-5 жилийн туршид ажиглагдаж байгаа ч одоог хүртэл эрүүл мэндийн холбогдох хууль тогтоомжид үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэндэд учруулж буй нөлөөлөлд үнэлгээг хийх тухай заалт байхгүй хэвээр байсаар байна.

Гадаад орны туршлагаар уул уурхайн компаниуд нийт хөрөнгө оруулалтын 1.5 хувийг нийгэм, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулахад зарцуулдаг. Уул уурхайн үйл ажиллагаанаас болж орон нутгийн иргэд, нөлөөлөлд өртсөн иргэдэд учрах үр нөлөө, хор хохирлыг урьдчилан бодитойгоор тооцох боломжгүй ч уул уурхайн иргэдийн хэрэгцээнд үндэслэн компани, иргэд хоорондоо зөвшилцөж тогтоодог. Өөрөөр хэлбэл энэ зөвшилцөл нь нөлөөлөлд өртсөн иргэдийн эрүүл мэндийн үнэлгээ биш, эрүүл мэндээ алдсан учраас компанийн зүгээс оруулж байгаа хөрөнгө оруулалт гэдэг утгаар иргэдтэй хэлэлцдэг.

Гэтэл судалгаа явагдсан 3 уурхайн жишээн дээр уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн хүний эрүүл мэндэд учирч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр дорвитой авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байхгүй байгааг судалгааны дүн харуулж байна. Харин ч жилээс жилд уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас эрүүл мэндээрээ хохирч байгаа хүмүүсийн тоо өсөх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээгээр Ханбогд суманд халдварт өвчний тархалтын хандлага 2005 онд 10,000 хүн ам тутамд 11 байсан бол 2006 онд 21 хүн, 2007 онд 11, 2008 онд 20, харин 2009 онд 22 болж өөрчлөгджээ. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар Ханбогд суманд халдварт өвчлөлт тархахад Хятад улстай хил залгаа байдал, Гашуун-Сухайтын шалган нэвтрүүлэх боомт ачаалал, Тавантолгойн нүүрсний тээвэрлэлт Ханбогд сумаар дамжин өнгөрдөг, агаарын болон газрын тээвэрлэлт голлон нөлөөлж байна гэж дүгнэжээ. Мөн тус суманд 2011 нэгдүгээр сараас гурван сарын сүүл хүртэл өвчлөлтийн 567 тохиолдол бүртгэгдсэн нь аймгийн хэмжээнд өвчлөлийн тоогоор тэргүүлсэн бол 2010 онд гэмтэл, хордлогын эсвэл бусад ослоос шалтгаалсан 16 тохиолдол бүртгэгдсэн нь аймгийн хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлтүүдийн нэг болжээ.

Хэлэлцүүлгийн явцад төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын нөлөөгөөр астма болон бронхит зэрэг өвчлөлүүд гарч буй талаарх санал гомдол малчдын зүгээс ахин дахин гарчээ⁷.

Жишээ 4.34

2012 оны 5-р сард малчдын амьдралын хэв маяг, эрүүл мэндэд учруулсан хохирлыг барагдуул гэдэг шаардлага ОТ ХХК, орон нутгийн удирдлагад тавьж байсан. Үр дүн байхгүй. Орон нутгийн удирдлага хариу өгөхдөө “Та нарт юу нөлөөлөөд байгаа юм, барилга дуусангуут эргээд л хэвэндээ орно” гэдэг.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавхлант багийн малчин)

Нүүрсний замын ойр 10 жил нутаглаж байна. Транс, Энержи ресурс ХХК-ийн нүүрсний цувааны дуу чимээн дунд тоос манан дотор амьдардаг. 2010 оны 8-р сард хятадуудын ухсан газарт ус тогтсон, мал уугаад дундарсаны дараа хэр гүн байгааг мэдэх гэж 17 настай хүү морьтойгоо ороод нас барсан. Хятадууд аль компанийн шугамаар яах гэж ухсныг мэдэхгүй.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавхлант багийн малчин)

Матриц 4.3 Уул уурхайн нөлөөллийн бүс дэх малчин өрх болон малын эрүүл мэндийн байдал

Нөлөөлөл	Нөлөөллийн үзүүлэлтүүд
Уул уурхайн үйл ажиллагааны хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөө	
Хүнд даацын тээвэр	- Уурхай байгуулагдсан газарт болон салхин талд 30 км орчим зайд амьдардаг малчдын амьдрах орчинд тоосжилт үүссэн - Тээврийн замд хүний амь нас хохирч байна
Тоос тоосжилтоос үүдсэн өвчлөл	- Зам дагуух болон нисэх буудал, гүний хоолой, цахилгаан дамжуулах шугам барих явцад тоос, түйрэн дунд аж төрж байна - Амьсгалын замын өвчлөл - Нүдний өвчин - Харшил
Коксийн үйлдвэрийн утаанаас үүдсэн өвчлөл	- Үйлдвэрийн салхин доор байгаа иргэдийн дунд амьсгалын замын өвчлөл, харшил, хамар хоолойн өвчлөл ихсэж байна
Уурхайн хог хаягдлаас үүдсэн өвчлөл	- Халдварт өвчин гарах магадлал нэмэгдсэн - Бохирдсон хөрс, газарт ариутгал, халдваргүйжилт хийхгүй байгаагаас үүдсэн өвчлөл бий болж байна
Уурхайн усны хэт хэрэглээ	- Хүн ам ундны усаар гачигдаж эхэлсэн - Нөлөөллийн бүсэд худаг нь орсоноос ундны усаа холоос авдаг болсон
Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж	- Уул уурхайн бүс нутагт түр шилжих хөдөлгөөн, хөдөлгөөнт хүн ам нэмэгдэж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт хүрэлцээ хангалтгүй - Сумын эмнэлэг ачаалал нэмэгдсэн - Эрүүл мэндийн шатахууны төсөв хүрэлцэхээ байсан
Нүүр олборлолт тэсэлгээ, тээвэрлэлтийн нөлөө	- Хөрс, бэлчээр бохирдож хүний хоол хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөөлж байна - Чимээ шуугиан ихэсч мэдрэлийн ядаргаа, мэдрэлийн гаралтай өвчлөл нэмэгдэж байна - Тээврийн жолооч нар хог хаягдлаа малын бэлчээр,

⁷ ОТ ХХК, БОННБУ, 2012

	худаг усанд хаяж хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байна.
Бага насны охидын жирэмслэлт	- Бага насны охидын жирэмслэлт нэмэгдсэн
Уул уурхайн нөлөөлөлд өртсөн малчдад шаардлагатай байгаа эмнэлгийн тусламж үйлчилгээ	- Хүний эрүүл мэндийн лабораторийн болон рентген оношлогоо - Харшлын сорилууд - Урьдчилан сэргийлэх үзлэг - Сайн дурын зөвлөгөө шинжилгээ өгөх төв - Мэдээлэл сургалт сурталчилгааны төв
Уул уурхайн үйл ажиллагааны малын эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөө	
Малын хорогдол	- Замд дайруулж олноороо мал үхэх болсон - Зам дээр хүн мал, амьтан гаталдаг гарц байхгүй
Уурхай болон тээвэрлэлтийн явцад бий болж буй тоосжилтоос үүдсэн өвчлөл	- Малын дотор эрхтэн - Малын нүдний өвчлөл ихэссэн - Малын догол өвчин нэмэгдсэн - Төрөлхийн гажигтай мал төрдөг болсон
Уурхайн үйлдвэрлэлийн хатуу хог хаягдлаас үүдсэн сөрөг нөлөө	- Мал цаас, гялгар уут идэж түгжрэх, элэг дэлүү, уушиг зэрэг дотор эрхтний өвчлөл нэмэгдэж байна - Уурхайн хаягдлын даланд мал унаж үхсэн - Мал хаягдлын даланд хуримтлуулсан шингэнээс уудаг

Эх сурвалж: Сумын эмч нар, малчидтай хийсэн ярилцлагын үр дүн

Жишээ 4.35

Ухаа худгийн уурхай сумын төвөөс 5 километр, уурхайн отвал (шороон овоолго) сумын төвд ойртож байна. Сумын төв үргэлж шороон шуурга, тоосон дунд амьдарч эрүүл амьдрах хүний эрх зөрчигдөж байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сумын иргэд)

Энержи ресурс ХХК болон Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж байгаа бусад уул уурхайн компанийн бэлчээрийн МАА, малчдад үзүүлж буй сөрөг нөлөөлөл нь их байгаа атлаа эрүүл мэндийн нөлөөллийг авч үзэхэд туйлын хайнга хандаж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Уул уурхайн компанийн сөрөг үйл ажиллагааны улмаас бий болж буй тоос тоожилт, тоосонцорын хүний эрүүл мэндэд үзүүлж буй хор хөнөөлийг үнэлэх, эрүүл мэндийн хохирлын үнэлгээг тооцох, эрүүл мэндийн нөхөн төлбөр зэрэг асуудал нь олон жилээр хуримтлагдсан тулгамдсан асуудал болсныг ЭМЯ, орон нутгийн удирдлага, малчидтай хийсэн ярилцлагын дүн харуулж байна.

Жишээ 4.36

Ус, тоосжилтыг хэмжих багаж төхөөрөмж хангалтгүй байгаа. Удахгүй тоосжилтыг хэмждэг сайн багаж төхөөрөмж авчирна. Тоос юунаас үүсээд байна вэ? Үүнийг хэн зохицуулах вэ? Цогтцэцийд олон нүүрс тээвэрлэлтийн компани байгаа, хэн нь үүсгээд байгаа юм бэ. Уг нь хотжилтын асуудлыг сум орон нутаг нь шийдэх ёстой. Харин ч Энержи ресурс ХХК нь Цогтцэцийг ус, цахилгаанаар хангаж байна. Цогтцэцийд хүн ам нэмэгдэж, хүн бүр машинтай болж байгаа нь тоосжилтыг бий болгож байна. Говь угаасаа хуурай, цөлөрхөг газар тул угаасаа шороогоор шуурч байдаг онцлогтой. Дээр нь уурхай, машины тоос нэмэгдэж байгаа. Үнэндээ Улаанбаатар хот ч мөн адил тоостой.

(Ганцаарчилсан ярилцлага, Энержи ресурс ХХК, ОННХ-ийн ажилтан)

Энэ олон компаниуд бүгд тоос гаргаж байгаа, аль нь хүний эрүүл мэндэд нөлөө үзүүлж байгааг ЭМЯ тогтоох байх.

(Ганцаарчилсан ярилцлага, ОТ ХХК, ОННХ-ийн ажилтан)

Уул уурхайн компаниудын барилгажилт, тээвэрлэлтийн явцад үүсч байгаа тоос тоосжилтод эзэн олдохгүй шинжтэй болж байгаа нь дээрх жишээнээс харагдаж байна.

Судалгааны дүнгээс харахад олон жил яригдсан, мэдээлэгдсэн уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад бий болж байгаа тоос, тоосонцорыг орчин үеийн багаж тоног төхөөрөмжөөр, нөлөөллийн бүсэд үнэн зөв хэмжих, улмаар энэхүү тоос тоосонцорын хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг тогтоох, тоос тоосонцороос үүсч байгаа өвчлөлийн хяналт тандалт судалгааг мэргэжлийн яам нь ядахдаа хийж эхлээсэй гэсэн хүлээлт малчид, орон нутгийн захиргааны байгууллага, уул уурхайн компанийн аль алинд байгаа нь судалгаагаар харагдаж байлаа. Цаашлаад уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэндэд үзүүлж буй хуримтлагдсан нөлөөллийг үнэлэх, хүний эрүүл мэндэд үзүүлсэн хохирлын нөхөн төлбөрийн асуудлыг хүртэл зохицуулах шаардлага гарч ирж байна. Холбогдох хуулинд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө, хор хохирол үзүүлсэн тохиолдолд нөхөн төлбөр тооцох зохицуулалт байхгүй, харин эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл учруулсан нь нотлогдвол тухайн буруутай байгууллагад нь хариуцлага тооцох заалт л байдаг байна.

Жишээ 4.37

Хүний эрүүл мэндэд анхаарал тавиасай. Малтайгаа адил уушигтай болчих вий дээ гэж их санаа зовж байна даа.


(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Гавилууд сумын малчин)

БҮЛЭГ 5. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсийн байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг судалсан судалгааны үр дүнг танилцуулж байна.

5.1 Нөлөөллийн бүсийн экосистемийн төлөв байдал

Нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа судалгаанд хамрагдсан нийт 50 малчны 36 нь буюу 72 хувь нь уугуул нутгийнхаа экосистем, байгаль орчны төлөв байдлыг маш их доройтсон хэмээн хариулжээ. Нөлөөллийн бүсийн экосистем маш их доройтож байгааг Ханбогд, Цогтцэций сумдын малчид илүүтэй үзсэн нь уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөний үр дагаварт илүүтэй өртөж байгаагаар тайлбарлагдаж байна.



Тэрчлэн чанарын судалгаанд хамрагдсан орон нутгийн удирдлага, асуудал хариуцсан мэргэжилтнүүд, ТББ, малчидтай хийсэн ганцаарчилсан болон чанарын судалгааны ярилцлагад хийсэн дүн шинжилгээгээр мөн л уул уурхайн бүс дэх байгаль орчин хурдацтайгаар доройтож байна гэж үзсэн нь нийтлэг ажиглагдсан тоон судалгааны үр дүнг давхар баталгаажуулж байна.

Жишээ 5.1

Энержи ресурс ХХК нүүрс угаах үйлдвэр байгуулснаар хүчтэй насосоор 11 газраас ус татаж байна. Ингэснээр гүний усгүй боллоо, 10 гаруй өнгөний худаг усгүй боллоо, 80 метрийн гүнээс гоождог байсан даралттай ус татарч эхэлсэн. Энержи ресурс компани хар замаар явж байгаа. Бусад нь хулгайгаар олон салаа зам гаргаж явдаг. Сийрэст багийн газар нутгийн 60-70 хувь нь лицензийн талбайд орж талхагдсан, олон салаа зам гарч хэрсэн. Манай баг 2009 онд 40 мянга гаруй малтай байсан бол одоо 18 мянган малтай болсон. Уул уурхай, зуд хавсарсан. 98 малчин өрх байснаас одоо 40 малчин өрх байна. Малчид нэг айлдаа малаа тавиад өөрсдөө сумын төв рүү орж байна. Уугуул иргэдийн эрх ашиг маш их зөрчигдөж байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Сийрэст багийн малчин)

Уул уурхай усны венийн судсан дээр өрөм тавьж усны түвшин доошилж байна. Хамгийн санаа зовоож байгаа зүйл 3 жилийн дараа усгүй хатна гэдгийг мэдсээр байж юу ч хийхгүй байна. Усыг химийн аргаар гаргаад ирэхгүй шүү дээ. Экологийн тэнцвэрт байдал алдагдаж олон машины утаа тоосон дунд холилдон амьдарч байна. Уул уурхайд бэлчээр, ус, малчин хүнд хэрэгтэй хамаг юмаа алдаж байгаа улс уул уурхайгаар хөгжинө гэж байхгүй. Уул уурхайгаас малчин хүнд наалдсан юм алга харин өвөлжөө бууц, эрүүл мэндээрээ хохирч байна.


(Ганцаарчилсан ярилцлага, Гурвантэс сум, Тост багийн малчин)

Оюу толгой ХХК асар олон цооног ухсантай холбоотой ус татарч мал хүнгүй уух усгүй боллоо. ОНТРЭ компани хаа сайгүй дураараа явж өрөмддөг, канал ухдаг. Оюу толгой ХХК-ийн тээвэрлэлт хийдэг машин шороон замаар явж тоос түйрэнгээр булдаг, мал идэхийн аргагүйгээр өвс ургамал, бэлчээр тоосонд дарагдсан. Нөхцөл байдал ийм болоод байгааг дээр дооргүй мэдээд байгаа хэрнээ арга хэмжээ авахгүй байгааг ойлгохгүй байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Гавилууд багийн малчин)

Нутгийн иргэдийн үзэж байгаагаар хамгийн сайхан устай, бэлчээртэй, ургамалтай, ан амьтантай байгалийн үзэсгэлэнтэй газар нутагт нь уул уурхайн компани хайгуул, олборлолт, тээвэрлэлт хийж байгаль орчныг сүйтгэж улмаар нутгийн малчин өрх айлууд уул уурхайн компанид шахагдаж нүүсээр мал аж ахуйгаа эрхлэх боломжгүй болж, ухсан нүх, өвчтэй хүн, мал үлдэж байна хэмээн чанарын судалгаанд оролцогчид үзлээ.

Зураг 5.2-т харуулснаар, судалгаанд хамрагдсан нөлөөллийн бүс дэх малчдын 78-84 хувь нь байгаль орчны доройтолд уул уурхайн үйлдвэрлэл, нүүрсний тээвэрлэлт нь хамгийн их сөрөг нөлөө үзүүлж байна гэж хариулсан нь хамгийн өндөр давтамжтай үзүүлэлт болж байна. Үүний дараагаар Ханбогд суманд үйл ажиллагаа явуулж байгаа Оюу толгой төсөл, Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж байгаа МАК, Чинхуа МАК, Өмнийн говийн элс нүүрсний компани, Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж байгаа Ухаа худаг төсөл, Эрдэнэс таван толгой, Таван толгой компаниудын үйл ажиллагаа нөлөөллийн бүсийн байгаль орчин, экосистемийн доройтолд хамгийн их сөрөг нөлөө үзүүлж байна гэж хариулжээ.



Гурвантэс сумын нөлөөллийн бүсэд амьдарч байгаа хоёр малчин тутмын нэг нь МАК, Чинхуа МАК, Өмнийн говийн элс, Жавхлант орд, Зэлмэ компанийн явуулж байгаа үйл ажиллагаа байгаль орчинд маш их сөрөг нөлөө үзүүлж байгаа нь хүн, тоос тоосжилт ихэссэн, бэлчээр талхлагдсан, усны түвшин багассан зэрэг шалтгаантай холбон тайлбарлалаа.

Хүснэгт 5.1 Нөлөөллийн бүсийн байгаль орчинд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө, Гурвантэс сумын малчдын өгсөн үнэлгээ

Сонгосон үзүүлэлтээр	Гурвантэс			
	Маш их сөрөг	Ер нь сөрөг	Сөрөг нөлөө бага	Мэдэхгүй
Уул уурхайн үйлдвэрлэл	62.5	37.5	-	-
Энержи ресурс, Таван толгой, Эрдэнэс 5 толгой ХХК	6.3	62.5	31.3	-
Оюу толгой ХХК	0.0	68.8	31.3	-
МАК, Чинхуа МАК, Өмнийн говийн элс, Жавхлант орд, Зэлмэ	50.0	50.0	-	-
Үйлдвэрийн хог хаягдал, овоолго	12.5	25.0	6.3	56.3
Тээвэрлэлтийн компани	75.0	-	-	25.0

Ханбогд сумын судалгаанд хамрагдсан малчдын 83 хувь нь уурхайн нүүрсний болон тээвэрлэлт гүйцэтгэдэг компаниудын тээврийн үйл ажиллагаа, 78 хувь нь уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, 72.2 хувь нь Оюу толгой төслийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотойгоор амьдарч буй нутаг орны байгаль орчин маш ихээр доройтож байгаа нь нөлөөлж байна гэж үзлээ. Нүүрсний зам дагуу нутагладаг Ханбогд сумын Жавхлант, Цагаанхад, Гавилууд багийн 40 гаруй малчин өрх нь Оюу толгой, Энержи ресурс, Таван толгой, Эрдэнэс таван толгойн нүүрс тээвэрлэлтийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөлөлд илүүтэй өртөж байна.

Хүснэгт 5.2 Нөлөөллийн бүсийн байгаль орчинд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө, Ханбогд сумын малчдын өгсөн үнэлгээ

Сонгосон үзүүлэлтээр	Ханбогд			
	Маш их сөрөг	Ер нь сөрөг	Сөрөг нөлөө бага	Мэдэхгүй
Уул уурхайн үйлдвэрлэл	77.8	22.2	-	-
Энержи ресурс, Таван толгой, Эрдэнэс 5 толгой ХХК	38.9	61.1	-	-
Оюу толгой ХХК	72.2	27.8	-	-
МАК, Чинхуа МАК, Өмнийн говийн элс, Жавхлант орд, Зэлмэ	5.6	83.3	11.1	-
Үйлдвэрийн хог хаягдал, овоолго	33.3	27.8	22.0	16.7
Тээвэрлэлтийн компани	83.0	11.1	5.6	-

Гурвантэс, Ханбогд сумтай харьцуулахад Цогтцэций сум бүхэлдээ уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн золиос болж байгаа нь судалгаанд хамрагдсан 16 малчны 15 нь тээвэрлэлтийн компани, уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөгөөр байгаль орчин маш их доройтож байна гэж хариулжээ. Энержи ресурс, Таван толгой, Эрдэнэс 5 толгой ХХК мөн 50 гаруй тээвэрлэлтийн компани Цогтцэций сумын нутгийг дайран өнгөрч байгаа нь байгаль орчинд уул уурхайн үйлдвэрлэл хамгийн их хор хохиролтой гэж үзэхэд хүргэж байна. Цогтцэций сумын төвөөс 2 километрийн зайд Энержи ресурс компанийн хөрс хуулалтын овоолго нурууг үүсгэж байгаа нь сумын төвийн орчимд тоос тоосжилт ихэссэнд иргэд шүүмжилттэй хандаж байв. Цогтцэций сумын байгаль орчны нөхцөл байдал байгаль орчин, эрүүл мэндийн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэд дахин их бохирдолтой, нөлөөллийн түвшин нь өндөр байгааг бусад судалгааны дүн ч харуулаад байгаа билээ.

Хүснэгт 5.3 Нөлөөллийн бүсийн байгаль орчинд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө, Цогтцэций сумын малчдын өгсөн үнэлгээ

Сонгосон үзүүлэлтээр	Цогтцэций		
	Маш их сөрөг	Ер нь сөрөг	Сөрөг нөлөө бага
Уул уурхайн үйлдвэрлэл	93.8	6.3	-
Энержи ресурс, Таван толгой, Эрдэнэс 5 толгой ХХК	75.0	25.0	-
Оюу толгой ХХК	6.3	93.8	-
МАК, Чинхуа МАК, Өмнийн говийн элс, Жавхлант орд, Зэлмэ	-	100.0	-
Үйлдвэрийн хог хаягдал, овоолго	68.8	18.8	12.5
Тээвэрлэлтийн компани	93.8	6.2	-

Хууль зүйн үндэсний төвийн судалгаагаар Таван Толгойн нүүрсийг БНХАУ-ын хил хүртэл 240 км урт, 32 салаа замаар 80-100 тоннын хүнд даацын машинаар стандартын хучлагагүй ил задгай нүүрс тээвэрлэж байгаа, том уурхай тус бүрийн дэргэд нисэх онгоцны буудал байгуулснаас говийн нутгийн хөрс ба ургамал бүрхүүл эвдэрч, бэлчээр, хадлангийн газрын тоосжилтын хэмжээ хүн, мал ба амьтан амьдрах боломжгүй түвшинд хүрснээр “нүүрсний замын” дагуу аж төрж байсан иргэд шахагдан гарч “дүрвэгсэд” бий болж байна” гэж дүгнэсэн нь дээрх судалгааны дүнг давхар баталгаажуулж байв.

Харин орчны бохирдолд нөлөө үзүүлж байгаа уул уурхайн компани тодруулбал Энержи ресурс компанийн төлөөллийн өгсөн мэдээллээр, зам тавьсан, сумын

төвийн иргэдийг цэвэр усаар хангасан, сум хур хогийг цэвэрлэх зэргээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч тулгамдсан асуудлыг шийдэж байна гэж хариуллаа.



Хэдийгээр Энержи ресурс ХХК нийгмийн хариуцлагаа ухамсарлан уул уурхайн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч байгаа ч энэ нь сум орон нутгийн иргэдэд учруулсан сөрөг нөлөө, хор хохиролтой харьцуулахад хангалтгүй хэмээн үзэж байгааг бүлгийн ярилцлагад оролцогчдын өгсөн мэдээлэл харуулж байна.

Уул уурхайн үйл ажиллагаа нөлөөллийн бүс нутгийн байгалийн нөөцүүд, мал, ан амьтанд хэр зэрэг нөлөө үзүүлж байгааг судалгаанд оролцогчдын санаа бодолд тулгуурлан үнэлүүлэхэд дараах үр дүн харагдаж байна. Гурвантэс сумын хувьд уул уурхайн сөрөг нөлөөгөөр ус, усны нөөцийн асуудал сэтгэл зовоох хэмжээнд хүрсэн нь нийт судалгаанд оролцогчдын 87.5 хувь нь уул уурхайн компанийн усны хэрэглээнээс үүдэлтэйгээр гүний болон өнгөний ус шавхагдаж байгаатай холбоотойгоор ингэж үзэж байлаа.

Хүснэгт 5.4 Нөлөөллийн бүсийн байгалийн нөөц, мал, ан амьтанд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө, Гурвантэс сумын малчдын өгсөн үнэлгээ

Сонгосон үзүүлэлтээр	Гурвантэс		
	Маш их сөрөг	Ер нь сөрөг	Сөрөг нөлөө бага
Ус, усны нөөц	87.5	12.5	-
Хөрс, ургамлын төрөл	68.8	31.3	-
Мал	43.8	43.8	12.5
Ан амьтан	62.5	37.5	-
Агаар	75.0	25.0	-
Газрын дээрх болон доорх баялаг	37.5	31.3	31.3
Хөрс	75.0	25.0	-
Бэлчээр	68.8	31.3	-

Ханбогд суманд уул уурхайн үйл ажиллагаагаар бэлчээрийн талхлагдал хамгийн ноцтой хэмжээнд хүрсэн гэж үзэж байгаа бөгөөд бэлчээр байгалийн нөөцөд дулдуйдан 4 улирлаар малаа хариулдаг онцлогтой малчдын хувьд бэлчээртээ хамгийн их санаа зовж байгаа нь харагдаж байна. Ханбогд сумын Жавхлант, Гавилууд, Цагаанхад багийн малын бэлчээрийн 70-80 хувь нь доройтолд орсон төдийгүй сүүлийн жилүүдэд бэлчээрийн хомсдол, тоос тоосжилтын нөлөөгөөр мал, малчны тоо ч ихээхэн буурч байгааг тус багийн Засаг дарга нар тэмдэглэж байв.

Хүснэгт 5.5 Нөлөөллийн бүсийн байгалийн нөөц, мал, ан амьтанд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө, Ханбогд сумын малчдын өгсөн үнэлгээ

Сонгосон үзүүлэлтээр	Ханбогд		
	Маш их сөрөг	Ер нь сөрөг	Сөрөг нөлөө бага
Ус, усны нөөц	83.3	16.7	-
Хөрс, ургамлын төрөл	66.7	33.3	-
Мал	83.3	16.7	-
Ан амьтан	77.8	16.7	5.6
Агаар	83.3	16.7	-
Газрын дээрх болон доорх баялаг	50.0	44.4	4.6
Хөрс	83.3	16.7	-
Бэлчээр	100.0	-	-

Цогтцэций суманд уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөгөөр тоос тоосжилтын асуудал нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа малчдад хамгийн дарамт болж байгааг судалгааны дүн харуулж байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон малчид бүгд санал нэгтгэйгээр тоос тоосжилт, бэлчээр, усан хангамжид уул уурхайн үйл ажиллагаа хамгийн ихээр сөрөг нөлөө үзүүлж байгааг хүлээн зөвшөөрчээ.

Хүснэгт 5.6 Нөлөөллийн бүсийн байгалийн нөөц, мал, ан амьтанд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө, Цогтцэций сумын малчдын өгсөн үнэлгээ

Сонгосон үзүүлэлтээр	Цогтцэций	
	Маш их сөрөг	Ер нь сөрөг
Ус, усны нөөц	93.8	6.2
Хөрс, ургамлын төрөл	81.3	18.2
Мал	93.8	6.2
Ан амьтан	93.8	6.2
Агаар	100.0	-
Газрын дээрх болон доорх баялаг	81.3	18.2
Хөрс	100.0	-
Бэлчээр	100.0	-

Тоон судалгааны үр дүнг баталгаажуулсан чанарын судалгааны үр дүнг доорх матрицад харуулж байна.

Матриц 5.1 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсийн байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө, сумдаар

Сум	Байгалийн нөөц	Сөрөг нөлөөлөл
Гурвантэс	Бэлчээр	- Урт, Тост багийн газар нутгийн дийлэнх нь лицензийн талбайд орсон
		- Малын бэлчээр хомсдож байна.
	Ус	- Усны түвшин жилээс жилд багасаж байна
		- Усны хайгуул, өрөмдлөг хийж ус, бэлчээрийг талхалж байна.
Ханбогд	Ургамал	- Ургамлын төрөл зүйл багассан - Хөрсний эвдрэл маш их болсон
	Ан амьтан	- Дуу чимээ, тоосжилтоос болж ан амьтан дайжсан
	Ан амьтан	- Ан амьтад үргэж дайжсан
	Ус	- Гар худгийн ус ширгэсэн

		<ul style="list-style-type: none"> - Оюу толгой хэд хэдэн газраас гүний хоолойгоор ус татаж усны түвшин, хөрс, бэлчээрийг талхалж байна
	Бэлчээр, газрын хөрс	<ul style="list-style-type: none"> - Тоосжилт, бэлчээр, ургамал, ан амьтанд маш их сөрөг нөлөө үзүүлж байна \ургамал тоосонд дарагдсан\ - Зөвшөөрөөгүй газар өрөмдлөг хийж, карьер ухаж байгаль орчныг маш их сүйтгэж байна - Жавхланта, Гавилууд, Цагаан хадны айлууд малын бэлчээргүй, өвөлжөө, хаваржаа, намаржааны газаргүй болсон
Цогтцэций	Бэлчээр, ургамал	<ul style="list-style-type: none"> - Хөрс, бэлчээрийн 80 хувь талхлагдалд мал аж ахуй эрхлэх аргагүй нөхцөл байдалтай болсон - Ургамал, үндэс ургах нөхцөлгүй болсон - Ургамал тоос, шороонд дарагдсан - Цагаан-Овоо, Сийрст зэрэг бэлчээрийн гол бүс нутаг бэлчээргүй болсон - Нүүрсний тээвэрлэлт хийж байгаа компаниуд зөвшөөрөлгүй карьер ухаж, өрөмдлөг хийх, түгээмэл тархацтай байгалийн баялаг ашиглах нь нийтлэг болсон - Малчдын нийтээр эзэмшдэг зуслан намаржаа, хаваржааны бэлчээр талхлагдалд орсон
	Агаар	<ul style="list-style-type: none"> - Тоосжилт гамшгийн хэмжээнд хүрсэн \сумын төв, нөлөөллийн бүс\ - Тоосжилтоос болж хүн, малын халдварт өвчнүүд байнга гарах болсон - Малыг уушиг, ходоод, дотор эрхтэн битүүрсэн, гажигтай төл төрдөг болсон - Мал маллах аргагүй болсон
	Ус	<ul style="list-style-type: none"> - Сум тойрсон худгууд ширгэсэн - Баян булаг, задгай ус ширгэсэн
	Ан амьтан	<ul style="list-style-type: none"> - Ан амьтан дайжсан

Оюу толгой, Энержи ресурс, Таван толгой, Эрдэнэс таван толгой, МАК зэрэг уул уурхайн туслан гүйцэтгэх гэрээт компани, ААНБ-ууд толгой компаниасаа илүү байгаль орчин, бэлчээрийн МАА-д хор хөнөөлтэй үйл ажиллагааг ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр явуулдаг нь ердийн үзэгдэл болсныг чанарын судалгааны үрд дүн харуулж байна. Эдгээр компани нь аль уул уурхайн гэрээт компани болох, ямар зөвшөөрөлийг хэн хаанаас өгсөн нь мэдэгддэггүй нь сум орон нутгийн холбогдох хүмүүс хариуцлага тооцох, арга хэмжээ авахад хүндрэл учруулж байгааг бүлгийн ярилцлагад оролцсон байгаль орчны байцаагч, газрын даамал нар тэмдэглэж байв.

Жишээ 5.2

Манай өвөлжөө хайгуулын лицензэд орсон. Өвөлжөөний хажууд хэлэхгүйгээр өрөм тавьдаг. Ногоо ургахаа байсан. 2 жилийн өмнө бэлчээрийн газарт хайгуулын өрөм тавиад машин тэргээрээ хайр найргүй явж сүйтгэсэн. Өрөмдсөн, цооног гаргасан нүхээ булалгүй тэр хэвээр нь орхиод явдаг. Одоо манайх зун болчихоод байхад зусланд буухын аргагүй болсон тул өвөлжөөндөө сууж байна. Гол горхи, модтой Баянбүрд уул уурхайнхны балгаар байхгүй болсон. Хээрийн амьтан хулан зээр байхгүй болсон. Уул уурхайн компанийнхан худлаа сайхан амалдаг.

(Ганцаарчилсан ярилцлага, Гурвантэс сум, Баясах багийн малчин)

Уул уурхайн салбарын үйл ажиллагаа хэр зэрэг эрчимтэй явагдана тэр хэмжээгээр байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа ба байгаль орчинд үзүүлж байгаа их хэмжээний сөрөг нөлөөлөл нь малчдын эрүүл мэнд, амьжиргаанд хүндээр тусч байна.

5.3 Нөлөөллийн бүсийн усны нөөцөд уул уурхайн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөө

Уул уурхайн үйл ажиллагаагаар ойн нөөц хомсдох, ургамлын сан хөмрөг устгах, газар, газрын хэвлий эвдэгдэх, хөрсний үржил шим алдагдах, усны нөөц багасах, ан амьтан устаж үгүй болох, дайжих, агаар, ус, хөрс бохирдох зэрэг байгаль орчинд олон сөрөг нөлөө үзүүлдэг. Ялангуяа ус, бэлчээрээ дагаж нүүдэллэдэг говийн малчдын хамгийн их сэтгэл зовдог асуудал нь усан хангамж, усны нөөц. Говь нутаг нь гадаргуугийн урсацгүй, агаарын хур тунадас маш бага унадаг энэ бүс нутгийн ус хангамжийн ганц эх үүсвэр нь газар доорх ус юм.

Судалгаанд хамрагдсан Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс суманд уул уурхайн үйлдвэрлэл явуулж буй ОТ, Энержи ресурс, МАК ХХК усны хэрэглээ жилээс жилд нэмэгдэж байгаа нь ус ашиглалтын байдал, улсын төсөвт төвлөрүүлсэн усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээнээс харж болно. Жишээлбэл Оюу толгой ХХК 2010 онд 0.48 сая метр квадрат ус, 2011 онд 2.3 сая метр квадрат ус хэрэглэсэн үзүүлэлттэй байгаагаас үзвэл зөвхөн нэг жилийн дотор тус компанийн усны хэрэглээ 4 дахин нэмэгдснийг харуулж байна. (Усны газар, 2011) Усны мэргэжилтнүүд говийн бүсэд одоогоор нээгдээд байгаа байгалийн баялагийг бүрэн ашиглахад одоогийн судлагдсан газрын доорхи ус хүрэлцэхгүй хэмээн үзэж байна.

Жишээ 5.3

Оюу толгой төслийн хүрээнд Гүний хоолойн ус татах байгууламжаас хоногт 77760м³ ус олборлох хүчин чадалтай , 28 худаг, 5 ус өргөх станц, өргөлтөөр авах, тус бүр нь 200 мянган м³ багтаамжтай 2 ус хуримтлуулах цөөрөмтэй. 2011оны 8-р сараас Гүний хоолойн ус ашиглалт эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 5-р цацрагийн 10 худгийг Оюу толгой төслийн Ус цэвэршүүлэх ба савлах байгууламж, ус хуримтлуулах цөөрөм, барилгын ажлын усны хэрэгцээнд ашиглаж эхлээд байна. 2011 онд 2.3 сая м³/жил ус ашигласан байна. (6300 м³/хоног 72.9 л/с)

(Усны газар, 2011)

Энэ судалгаагаар нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа малчид, орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдийн өгсөн мэдээлэлд тулгуурлан уул уурхайн үйл ажиллагааны усан хангамж, усны нөөцөд үзүүлж буй нөлөөллийг судалсан судалгааны дүнг танилцуулж байна. Дээр дурдсанчлан нийт судалгаанд хамрагдсан малчдын 88 хувь нь уул уурхайн компаниудын ус ашиглалттай холбоотой усны нөөц багасаж, ус хомсдож байна хэмээн үзэж байна.

Чанарын судалгаанд хамрагдсан малчдын дийлэнх нь энгийн хийцтэй гар худгийн усны түвшин доошилсон, мал усалж дийлэхээ байсан гэсэн мэдээллийг өгч байлаа. Жилээс жилд усны нөөц багасаж, задгай ус, гол горхи ширгэж байгаагийн шалтгааныг уул уурхайн үйл ажиллагааны сөрөг үр дагавартай холбон тайлбарлав. Уул уурхайн компаниуд гүний хоолойгоор дамжуулан ус татаж үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэглэж байгааг буруутгах хандлага түгээмэл ажиглагдлаа.

Жишээ 5.4

ОТ ХХК гүний өрмийн ус татаад авсан. Уудаг ус ширгэж байна. Ус багасч байгаа нь ОТ ХХК хайгуулын асар олон цооног хийсэнтэй холбоотой.


(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавхлант багийн малчин)

5.3 Уул уурхайн компанийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа ба орон нутгийн иргэдийн сэтгэл ханамж

Уул уурхайн нөхөн сэргээлт нь уул уурхайн үйл ажиллагааны явцад эвдэгдсэн байгаль орчныг сэргээж байгалийн тогтвортой байдлыг хангах, бүс нутгийг эргээд хүн суурьшихад аюулгүй болгох, тухайн газар орны урт удаан хугацааны экологийн тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой.

Нөхөн сэргээлт нь уул уурхайн салбарын компанийн нийгмийн хариуцлагын салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд бол орон нутаг, иргэд малчдын зүгээс нөхөн сэргээлтийн хөтөлбөр үйл явцад оролцох оролцоо маш чухал байдаг.

Монгол Улсын хөгжилд уул уурхайн салбар чухал байр суурь эзэлж байгаа боловч экологийн хувьд олон тулгамдсан асуудал үүсч, байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж, газрын хэвлийг ухсан нүх, овоолго, хөндий болгож, гол, горхийг ширгээн, ус, агаар, хөрсийг бохирдуулан ургамлан бүрхэвчийг доройтуулж талхлан, тухайн орчинд амьдардаг хүмүүсийн аж амьдралд өөрчлөлт оруулж, малын бэлчээр нутгийг шахах, сүйтгэх, ан амьтныг дайжуулах зэргээр сөрөг нөлөөлөл үзүүлснээр байгалийн даац, зохистой ашиглах хэмжээнээс хэтэрч, хүндрэл бэрхшээл учруулсаар байгаа талаар нутгийн иргэд, малчид эмзэглэж байгаагаа илэрхийлж байна.



Судалгааны хамрагдсан Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд байгаль орчинд нөхөн сэргээлт хийж байгаа эсэхийг малчдаас тандахад 40 хувь нөхөн сэргээлт нэр төдийхөн хийдэг бол гурваны нэг нь огт хийдэггүй гэж хариулсан байхад 14 хувь иргэд, малчдыг уул уурхайн үнэлгээ хяналтын үйл ажиллагаанд оролцуулдаггүй тул нөхөн сэргээлтийн талаар ямарч мэдлэг мэдээлэл байхгүй байна. Харин иргэд, малчдын 14 хувь л нөхөн сэргээлтийг хуулийн дагуу хийж байгаа хэмээн үнэлсэн бөгөөд тэдгээр

компаниуд нь техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхдээ ухсан нүхээ булж үрслэгээ заг, бударгана тарьдаг байна.



Тухайлбал, Оюу Толгой төслийн байнгын онгоцны буудал баригдах хүртэл хугацаанд түр ашиглах “Оюут” орон нутгийн онгоцны буудлыг 2010 оны 9-р сард ашиглалтанд оруулсан байна. Уг онгоцны буудлын барилгын ажлын явцад 77 га орчим газрын хөрсийг хөндсөн. Тиймээс хууль журмын дагуу ОТ төслийн Байгаль орчны хэлтэс, ОНХТХ хэлтэс хамтран нийт 65 га талбайд 975 кг нутгийн ургамлын үр цацаж биологийн нөхөн сэргээлт хийсэн. Цацсан үрийг бог малын хөлөөр гишгүүлж нягтруулсан. Энэ ажилд онгоцны буудлын ойр орчимд амьдардаг 12 малчин өөрсдийн санаачлагаар хамтран оролцсон нь цаашид төслөөс хэрэгжүүлэх байгаль орчны нөхөн сэргээлтийн ажилд орон нутгийн иргэдийн оролцоог хангах эхлэл боллоо. (Орон нутгийн харилцаа тогтвортой

хөгжлийн хэлтсийн 2010 оны жилийн тайлан. ОТ. 2010)

Хүснэгт 5.7 Уул уурхайн компаниуд байгаль орчинд нөхөн сэргээлт хийдэг эсэх, сумдаар

Сонгосон үзүүлэлтээр	Гурвантэс	Ханбогд	Цогтцэций	Нийт
Нөхөн сэргээлтийг хуулийн дагуу хийдэг	-	3	3	6
Хагас дутуу хийсэн нэртэй болдог	2	11	7	20
Огт хийдэггүй	13	1	3	17
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийхэд иргэд, малчдыг оролцуулдаггүй тул мэдэхгүй	1	3	3	7
Нийт	16	18	16	50

Хүснэгт дэх мэдээллээс харахад, уул уурхайн компаниуд байгаль орчинд нөхөн сэргээлт огт хийгээгүй хэмээн хариулсан малчдын ихэнх буюу 13 нь Гурвантэс суманд нутагладаг малчид ийнхүү үзэж байгаагаас харахад төвөөс алслагдмал сум орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд нөхөн сэргээлтэнд төдийлөн анхаарал тавьдаггүй нь харагдаж байна.

Жишээ 5.5
 Зэлмэ компани ноднин өрөм хийсэн газартаа нөхөн сэргээлт хийгээгүй. Уул сэтэлж зам гаргаад хогоо цэвэрлээгүй, нүхээ булаагүй, газар нутгийг сүйтгэсэн. Уул уурхайн компаниуд байгаль орчноо хайр гамгүй ухаж төнхчихөөд эргээд нөхөн сэргээлтдээ үнэхээр хойрго ханддаг. Нүхнүүдээ таглаагүй, онгорхой орхисон. Тэр хавиар нь 25 малчин өрх нутагладаг
 (Ганцаарчилсан ярилцлага. Гурвантэс сум)

Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны талаарх орон нутгийн иргэдийн санал бодлыг багцлан үзвээс, нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийдэггүй, уул уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд оролцуулдаггүй,

иргэдийн хяналтыг тавиулах сонирхолгүй, байгаль хамгаалах бүлгүүд чадавх сул, иргэдийн оролцоо байхгүй, нөхөн сэргээлтийн талаар мэдээлэл хомс зэрэг бэрхшээл дутагдлуудыг илэрхийлсэн байна.

5.4 Канад, Австрали улсад уугуул иргэд, уул уурхайн компанийн зөвшилцлөөр нөхөн төлбөрийг шийдвэрлэсэн сайн туршлага⁸

Уул уурхайн нөлөөгөөр уламжлалт ёсоор тухайн газар нутгийг эзэмшиж байсан орон нутгийн хүмүүсийн мэдлэг өөрчлөгддөг. Жишээ нь улирлын чанартайгаар малаа оторлуулж өвөлжүүлж, аль эсвэл зусдаг байсан тэр газар нь уурхайн газар болоход орон нутгийн иргэд тэрхүү газраа бэлчээрийн зорилгоор хэрэглэхээ больсноор отор хийх, өвөлжих, зусах зэрэгт өөрчлөлт гарсан нь тэдэнд алдагдал болж байна. Учир нь тэр газар бэлчээрийн биш уурхайн газар болсны улмаас МАА-д болон орон нутгийн хүмүүст сөрөг нөлөөлөл, алдагдал бий болдог.

Бэлчээрийн газраа ашиглан мал сүргээ өсгөж үржүүлж үр ашгийг нь үргэлжлүүлэх нөхцөл байдал нь алдагдаж энэ нь бас тэдний хувьд уул уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалсан хохирол болж байна.

Хуучин байдлаараа эзэмшин ашиглаж байсан газар нутаг болон орон нутаг өөрчлөгдөх нь бас алдагдал хохирол болж байна. Яагаад гэвэл тэдний хүрээлэн буй хөрш зэргэлдээ болон тэдэнд хамааралтай зүйлс нь өөрчлөгдсөнөөр сэтгэл зүйн хямрал стресс уялдан гарч ирдэг.

Native title-ийн хуулийн дагуу бол уул уурхайн компани нь тэр үнэт олдвор газрыг олоод орон нутгийн иргэдтэй зөвшилцөн зөвшөөрөл хүлээн авах хүртэл үйл ажиллагаагаа эхлэх ёсгүй юм. Native title-ийн зардалийн үнэ ханш нь уул уурхайн компани болон тухайн олдвор олдсон орон нутгийн төлөөлөгчдийн хооронд харицан үнэ тохирох хэрэгтэй. Хэрвээ тэд хоорондоо зөвшилцөлд хүрэхгүй бол шүүхээр шийдэгддэг байна.

Тэрхүү харилцан тохиролцсон зардалд гарах нийт үнэ нь орон нутгийн иргэдээр тодорхойлогдсон маш өргөн хүрээтэй нийгмийн зардлыг хамарч тооцсон байх ёстой. Уул уурхайн компани үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө орон нутаг, орон нутгийн иргэдээр зөвшөөрөгдөн батлагдах учир тэдний харилцан тохиролцсон үнэ ханш нь орон нутгийнхний сэтгэл санаанд хүрсэн төдийгүй бас уул уурхайн компани үйл ажиллагаагаа явуулах явцад үүдэн гарах нийгмийн зардлыг хангалттай төлж барагдуулах ёстой. Жишээ нь Австрали, Канад дахь Native title-ууд нь Монголд ийм маягийн нийгмийн зардлыг нөхөн төлж барагдуулах төлбөр\зардлыг байж болно гэсэн жишээ юм. Үүний дагуу энэ нь Монгол дахь уул уурхайн төслүүд эсвэл уурхайн үйлдвэрлэлийн салбарын зардалд МАА, орон нутгийн иргэдэд үзүүлж байгаа нийгмийн нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулах зардлыг тооцсон байх ёстой бөгөөд орон нутгийн иргэдтэй энэ асуудлаар зөвшилцөх ёстой.

Сүүлийн 15 жилийн туршид өөрөөр хэлбэл Австрали дахь Native title-ууд үнэ хаялцан солилцоход гарсан түүхэнд ойролцоогоор дундчилж төлөх төлбөрийн хэмжээг тухайн уурхайг ашиглаж эхлэхээс хаагдах хүртэл тооцон гаргасан нийт бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.5 хувиар бодож тогтоодог байна. Энэ нь бүдүүвчилсэн тооцоо бөгөөд ингэж тооцсоноор МАА-д үзүүлж буй сөрөг нөлөөлөл,

⁸ Paul Burke (2002) *How can judges calculate Native title compensation*

нүүдлийн соёл уламжлалын алдагдлын нийгмийн төлбөрийг тогтооход бас нэг баримжаа болж өгч байгаа юм.

Монгол Австрали хоёрын нөхцөл байдал ялгаатай ч соёлын алдагдал гэж нэрлэгдэж байгаа нийгмийн сөрөг нөлөө, хор хохирлын зардлыг уул уурхайн компанийн дотоод зардалд төлөвлүүлэх боломжтой. Хэрвээ уул уурхайн компаниас үүдэн гарч байгаа нийгмийн сөрөг нөлөөлөл, үр дагаврыг 0.5 хувиас дээш бол уламжлал соёлын сөрөг нөлөө, алдагдалтай уялдан гарсан нийгмийн асуудлуудын зардал\төлбөрөөс нь илүүг төлөх хэрэгтэй болдог. Ингэсэн тохиолдолд огт анхаарахгүй байгаа, малчин хүн, орон нутгийн иргэдэд бий болгож байгаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх юм. Өөрөөр хэлбэл уул уурхайн компани орон нутгийн иргэд, МАА-д учруулсан хор хохирлыг төлбөл энэ нь малчдад төдийгүй Монгол улсад цэвэр ашиг болж өгч байна. Хэрвээ уул уурхайн компани нь 0.5 хувиас багийг төлбөл тэр нь Монгол улсад цэвэр ашиг биш, цэвэр хохирол болох юм.

Иймд цаашид нийгмийн хариуцлагатай мөн уул уурхайгаас Монгол улс хэдээр алдаж, хэдээр хожиж байгааг уул уурхайн салбарын нийгэм, эрүүл мэнд, соёл уламжлалын алдагдал зэрэг нийгмийн асуудал дээр тооцох, ингэснээр сөрөг нөлөө, хор хохирлыг арилгах, бууруулах боломж бололцоо бүрдүүлэхэд энэхүү сайн туршлагыг ашиглаж турших хэрэгтэй юм.

БҮЛЭГ 6. УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

6.1 Уул уурхайн үйлдвэрлэлийн орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөө

Энэхүү хэсэгт орон нутгийн нийгэм-эдийн засагт үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөг авч үзэх болно. Юуны түрүүнд судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөө үзүүлсэн болохыг тодруулав. Судалгаанд оролцсон иргэдийн 29 хувь нь уул уурхайн үйлдвэрлэл эрчимжихээс өмнөх үеийн ажил эрхлэлтийн статусаа ямар нэгэн хэлбэрээр өөрчилжээ. Уул уурхайн компаниудын зүгээс нийгмийн үүрэг хариуцлагаа биелүүлэх, орон нутгийн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах үүднээс орон нутгийн иргэдийг ажиллуулахыг чухалчилдаг. Тухайлбал Гурвантэс сумд байрлах МАК-ийн 400 ажилтны 48 нь нутгийн иргэд байна. Хүснэгтээс харахад нийтлэг биш ч, уул уурхайн бүс нутагт хөдөлмөр эрхлэлтийн хувьд төрийн алба, мал аж ахуйн сектороос уул уурхайн салбарт шилжсэн шилжилт илүүтэй ажиглагдаж байна. Хэдийгээр малчдын хувьд уул уурхайн салбарт ажил эрхлэх болж байгаа нь нэг талаас бэлэн мөнгөний тогтвортой эх үүсвэртэй болж байгаагаараа сайн талтай ч, нөгөө талаас уламжлалт ёсоор аж ахуйгаа эрхлэхээс татгалзахад хүрч, улмаар нэр хүнд, цалин хөлсөөр харьцангуй доогуур ажил эрхлэх болж байгааг анхаарах шаардлагатай байна. Нутгийн иргэд цалин хөлс, нэр хүндээр доогуур энгийн хөдөлмөрийн төрлийг төвлөрөн гүйцэтгэснээрээ орон нутгийн тогтвортой хөгжилд хүргэхгүй тул мэргэжлийн ур чадвар олгох, мэргэжлийн боловсрол олгох, дахин бэлтгэхэд тусгайлан анхаарах нь зүйтэй юм.

Жишээ 6.1

Өмнө нь манай баг 98 малчин өрхтэй байсан, одоо 40 болж буурсан. Малчид нэг айлдаа малаа тавиад төврүү орж байна. Хөдөөнөөс малаа барж сумын төвд орж ирээд компанийн барлаг хийдэг. Энержи ресурс ХХК-ийн үйл ажиллагаа эхлэхэд үйлчлэгч байсан хүн одоо ч үйлчлэгч хэвээр байна. Гэтэл гаднаас ирсэн хүмүүс тус компанид ажил хийгээд улам өсөөд дэвжээд байдаг. Уул уурхай хаагдахад бид ухсан нүхэн дээрээ үлдэнэ.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сумын Багийн засаг дарга)

Хүснэгт 6.1 Уул уурхайн үйлдвэрлэл эрчимжсэний дараагаар эрхэлж буй ажлаа өөрчилсөн байдал, хувиар

Ажил мэргэжил	Өссөн	Буурсан
Төрийн албан хаагч	-	2.3
Уул уурхайн ажилтан	7.9	-
Нүүрс тээвэрлэлт	-	0.6
Үйлчилгээ	-	0.6
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	0.6	-
Малчин	-	9.6
Оюутан	-	5.6

Судалгаанд оролцогчдоос уул уурхайн үйлдвэрлэл эрчимжсэнтэй холбоотойгоор тэдгээрийн амьжиргааны түвшинд ямар өөрчлөлт гарсан болохыг тодруулсан юм. Тэдний хариулснаар 44 хувийнх нь амьжиргаанд эерэг, 0.6 хувьд нь сөрөг, харин үлдэх 55 хувьд нь төдийлөн өөрчлөлт гараагүй гэжээ. Иргэдийн амьжиргааны байдалд сөрөг гэхээсээ эерэг өөрчлөлт гарсан нь олзуурхууштай юм. Энэ нь Ханбогд, Цогтцэций сумын төвийн иргэдийн хувьд Оюу толгой, Энержи ресурс, Таван толгой, Эрдэнэс таван толгой болон эдгээр компаниудын гэрээт туслан гүйцэтгэх компанид цэвэрлэгч, үйлчлэгч, жолооч, оператор зэрэг ажлын байраар хангагдаж байгаа, мөн уул уурхайн дам нөлөөгөөр бизнесийн бусад салбарын өсөлттэй холбоотой.

Хэдийгээр уул уурхайн компани орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж байгаа нь орон нутаг уул уурхайн хөгжлийн үр өгөөжийг хүртэж байгаа хэлбэр боловч илүү цагаар ажиллуулах, ажил мэргэжлээрээ өсөх боломжгүй энгийн ажлын байранд бага хөлсөөр ажиллуулах зэргээр Үндсэн хуульд заасан иргэдийн хөдөлмөрлөх эрхийг зөрчих үзэгдэл нийтлэг байгааг чанарын судалгааны дүн харуулж байна. Тэрчлэн Ханбогд сумын судалгаанд хамрагдсан иргэд, зарим төрийн албан хаагчид уурхайд ажиллаж байгаа хятад ажилчдын тоо тогтоосон квотоос давсан төдийгүй Засгийн газрын болон УИХ-ын гишүүдийг ирэх үеэр хятад ажилчдаа нуудаг, мөн Монгол ажилчдын тоог гэрээнд заасан квотод хүргэхийн тулд ажиллуулахгүйгээр сул цалинжуулдаг тухай мэдээллийг өгч байлаа.

Жишээ 6.2

Оюу толгой ХХК-ийн CIS, GDCF, CPCC зэрэг гэрээт компани хүний эрхийг маш ихээр зөрчдөг. Жишээ нь сонгуулийн өдөр сонгууль өгөхөөр явсны төлөө 3 өдрийн ажлын хөлс хасна, ажлаа хийгээд сонгуульд оролцохгүй гэвэл нэг өдрийн хөлс нэмж өгнө. Оюу толгой ХХК-ийн гэрээт компанид ажилчин зуучилдаг “Ханбогд хайрхан” компани байдаг. Энэ компанид ажил хийдэггүй сул цалин авдаг 300 гаруй Монгол иргэд бүртгэлтэй байдаг. Сарын 350000 төгрөгөөр цалинжуулдаг. Дарга нар ирэхээр орон нутгаас компанид ажиллаж байгаа Монгол ажилчдын тоо гэж үзүүлдэг. Зарим компани ажилчин авахдаа МАН-д элсвэл ажилд авна гэдэг. Хотоос ирсэн хамгаалалтын албаныхан (нутгийнхан “Бамбай” нар гэж нэрлэж байлаа) гэр бүл салгаж суудаг. Гэр бүлийг дэмжих бодлого байхгүй компанийн үйл ажиллагаа явуулах эрхийг цуцлах хэрэгтэй.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сумын Засаг даргын орлогч, Багийн засаг дарга)

Уул уурхайн салбарт ажиллагсад гэр бүлээсээ хол удаан хугацааны ростерийн системээр ажилладаг нь уул уурхайн үйлдвэрлэл явагдаж байгаа сум орон нутагт сөргөөр нөлөөлж байгаа нь гэр бүл салгах явдал гарч байна гэж үзсэнээс харагдаж байна. Иймд уул уурхайн компани ажиллагчдын ажил\амралтыг зохицуулах ростерийн системээ богиносгох зэргээр орон нутгийн иргэдийн болон ажиллагчдын гэр бүлийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцлийг хангасан ростерийн системийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Судалгаанд оролцогчид уул уурхайн үйлдвэрлэл нь хөдөлмөр эрхлэлт, худалдаа, хүнсний хангамж, орон нутгийн эдийн засаг, бизнес, ядуурлыг бууруулах, барилгажилт, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ зэрэгт сөрөг гэхээсээ эерэг нөлөө үзүүлж байна гэжээ. Харин байгаль орчин, зам, хүн амын шилжих хөдөлгөөн, бэлчээр, авто осол, бэлчээр, гэр бүл болон гэрлэлтийн харилцаа, мал аж ахуй, авилга болон нийгмийн сөрөг үзэгдэлд (биеэ үнэлэх, хулгай, гэмт хэрэг) уул уурхайн салбарын хөгжил ихээхэн нөлөөтэй хэмээн шүүмжлэнгүй хандсан байна. Харин орон нутгийн цахилгаан хангамжид эерэг буюу сөрөг нөлөө үзүүлж байна хэмээн маргалдах хандлага ажиглагдав.

Судалгаанд хамрагдсан сумд нь уул уурхайн үйлдвэрлэлийн төрөл, гүйцэтгэн ажиллаж буй компаниараа ялгаатай. Гурвантэс сумын төвийн судалгаанд хамрагдсан иргэд орон нутгийн эдийн засаг, бизнес, худалдаа, хөдөлмөр эрхлэлт, хүнсний хангамжид уул уурхайн үйлдвэрлэл нь эерэгээр нөлөөлж байна хэмээн бусад сумдыг бодвол илүү өөдрөгөөр хариулсан байна. Харин Ханбогд сумын төвийн иргэд аж үйлдвэрлэл эрчимжин хөгжиж байгаад эерэгээр ханджээ. Цахилгаан хангамжийн хувьд Цогтцэций болон Гурвантэс сумын төвийн иргэд эерэгээр хандаж байгаа бол Ханбогд сумынхан сөргөөр үнэлж байв. Замын хувьд Цогтцэций, Гурван тэс сумын төвийн иргэд туйлын сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлжээ. Цогтцэций сумын хувьд сургуулийн өмнөх боловсрол, бүрэн дунд сургуулийн үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлж байна гэж үзэх хандлага бусад сумдынхаас бага зэрэг илүү байв. Энэ нь бусад аймаг, сумдаас шилжин ирэх хүн амын хөдөлгөөнтэй холбоотой. Харин Гурвантэс сумынхан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ сайжирч байгаа гэж үзсэн байна. Яах аргагүй Өмнийн говийн элс (SGS) компаниас 100 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг барьж өгсөнтэй холбоотой. Түүнчлэн МАК компани сургууль барихаар ажиллаж байгаа бөгөөд ер нь уул уурхайн компаниудаас орон нутагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахаар томоохон хөрөнгө оруулалтыг хийж байгаа нь сайшаалтай. Цогтцэций болон Гурвантэс сумын төвийн судалгаанд оролцогчид Ханбогдын иргэдээс илүүтэй шилжих хөдөлгөөн, засаглал, төрийн байгууллагын ил тод байдал, авилга, гэр бүл

болон гэрлэлтийн харилцаа, гэмт хэрэгт (авто замын осол, биеэ үнэлэх, хулгай) уул уурхайн салбарын хөгжил сөрөг нөлөөтэй хэмээн дүгнэжээ.

Жишээв 6.3

Манай компани Овоотод 12 айлын орон сууц бариад эхэлсэн. Залуучуудыг дэмжиж байгаа, 320 хүүхдийн сургууль, 120 хүүхдийн цэцэрлэгийн ажил эхэлсэн.

(Ганцаарчилсан ярилцлага, Гурвантэс сум, МАК-ийн уурхайн дарга)

2011 онд 8 тэрбум 7 сая төгрөгийн орлого олсон ч зарцуулах эрхгүй байдаг. 200 сая төгрөг үлддэг. ИХТ, баг сумын Засаг даргын үйл ажиллагааны зардалд явдаг, бусад нь дээшээ явдаг. Орон нутаг тодорхой хувийг зарцуулна гэдэг ч сумын төсвийн хэмжээнээс хэтрүүлж болохгүй гээд хумьчихдаг. Иймд сум орон нутгаа хөгжүүлэх зорилгоор уул уурхайгаас орж ирж байгаа орлогыг зарцуулах эрх байдаггүй.

(Ганцаарчилсан ярилцлага, Гурвантэс сумын багийн Засаг дарга)



Уул уурхайн үйлдвэрлэл эрчимжих болсонд иргэд хэр зэрэг сэтгэл хангалуун байгааг тодруулах нь уул уурхайн үйл ажиллагаа иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж байгааг тодорхой хэмжээгээр харуулах юм. Судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 66 хувь нь ямар нэг хэмжээгээр сэтгэл хангалуун байгаа бол гуравны нэг нь сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлжээ. Сэтгэл хангалуун байгаа эсэх нь сумдын хувьд төдийлөн ялгаатай байгаагүй ч, Ханбогд сумынхны хувьд сэтгэл

хангалуун бус байх нь бусад сумдаас бага зэрэг илүү байв. Энэ нь уул уурхайн компаниудын зүгээс хэрэгжүүлж буй орон нутагт чиглэсэн нийгмийн хөтөлбөрүүд хэр зэрэг хэрэгжиж байгаагаас хамаарч болох юм.

Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй компаниуд орон нутгийн иргэд малчдын хөдөлмөрлөх, сурч боловсрох, эрүүл аюулгүй байх, өрхийн бизнес, өрх гэрийн амьжиргааг дэмжих, хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих зорилгоор нийгмийн олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа нь уул уурхайн салбар хөгжиж байгаагийн давуу тал болж байна. Тухайлбал, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс зэрэг сумдад ажиллаж буй уул уурхайн компаниуд дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байгаа талаар орон нутгийн иргэд мэдээлсэн ба тэдгээрийн хариултыг багцалж доорх хүснэгтэнд харуулав.

Матриц 6.1 Уул уурхайн нөлөөллийн бүс нутагт уул уурхайн компаниудын хэрэгжүүлж буй нийгмийн асуудлыг шийдвэрлэж буй байдал

Сонгосон үзүүлэлтээр	Ханбогд	Цогтцэций	Гурван Тэс
Өрхийн тогтвортой амьжиргаанд дэмжлэг үзүүлэх	+	+	+
Оюутны сургалтын төлбөр төлөх, богино болон урт хугацааны сургалтын төлбөр төлөх	+	+	+
Гэр бүлийн хөгжлийг дэмжих бодлоготой	+		
Ажлын байраар хангах	+	+	+
Орон сууц хөтөлбөртэй	+		
Орон нутгийн бизнесийг хөгжүүлэх хөтөлбөртэй	+		+
Иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад анхаарах	+	+	+
Хөгжлийн хөтөлбөртэй	+		
Соёлын өвийг хамгаалах хөтөлбөртэй	+		
Бэлчээр хамгаалах хөтөлбөр, бэлчээрийн менежментийн хөтөлбөр бэлчээрийг хадгалах бүлгүүдтэй	+		
Жижиг, дунд үйлдвэрлэл болон бизнесийг дэмжих	+		
Эмнэлэг, сургууль, цэцэрлэгт барилга барих		+	
Оюутнуудын дадлагыг уурхай дээр хийлгэх			+
ШУТИС-д уул уурхайн сургуульд тэнхим нээх			+
Гадаад орнуудад сургалтад хамруулах			+
Хүүхэд залуучуудын асуудлаарх хөтөлбөр хэрэгжүүлэх	+	+	+
Цахилгаан эрчим хүчээх хангах			+
Хатуу хучилттай зам тавих	+	+	+

Судалгаа явагдсан сумдын бүгдэд уул уурхайн компаний зүгээс нэгд, өрхийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх, хоёрт, ажлын байраар хангах, гуравт, оюутны болон гэр бүлийн гишүүний сургалтын төлбөрийг даах, дөрөвт, иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад анхаарах, тавд, хүүхэд залуучуудад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх, зургаад, хатуу хучилттай зам тавихад нийтлэг анхааран ажиллаж байна.

Уул уурхайн компаниуд нөлөөллийн бүсэд амьдарч байгаа малчид, орон нутгийн иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангах үүднээс орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах хүрээнд зарим хүмүүстэй ажлын гэрээ \бүтэн болон хагас цагийн\ байгуулж, малаас нь салгахгүйгээр суваг шуудуу ухах, хог цэвэрлэх, малын гарам\гарц гаргах зэрэг ажлын байраар хангаж байгаа нь иргэдийн дэмжлэгийг авч байна.

Хэдийгээр судалгаанд оролцогчдын хувьд уул уурхайн үйлдвэрлэл нь нутгийн бэлчээрт сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байсан ч, зарим компаний зүгээс бэлчээрийн менежментийн чиглэлээр анхааран ажиллаж байна. 2010 оны байдлаар Ханбогд сумын төвд малчдад зориулсан “Бэлчээрийн менежмент”-ийг таниулах сургалтыг зохион байгуулж, Гавилууд багийн нутагт бэлчээр ашиглагчдын гурван хэсэг байгуулагдаад байна. Бэлчээр ашиглагчдын хэсгийн зохион байгуулалтад орсноор малчид бэлчээрээ хуваарилан ашиглаж, хамтарч хоршин амьжиргаагаа дээшлүүлэх санаачлага гарган хэрэгжүүлэх боломжтой болсон байна. Тухайлбал, бэлчээр хашаалах, малын тэжээлийн ургамал тариалах ажлыг турших, тариалах, малын хороогоо сайжруулан тохижуулах, худаг ус гаргах, засах, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, ахиу үнээр борлуулах гэх мэт үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг байна.

Жишээ 6.4

Долоо хоногийн 2 өдөрт малчдыг ажиллуулах гэрээ хийсэн. 70-80 км-т гүний хоолой дээр шуудуу ухсанаас болж бэлчээр таслагддаг тул малын гарам гаргах, хогоо цэвэрлэх 5 жилийн гэрээтэй ажиллуулж байна. Замын хог цэвэрлэх, ОТ-той холбоотой зөрчлийг бидэнд мэдээлэх гэх мэт ажлуудыг 86 малчин хийж байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Оюу толгой ХХК, Хүний нөөцийн мэргэжилтэн)

Уурхайн барилгын ажлын явцад малчин өрхийг нүүлгэхгүйгээр аюулгүй байдлыг нь хангаж, мачин өрхийн гишүүдийг ажлаар хангаж байна. 30 малчныг барилга барих хугацаанд барилгын ажилд хяналт (барилгын талбайд мал оруулахгүй байх, хог хаягдал хаях, осол аваар гаргаж байна уу гэх мэтээр хяналт) тавих цалинтай ажилд малчдыг авсан.

(Ганцаарчилсан ярилцлага, Оюу толгой ХХК, Хүний нөөцийн мэргэжилтэн)

Өнөөдөр нөлөөллийн бүс нутагт тоос ихтэйгээс шалтгаалан хүн малын эрүүл мэндэд ноцтой хохирол учирч, хариуцлагагүй жолооч нарын уршгаар замын осол аваар их гарч байгаа учраас замаа сайжруулан засах, хатуу хучилттай болгох ажлуудыг судалгаанд хамрагдсан сумдад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд төлөвлөн хийж байна. Харин үүнийг ашиглалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө биш, дараа нь хэрэгжүүлж байгаа нь учир дутагдалтай. Учир нь Цогтцэций сумын иргэд Энержи ресурс, Таван толгой, Эрдэнэс таван толгой, Таван толгой транс болон тээвэрлэлт хийдэг компанийн 120 тонны даац бүхий том машин сумын төвөөр холхиж тоос, тоосжилт дээд цэгт хүрсэн, Энержи ресурс компанийн хөрс хуулалтын овоолго шороо сумын төвд ойрхон байгаагаас шалтгаалан шороо түйрэнгүй өдөр байхгүй болсныг тэмдэглээд бага насны хүүхдээ салхилуулах, угаасан зүйлээ хатаах нөхцөлгүй болсон гэсэн билээ. Түүнчлэн тоос тоосжилтоос хамааралтайгаар ханиад, харшил, амьсгалын замын өвчлөл нэмэгдэж байгааг тэмдэглэв.

Түүнчлэн эмчийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэн алслагдсан сумдыг эмч, эмнэлгийн ажилтнаар ханган, орон нутгийн иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэх, эрүүл мэндийн чанартай, найдвартай үйлчилгээг хүргэх боломжийг хангах зорилготой байна. Энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийг ОТ ХХК 5 жилийн хугацаатай 2005-2010 оны хооронд хэрэгжүүлж, 2011 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлжээ. Энэ хугацаанд нийт 25 эмч хөтөлбөрт хамрагдаж 500 сая төгрөгний хөрөнгө оруулалтыг орон нутгийн эмч, эмнэлгийн чадавхи, чанарыг дээшлүүлэхэд зориулжээ. Мөн иргэд\малчдад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, түргэн шуурхай болгох зорилгоор Энержи ресурс ХХК сумын эмнэлгийн барилга барих, машинтай болгох, зарим эм тариагаар

хангах, нарийн мэргэжлийн эмч нарыг урьж эрүүл мэндийн үзлэг хийх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Орон нутгийн иргэдийн сурч боловсрох эрхийг хангах зорилгоор сургууль, цэцэрлэг барьж, оюутны сургалтын төлбөр, богино болон урт хугацааны дамжааны сургалтын хийгээд гадаад орнуудад сургалтанд хамруулах төлбөрийг барагдуулж байна. Жишээ нь Оюу Толгой ХХК нь 2005-2011 оны хооронд 5 жилийн хугацаатай оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж Өмнөговь аймгийн 133 оюутан тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж, 46 төгсөгч орон нутагтаа ажиллаж байна.

Матриц 6.2 Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын орон нутагт хийсэн хөрөнгө оруулалт

Компаний нэр	Хөрөнгө оруулалт
Чинхуа	- Хүүхэд залуучуудын цогцолбор барьсан - 24 цагийн цахилгаан хангамжид холбосон - Жилд 3-4 оюутан, нийт 15-20 оюутны төлбөр төлсөн. - 53,7 км зам тавьсан
Өмнийн говийн элс (SGS)	- 100 хүүхдийн цэцэрлэг барьсан - 250 сая төгрөгөөр элстэй хоолойн зам тавьсан.
МАК	- 320 хүүхдийн шинэ сургууль барьж байгаа - МАК компани 100 сая төгрөгийн сантай МАК сан байгуулсан

(Эх сурвалж: Чанарын судалгааны үр дүн)

Түүнчлэн хүмүүсийн тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэх үүднээс орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг нийгмийн шинжтэй үйл ажиллагааг явуулж байгаа ач холбогдолтой боловч хүртээмжтэй байж чадахгүйд иргэд сэтгэл дундуур байгаа юм.

Жишээ 6.5

Оюу толгой шууд бэлэн мөнгө өгдөггүй. Цогтцэций суманд 3000 айлын орон сууц барина гэж төлөвлөсөн. Орон сууц хөтөлбөр хэрэгжиж байна. Овоотод залуучуудыг дэмжих 12 айлын орон сууц, 320 хүүхдийн сургууль, 120 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил эхэлсэн.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд, Цогтцэций сумын иргэд)

Гурван тэс суманд үйл ажиллагаа явуулж буй Чинхуа МАК компани нь өрхийн амьжиргааг дэмжих зорилгоор малчин өрхүүдтэй гэрээлэн сүү, цагаан идээ авах, өрхийг дэмжих сан байгуулан ажиллаж байна.

Жишээ 6.6

Сард 600 литр ингэний хоормог, сүү, цагаан идээ авах гэрээ хийж малчдаас авдаг. МАК 100 сая төгрөгийн сан байгуулсан.

(Ганцаарчилсан ярилцлага. Гурван тэс сум, кемп менежер)

Дээрхээс харахад Оюу толгой ХХК-ийн орон нутгийн хөгжилд чиглэсэн олон төрлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг атал нутгийн иргэдийн сэтгэл ханамж бусад сумдыг бодоход харьцангуй доогуур байгаа нь нэг талаас олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй тул нутгийн иргэдийн хүлээлт хэрэгжихгүй удааширч байгаа, нөгөө талаас нийгмийн хөтөлбөрүүдийн үр өгөөж, үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлага байгаатай холбоотой юм. Нөлөөллийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй компаниуд ашиг орлогоосоо нийгмийн болон орон нутгийн хөгжилд хөрөнгө оруулалт хийхдээ

ард, иргэдийнхээ сайн сайхан, эрх ашгийг хангах, хүн амынхаа амьдрах орчинг дээшлүүлэх, үр өгөөжтэй, хуульд харшлахгүй, байгальд ээлтэй нийгмийн бодлого хөтөлбөр хэрэгжүүлбэл ард иргэдийн хүсэл сонирхол хэрэгцээнд нийцэх талаар судалгаанд оролцогсад илэрхийлж байлаа.

Матриц 6.3 Уул уурхай үйлдвэрлэлийн орон нутаг, нутгийн иргэдэд үзүүлсэн нөлөө

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас алдсан нь их гэж үзэж байгаагийн жишээ	Уул уурхайн эерэг нөлөөний жишээ
Байгалийн баялгаа зүгээр өгөөд дуусч байна	Иргэд ажилтай болж байна
Байгаль экологийн унаган төрх алдагдаж, сүйрч байгаа	Тогтмол цалин авч байна
Тоос тоосжилт их болж, хур бороо орохоо байсан	Оюу толгой, Энержи ресурс ХХК-д ажиллаж байгаа хүмүүсийн амьдрал дээшилж байна
Хятад иргэд их хэмжээгээр орж ирсэн	Хүн амын тоо нэмэгдэж, сум өргөжиж байна
Бэлчээр талхлагдсан	Сургууль, цэцэрлэг барьж байна
Хүн, малын эрүүл мэндэд маш их сөрөг нөлөө үзүүлсэн	Зам тавьж байна
МАН эрхлэх аргагүй болсон	
Бэлчээр, ус, нутаг усаа уурхайд алдсан	
Газар өмчлөх, ашиглах, эзэмших \өвөлжөө\ эрхгүй болсон	
Газар нутгийн аюулгүй байдал алдагдсан	
Малгүй болж сумын төв бараадсан	
Нутаг ус дахин сэргэхээргүй болсон	

Мөн судалгаанд оролцогчдын тал хувь (47 хувь)-ийнх нь амгалан тайван байдлыг уул уурхайн үйлдвэрлэл эвдсэн болохыг илэрхийлсэн байна. Мөн 44 хувь нь хүн амын хөдөлгөөн ихэссэний улмаас амгалан тайван байдал алдагдаж байна хэмээн дүгнэжээ. Иргэдийн төдийгүй мал болон эд хөрөнгийнх нь аюулгүй байдал алдагдаж байгаад судалгааны оролцогчдын 63 хувь нь санаа зовж байгаагаа илэрхийлсэн ба хүн амын хөдөлгөөн эрс нэмэгдсэн шалтгаан нь уул уурхайн үйлдвэрлэл билээ. Хүн ам сийрэг аж төрдөг говь нутаг уул уурхайн нөлөөгөөр хөдөлгөөнд орж, хүн, техникийн хөл хөдөлгөөн ихэссэн зэрэг нь нутгийн иргэдийн амгалан тайван байдалд их бага хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлж байгааг тоон судалгааны дүн харуулж байна. Судалгаанд хамрагдсан зарим төрийн албан хаагчдын өгч байгаа мэдээллээр тухайн сумын суурин хүн амаас гадна 5000-6000 орчим явуулын иргэд байгааг тэмдэглэснээс үзвэл Ханбогд, Цогтцэций сумдад 10000 орчим хүн ам суурин болон түр хугацаагаар оршин сууж байгааг харуулж байна. Ерөнхийдөө манай улсын нэг сумын дундаж хүн амын тоо 3000-4000 байдаг бол уул уурхай хөгжсөн сумдад энэ тоо даруй 2-3 дахин их байгаа нь уугуул нутгийн иргэд эрүүл аюулгүй орчинд аж төрөх, халдашгүй байх зэрэг эрх нь зөрчигдөхөд хүргэж байгаагийн зэрэгцээ хүн амын тоо хэтэрсний улмаас нийгмийн үйлчилгээнүүд тэр дундаа боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхээ эдлэхэд нь хүндрэл учирч байгаа ажээ.

Судалгаанд хамрагдсан сумын төвийн иргэд уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүний эрх зөрчигдөж байна хэмээн үзэж байна. Уул уурхайн үйлдвэрлэлийн эрчимжилт нь зөвхөн нөлөөллийн бүс дэх иргэдийн төдийгүй сумдын нийт иргэдийн

эрхэд халдаж байгааг судалгаанд оролцсон сумын төвийн иргэдийн дийлэнх нь буюу 79 хувь нь уул уурхайн үйлдвэрлэл эрчимжсэнтэй холбоотойгоор хүний эрх тодорхой хэмжээгээр зөрчигдөж байна гэж үзсэнтэй холбон тайлбарлаж болох юм. Тэдний үзэж байгаагаар эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хамгийн ихээр зөрчигдөж байна гэж үзсэн ба бусад ямар эрхүүд зөрчигдөж байгааг авч үзвэл:

Нэгд, эрүүл аюулгүй орчинд амьдрах,
Хоёрт, хөдөлмөрлөх,
Гуравт, үндэс угсаагаар ялгаварлагдахаас ангид байх,
Дөрөвт, хөдөлмөрлөх,
Тавд, газар эзэмших, өмчлөх,
Зургаад насаар ялгаварлагдахаас ангид байх,
Долоод, амьдрах орчноо чөлөөтэй сонгох,
Наймд, амьд явах,
Ест, жагсаал цуглаан зохион байгуулах,
Аравт, эвлэлдэн нэгдэх,
Арван нэгт, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох, ажлын байрны дарамтаас ангид байх, үг хэлэх эрх зөрчигддөг гэж тус тус хариулжээ.

Судалгаанд оролцогчид уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас хүний эрх тодорхой хэмжээгээр зөрчигддөг гэж хариулсан ч судалгаанд оролцогчдын дөрөвний нэг нь тодорхой хариулт өгч чадаагүй юм. Тодорхой хариулт өгч чадаагүй байдал нь хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байгаатай тодорхой хэмжээгээр холбогдоно.

Газар эзэмших эрх зөрчигдөж байна хэмээн Цогтцэций сумын иргэд илүүтэй үзэж байгаа бол үндэс угсаагаар ялгаварлагдаж байна хэмээн Ханбогд сумынхан үзсэн байна. Үүнийгээ Ханбогдынхон уул уурхайн салбарт ажиллаж буй нутгийн иргэдийн дийлэнх нь цалин хөлс, нэр хүндээр доогуур энгийн ажил хөдөлмөр эрхэлж байхад гадаадын иргэд цалин хөлс, нэр хүнд сайтай мэргэжлийн ажил эрхэлж байгаа байдлыг “ялгаварлан гадуурхалт” хэмээн үзэж байв. Харин бусад эрхийн зөрчил нь бүх сумдад нийтлэг илэрч байна.

Уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөгөөр нутгийн иргэдийн эрүүл, эсэн мэнд амьдрах эрх зөрчигдөж байгаа нь тэдний нэрлэсэн дээрх хариултаас гадна судалгаанд оролцогчдын 40 хувь нь уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор эрүүл мэндийн байдал нь муудсан гэж хариулж байгаагаас давхар харж болох юм.

Түүнчлэн нутгийн уугуул иргэд эцэг эхээсээ уламжлан ирсэн газар нутгаа эзэмших боломжоор хязгаарлагдаж байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 63 хувь нь газраа эзэмших боломжгүй байгаагаа илэрхийлжээ. Тэр дундаа Цогтцэций сумын хувьд сумын төвийн иргэд газраа эзэмших боломжоор хязгаардагдмал байна. Энэхүү нөхцөл байдал нь нутгийн иргэдийн оршин суух нутаг дэвсгэрээ чөлөөтэй сонгох, уламжлан ирсэн газраа эзэмших, ашиглах, өмчлөх эрх нь зөрчигдөхөд хүргэж байна. Энэхүү төлөв байдал нь уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа эсэхээс үл хамаарч, сумын төвийн иргэдийн дунд ч нийтлэг ажиглагдаж байгааг анхаарах ёстой.

Жишээ 6.7

Нутаг газар дуусах нь, түрүү үеэс уламжилж ирсэн нутгаа хойч үедээ үлдээх аргагүй боллоо.

(Гурвантэс сумын ЗДТГ-ын ажилтан)


Сумын төвийн байршил замгүй, хот төлөвлөлт байхгүй, ямарч зохион байгуулалтгүй, осол аваар их гардаг. Дуртай газраа мөнгөтэй хүн байшин барьж байна. Хөрсний хуулга сумын төвд улам ойртож байна. Хавар, өвөл тоосон дунд бужигнасан нөхцөлд амьдарч байна. Хаана юу байгаа нь бүү мэд. Нялх хүүхэд хэцүү, гадагшаа гаргах аргагүй, нус нь гоожоод, хамар ам нь битүү. Байнга маск зүүж явдаг. Газар нутгийг төр хувийн компанитай нийлж булааж авсан.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сумын ЗДТГ-ын ажилтан)

6.2 Уул уурхайн үйл ажиллагааны явцад төр, орон нутгийн иргэд, орон нутгийн захиргааны байгууллага, уул уурхайн компанийн оролцоо

Мэдээлэл бол иргэдийн оролцооны үндэс, эхлэл. Иргэд мэдээлэлгүйгээс өөрт хамаарах, ашиг сонирхлыг нь хөндсөн аливаа асуудлыг шийдэх үйл хэрэгт оролцож чадахгүйд хүрдэг. Судалгаанд хамрагдсан Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумын төвийн иргэдийн 49 хувь нь орон нутагт нь үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн үйл ажиллагааны талаар өнгөц мэдээлэлтэй, 5 хувь нь ямар ч мэдээлэлгүй байна. Холбогдох компаниас өнгөц мэдээлэл авч чаддаг хэсэг 4 хувь, огт чаддаггүй хэсэг 42 хувийг эзэлж байна. Харин судалгаанд хамрагдсан малчдын 98 хувь нь орон нутагт нь үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компанийн талаар тодорхой мэдээлэлтэй гэж хариуллаа. Малчид мэдээлэлтэй байх нь эрх ашгаа хамгаалах гол хэрэгсэл гэж үзэж байгаа нь бүлгийн ярилцлагаас тодорхой ажиглагдаж байв. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр малчдын эрх ашиг илүүтэй хөндөгдөж байгаа явдал нь малчдыг мэдээлэлтэй байхыг ч нөхцөлдүүлж байгаа юм.

Малчид ихэвчлэн ямар эх үүсвэрээр уул уурхайтай холбоотой мэдээлэл авч байгааг тодруулах зорилгоор “Танай нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын талаарх найдвартай мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг” гэсэн асуултаар судлахад 50 малчны 29 нь буюу 58 хувь нь уул уурхайн компаниас гэж хариулсан нь бусад мэдээллийн эх үүсвэртэй харьцуулахад хамгийн олонтаа давтагджээ. Өөрөөр хэлбэл малчид орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайтай холбоотой мэдээллийг тухайн компаниас авах нь хамгийн найдвартай эх сурвалж хэмээн үзэж байна.



Малчдын хувьд уул уурхайн компанийн дараагаар 44 хувь нь телевиз, 22 хувь нь танил хүмүүс, нутаг усны хүмүүсээс уул уурхайтай холбоотой хэрэгцээт мэдээллийг


авч байна. Харин сум, багийн ИТХ, сум орон нутгийн захиргаатай холбогдож мэдээлэл авах нь бага байгаа хандлага ажиглагдаж байна. Судалгаанд хамрагдсан сумын төвийн иргэд орон нутгийн Засаг даргын тамгын газраас мэдээлэл авч чаддаггүй гэж 66 хувь нь үзсэнээс харвал сумын засаг захиргааны байгууллагаас иргэд, малчдадаа уул уурхайтай холбоотой мэдээлэл хангалттай өгдөггүйг харуулж байна. Малчидтай харьцуулахад сумын төвийн иргэдийн дунд уул уурхайн үйл ажиллагааны талаарх мэдээлэл хомс байх хандлага ажиглагдаж байв.

Мэдээж малчдын хамгийн ихээр эрх ашиг нь хөндөгдөж бухимддаг асуудалд газар эзэмших, ашиглах бүр тодруулбал өвөлжөө, хаваржаа, намаржаа, зусланг бэлчээрийн зориулалтаар ашиглахтай холбогдсон харилцаа юм. Нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа малчид ерөнхийдөө багийн нутаг дэвсгэрийн аль хэсэг түүний дотор өөрийн өвөлжөө, хаваржаа, лицензийн талбайд орсон талаар мэдээлэл сайтай байгаа нь доорх зургаас харагдаж байна.



Ерөнхийдөө малын бэлчээр, ус, өвөлжөө бууц нь малчдыг мэдээгүй байхад лицензийн талбайд орсон байдаг ба хэзээ хойно нь буюу малчдын оролцоогүйгээр асуудал шийдэгдсэний дараа энэ талаар мэддэг гэж хариулсан нь түгээмэл илэрч байлаа.

Аливаа шийдвэрийг гаргахдаа ашиг сонирхол нь хөндөгдөж буй иргэдтэй зөвлөлдөх явдал нь иргэдийг оролцуулах дараагийн алхам. Гэвч судалгаанд оролцсон сумын төвийн иргэдийн дийлэнх нь буюу 64 хувь нь огт зөвлөлддөггүй гэсэн бол судалгаанд хамрагдсан нөлөөллийн бүсэд нутаглаж буй малчдын 82 хувь нь сум орон нутгийн удирдлага, баг, сумын ИТХ-аар лиценз олголтын асуудлыг шийдэхдээ бидний саналыг огт авдаггүй гэж хариулснаас үзвэл Үндсэн хуулиар баталгаажсан саналаа илэрхийлэх, шийдвэр гаргахад оролцох эрх нь бараг хэрэгждэггүй болохыг илтгэсэн үзүүлэлт юм. Судалгаанд хамрагдсан Ханбогд сумын нэг малчин, Цогтцэций сумын ердөө хоёр малчин лицензийн тусгай зөвшөөрөл олгох асуудлаар малчидтай зөвлөлдсөн гэж хариулжээ.



Иргэд, малчидтай зөвлөлддөг эсэхийг мэдэхгүй явдал ч нэлээд хувьтай байгааг судалгааны дүн харуулж байв. 10 малчин тутмын найм нь лиценз олгохтой холбоотойгоор малчдын эрх ашиг хамгийн ихээр хөндөгдөж байгаа асуудлын талаар шийдвэр гаргахдаа эрх ашиг нь хөндөгдөж байгаа малчинтай зөвшилцөж зөвлөлддөггүй гэж үзэж байна.

Жишээ 6.8
Хэлэлцүүлэг хийдэг. Мэдээлэл өгдөг. Саналыг нь сонсдог. Хэрэгжүүлэх шийдвэртээ тусгадаг. Жишээ нь худаг гаргах, гарам гарц барья гэсэн санал гардаг. Энэ нь оролцуулж асуудлыг нь шийдэж байгаа хэлбэр. Агаарын хяналт, орчны хяналт шинжилгээ мониторинг хийхдээ иргэдийг оролцуулдаг. Гэвч ус, тоосны хэмжилт хангалтгүйг мөн судалгаанд оролцогч хэлж байв. Бид нутгийн иргэдээс гомдол санал байнга бөглүүлж авдаг, тухайн бүрт нь шийдэрлэдэг.
(Ганцаарчилсан ярилцлага, Энержи ресурс ХХК, ОНХХ-ийн ажилтан)
Малчдын эрх ашгийг хөндсөн асуудлаар эхлээд дээрээ \ОТ ХХК-ийн түвшинд\ дараа нь бидэнд танилцуулдаг. Шууд бидний саналаар шийдвэрлэдэггүй. Асуудлаа шийдчихээд түүнийгээ бидэнд ирж ярьж танилцуулдаг
(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум Цагаанхад багийн малчин)

Иргэдтэй зөвлөлдөхдөө багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх (14%), айл өрхүүдээр зочлон ярилцах (10%) гэсэн хэлбэрийг бага зэрэг ашигладаг байна.

Сумын төвийн судалгаанд хамрагдсан иргэдийн үзсэнээр иргэдтэй зөвлөлдөх үйл ажиллагаа хангалтгүй байгааг

- Хурлын зар иргэдэд хүрдэггүй,
- Тойм, ерөнхий мэдээлэл дамжуулдаг,
- Иргэд өөрсдөө л хандахгүй бол холбогдох талууд санаачилдаггүй,
- Асуудлыг зөвхөн иргэдийн төлөөлөгчдийн хурал шийдэж байгаатай холбон үзсэн аж.

Уул уурхайд холбогдох тулгамдсан асуудлаар судалгаанд оролцсон сумын төвийн иргэдийн 28 хувь нь багийн иргэдийн нийтийн хуралд оролцон санаа бодлоо илэрхийлдэг, 10 хувь нь зохион байгуулагдсан хурал цуглаанд үг хэлдэг, 10 хувь нь сайн дурын бүлэглэл байгуулан хамтдаа тэмцдэг, 6 хувь нь сонгосон төрийн болон орон нутгийн хууль тогтоогч нарт ханддаг хэмээн хариулжээ.

Судалгаанд хамрагдсан сумын төвийн иргэдийн зөвхөн 1.1 хувь нь уг асуудлаар шүүхэд хандсан бол судалгаанд хамрагдсан малчдын 34 хувь нь малын бэлчээр, өвөлжөө, хаваржааны газрыг уул уурхайн компаниуд дураараа ухсан, авсан тохиолдолд сум, багийн Засаг даргадаа хандаж гомдол гаргаж байсан гэж хариулжээ. Судалгааны явцад шүүхэд хандаж эрхээ хамгаалуулсан тохиолдол, жишээ бидэнтэй ер таараагүй юм. Энэ нь тэдний хүний эрхийн боловсролтой холбоотой.

Хүснэгт 6.2 Малын бэлчээр, өвөлжөө, хаваржааг уурхайн эдэлбэр газрын зориулалтын хүчээр ухсан, булаасан тохиолдол гарсан гэж хариулсан малчдын тоо

Сонгосон үзүүлэлтээр	Гурвантэс	Ханбогд	Цогтцэций	Бүгд
Олон тохиолдол байгаа	4	3	2	9
Гарч л байдаг	3	3	5	11
Цөөн	0	3	1	4
Байхгүй	3	9	5	17
Мэдэхгүй	6	0	3	9
Бүгд	16	18	16	50

Нийт судалгаанд хамрагдсан 50 малчны 24 нь буюу бараг тал хувь нь орон нутагт нь малын бэлчээр, өвөлжөө, хаваржааг уурхайн зориулалтаар хүчээр ухсан, булаасан тохиолдол их бага хэмжээгээр гарч байсан гэж дүгнэжээ. Энэ тохиолдолд малчид шүүхэд хандах бус ихэвчлэн орон нутгийн удирдлагадаа хандаж гомдол (34.8% буюу 8 малчин) гаргадаг байна. Орон нутгийн удирдлагадаа хандсан 8 малчнаас зөвхөн нэг малчин буюу Ханбогд сумын малчин асуудлаа шийдвэрлүүлж чадсан бол, Цогтцэций сумын нэг малчны асуудлыг шийдэлгүй аргацаагаад өнгөрөөсөн, үлдсэн 6 малчин хандаад ч нэмэргүй байсан гэсэн хариултыг тус тус өгчээ. Малчдын өгсөн хариултаас үзвэл уул уурхайн компаниуд малчин хүний үнэт хөрөнгө болсон өвөлжөө, хаваржааны газар түүн дээрх хонд бууц, хашаа хороо, худаг ус зэрэг малчин хүний эд хөрөнгөд дураараа халдаж өмнөх нөхцөл байдлаас нь дордуулсан үйл ажиллагаа явуулчихаад хариуцлага хүлээхгүй байгаа нөхцөл байдал нийтлэг ажиглагдаж байна.

Малчид сум багийн удирдлагадаа хандахаас гадна өвөлжөө, бууц, бэлчээр, ус нь уул уурхайн нөлөөлөлд өртсөн, ухсан нүхэнд мал нь орж үхсэн үед уул уурхайн компаниудад ханддаг гэж хариулжээ. Жишээлбэл судалгаанд хамрагдсан малчдын 50 малчнаас 14 нь уул уурхайн компанид хандсанаас дийлэнх нь Ханбогд сумын малчид эзэлж байлаа. Харин уул уурхайн компанид хандсан малчдаас ердөө 3 нь (худаг гаргаж өгсөн, нөлөөллийн бүсэд оруулсан, үхсэн малд нөхөн төлбөр өгсөн) асуудлаа шийдвэрлүүлсэн гэж хариулсан нь малчдын санал гомдол, хүсэлтийг шийдвэрлэлт тааруу байгааг илтгэж байна.

Үндсэн хуульд эрх ашиг нь хөндөгдсөн иргэнийхээ хангаж хамгаалах үүргийг төр хүлээнэ гэж заасан байдаг тул бүх шатны төрийн байгууллага энэ үүргээ хэрхэн биелүүлж байгааг сумын жишээн дээр тодруулахад уул уурхайн сөрөг нөлөөллийн улмаас нутгийн иргэдийн эрх зөрчигдсөн тохиолдолд тэдний эрх ашгийг төлөөлөх, хамгаалах арга хэмжээг нутгийн удирдлагын зүгээс огт авч хэрэгжүүлдэггүйг судалгааны дүн илтгэж байна. Өөрөөр хэлбэл иргэдийн Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг хангаж, хэрэгжүүлэх үүрэгтэй төрийн байгууллага хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх үүргээ биелүүлэхгүй байна. Үүнтэй холбоотойгоор нутгийн иргэдийн дунд орон нутгийн төрийн удирдлагын нэр хүнд

ихээхэн доогуур байгаа нь сумын төвийн иргэдийн хариултаас харагдаж байна. Учир нь уул уурхайн үйл ажиллагааны улмаас иргэд хохирсон тохиолдолд орон нутгийн удирдлагын зүгээс ямар ч арга хэмжээ авдаггүй (61%) гэж хариулах явдал хамгийн их хувийг эзэлж байв. Иргэдтэй хамтран уул уурхайн компанид гомдол гаргах, гурван талт хэлэлцээр зохион байгуулах замаар орон нутгийн байгууллага ажилладаг хэмээн 10 хувь нь л хариулжээ. Түүнчлэн судалгаанд хамрагдсан сумын төвийн иргэдийн (60.1%), малчдын (88%) орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлжээ.


Жишээ 6.9

Орон нутгийн удирдлагад хандаад ч нэмэргүй. Засаг даргад саналаа хэлэхээр өөдөөс загнадаг. Хүсэлт бариад очихоор хэрэгсэж авч хэлэлцдэггүй. Бидэнд хуулийн талаарх мэдээлэл бага байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Жавлант багийн малчин)

Гэв гэнэт хаяанаас нүх ураад эхэлсэн. Малчдаас огт зөвшөөрөл авдаггүй. Асуухаар Засгийн газраас зөвшөөрөл авсан гэдэг. Уул уурхайн компани хурал уулзалт хийдэг. Уул уурхайн компани өөрийгөө магтсан мэдээлэл өгдөг. Малчидтай шийдэлд хүрдэггүй, маргалдсаар байгаад таардаг.

(Ганцаарчилсан ярилцлага, Ханбогд сум, Баян багийн малчин)



Ийнхүү орон нутгийн удирдлагын нэр хүнд судалгаа хийгдсэн сумдад ялгаагүйгээр тааруу байв. Иймд үүнийг орон нутгийн төрийн удирдлагын эрх хэмжээ хязгаарлагдмал байгаатай холбоотой юу, эсвэл орон нутгийн удирдлагын түвшинд авилга, ашиг сонирхлын зөрчил их байгаатай холбоотой юу гэдгийг судлан тогтоох нь чухал юм.

Жишээ 6.10

Ард түмний үг үг биш. Бидний үгийг тоохгүй биз дээ. Ард түмнээрээ хэлэлцэж шийддэггүй. Ашигт малтмалын газар, Аймгийн ИТХ-аас шийдвэрлэсэн л гэдэг. Сумын удирдлагууд уул уурхайтай холбоотой асуудлаар бишгүй явдаг ч нэмэр алга байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, Цагаан-Овоо багийн малчин)

Малчид газар нутаг, бэлчээр усаа хамгаалахаар “Гурван тэс эх нутаг” хөдөлгөөн 5 сард байгуулсан. 500 хүний гарын үсэгтэй бичиг дээшээ явуулсан. Бид сум, багийн Засаг дарга нарт хэлэхээр бидний мэдэх асуудал биш, надад ямар ч эрх мэдэл байхгүй гэж хэлдэг.

(Ганцаарчилсан ярилцлага, Гурвантэс сум, Баясах багийн малчин)

Ер нь иргэд мэдээлэлгүй, хэрхэн оролцох тухай мэдлэг тааруу, компани болон орон нутгийн төрийн байгууллагын ил тод байдал тааруу, иргэдийг оролцуулах тухай хүсэл зориг дутмаг байгаа нь иргэдийн эрх ашгийг нь хөндсөн шийдвэрийг гаргахад

оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрх нь зөрчигдөхөд хүргэж байна. Иргэдийн мэдээлэл, оролцоо сумдад ялгаагүй тааруу болох нь ажиглагдав. Энэ нь холбогдох компаниудын хувьд төдийлөн ялгаа үгүй болохыг харуулах юм.

Судалгаагаар уул уурхайн компаниас ус, газар ашигласны төлбөр, уул уурхайн үйлдвэрлэл, нүүрсний тээвэрлэлт эрхэлж байгаа 50 гаруй компанийн 5000 гаруй тээврийн хэрэгслэлийн татвар, түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөр, байгалийн нөөц ашигласны төлбөр \роялти\ уул уурхайгаас орж ирж буй орлогоор үүсгэсэн сангийн мөнгө, уул уурхайн компанийн хандив, хөрөнгө оруулалт болон бусад төрлийн зөвшөөрөл авсны хураамж улсын юмуу орон нутгийн төсөвт төвлөрч байгаа, орон нутгийн захиргаа аль орлогыг мэдэж зарцуулах эрхтэй болох, эдгээр татвар хураамжаас талхлагдсан хөрс, бэлчээрийг нөхөн сэргээхэд хэдэн хувь нь зарцуулагдаж байгаа талаарх мэдээлэл хомс байлаа. Иймд уул уурхайгаас орж ирж байгаа орлого, уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас орон нутагт үүсэн бий болсон зардлыг тооцож орон нутгийн иргэд, малчид хийгээд бусад оролцогч талуудад ил тод, нээлттэй мэдээлж байх шаардлагатай байна.


Түүнчлэн МХГ зэрэг хяналт шалгалтаар очсон байгууллага уул уурхайтай холбоотой асуудлыг шалгадаг ч орон нутгийн захиргаа, иргэд, малчдад хариу мэдээлэл өгдөггүйг бүлгийн ярилцлагад оролцсон Гурвантэс, Ханбогд сумын уул уурхайн нөлөөлөлд өртсөн багийн Засаг дарга нар тэмдэглэж байв.

Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход нутгийн иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэнэ гэсэн хуулийн заалт байдаг хэдий ч судалгаанд хамрагдсан малчдын 44 хувь нь энэхүү заалт огт хэрэгждэггүй, 48 хувь нь ийм заалт байдгийг ч мэдэхгүй байлаа. Нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа малчдын 82 хувь нь сум орон нутгийн удирдлага, баг, сумын ИТХ-аар лиценз олголтын асуудлыг шийдэхдээ бидний саналыг огт авдаггүй, малчдын саналыг авч асуудлыг шийддэгийг мэдэхгүй гэж хариулснаас үзвэл Үндсэн хуулиар баталгаажсан саналаа илэрхийлэх, шийдвэр гаргахад оролцох эрх нь бараг хэрэгждэггүй болохыг илтгэсэн үзүүлэлт юм. Судалгаанд хамрагдсан Ханбогд сумын нэг малчин, Цогтцэций сумын ердөө хоёр малчин лицензийн тусгай зөвшөөрөл олгох асуудлаар малчидтай зөвлөлдсөн гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл хайгуул болон ашиглалтын лиценз олгодог эрх бүхий байгууллага шийдвэрийг гаргахдаа эрх ашиг нь хөндөгддөг нөлөөллийн бүсэд амьдарч байгаа малчдаас асуух, зөвлөлдөх үйл ажиллагааг 94 хувь нь (огт үгүй, мэдэхгүй гэж хариулсан хариултаудын нийлбэр) огт хийдэггүй гэж хариулжээ.

Ийнхүү судалгааны дүнгээр уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход иргэдийн оролцоо туйлын хангалтгүй байна. Ашигт малтмалын тухай хуульд хайгуулын лицензийн тусгай зөвшөөрөл олгохдоо АМГ-аас аймаг сумын засаг даргад ирүүлсэн өргөдлийг сум, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн хянуулж тэдний саналыг авахаар хуульчилсан нь иргэд ИТХ-аараа дамжуулан санал бодлоо илэрхийлэх боломжтой болсон ч АМГ нь засаг дарга нараас ирүүлэх саналыг 30 хоногт хүлээн авах бөгөөд хугацаа хэтэрсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл олгохыг зөвшөөрсөнд тооцохоор зохицуулсан нь Ашигт малтмалын хуулийн 19.4 огт хэрэгждэггүй заалт болохыг судалгааны дүн харуулж байна.

*Өмнөговь аймгийн
Турван тэ сумын
Талсах баг*

ТОЙМ ЗУРАГ
Ашигт малтмалын кадастрын тойм зураг



Зургийн масштаб: 1:652,366

Зургийн тусгаг: Газарзүйн солбицлын систем
Геодезийн холлох цэг: WGS 84

БАЙРШИЛ ЗҮЙ		ӨРГӨДЛИЙН ТАЛБАЙ	
	Аймаг		хайгуулын
	Сум		ашиглалтын
	Нийслэл		ашиглалтын өмнөх
	Аймгийн төв		номлолт
	Сумын төв		Бусад нь шилжүүлэх
	Нэг замтай төмөр зам		Хасгачлан шилжүүлэх
	Хоёр замтай		Бусад нь буцааж өгөх
	Плашиг [1:100 000]		Хасгачлан буцааж өгөх
	Ширгэдэггүй нуур		Нийлүүлэх
	Ширгэдэг нуур		Хуваах
			Хуулийн 56.1.3 -ээр цуцлах
			Хуулийн 56.1.1-2,56.1.4-5 дагуу цуцлах
			Хуулийн 56.1.3 -аас үүдэн багасгах
			Цэцэглэдсэн өгөдөл
			Цэцэглэн засах
			Хөлийн маргааныг шийдвэрлэх
			Шүүхийн шийдвэрийг үндэслэн засах
			Хайгуулын тусгай зөвшөөрөл
			Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл
			Хүчэнгүй (хаалттай) хайгуулын тусгай зөвшөөрөл
			Хүчэнгүй (хаалттай) ашиглалтын тусгай зөвшөөрөл
			Стратегийн ашигт малтмалын орд
			Улсын төсвийн санхүүжилттэй геологийн судалгаа
			Тусгай хэрэгцээний газар
			Нөөцөд авсан талбай
			Задалбар газар
			Улсын тусгай хамгаалалттай газар
			Улсын хилийн зэрвэс газар
			Төмөр замын зэрвэс газар
			СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЛБАЙ
			Хайгуулын сонгон шалгаруулалт явагдаж буй
			Ашиглалтын сонгон шалгаруулалт явагдаж буй
			Хайгуулын сонгон шалгаруулалтад орох
			Ашиглалтын сонгон шалгаруулалтад орох



**Монгол улсын Ашигт
Малтмалын Газар**

Засгийн газрын XII байр,
Барилгачдын талбай 3

Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар 15170
Монгол Улс

Огноо: 2012.05.08

Төлөвлөсөн: Монгол улсын Ашигт
Малтмалын Газар, 2010

Зохиогчийн эрх: Монгол улсын Ашигт
Малтмалын Газар, 2012

Жишээ 6.11

Гурван тэс сумын Баясах багт АМГ-аас явуулсан бичиг өчигдөр буюу 30 хоног нь дуусч байхад ирсэн. Ер нь АМГ-аас тусгай зөвшөөрөлтэй холбоотой засаг дарга нараас санал авах өргөдөл нь ямагт хугацаа хожимдож ирдэг тул нутгийн иргэдийн санаа бодлыг тусгах ямар ч боломж байхгүй. Бид гар дээрээ дөнгөж өчигдөр аваад өнөөдөр 30 хоногийн хугацаа нь дуусч байна шүү дээ. Иймд орон нутаг автоматаар зөвшөөрсөнд тооцогдоод шийдэгдээд явчихдаг. Хэрэв одоо манайд ирчихээд байгаа энэ өргөдөлд зөвшөөрснөөр далд уурхай байгуулбал ургамал ан амьтан, усгүй болно. Манай багийн ихэнх нутаг лицензийн талбайд орсон. Мал, малчин хоёр амьдрах аргагүй боллоо. Гэтэл 30 хоногийн хугацаа нь дуусаад иргэд оролцох боломжгүй болчихлоо. Манай багийн иргэд уул уурхайн үйл ажиллагаа явуулахгүй гэдэг бичиг явуулсан хариу ирээгүй байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Гурван тэс сум, Баясах багийн Засаг дарга)

Дээрх жишээнээс төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн бичгийг тухайн талбай байрлах Засаг дарга хүлээн авснаас хойш холбогдох орон нутгийн ИТХ-ын саналыг 30 хоногийн дотор хүлээн авч, хариу илгээх ёстой хэмээн хугацааг орон нутгийн удирдлагын талд нийцтэй байхаар тодорхой заагаагүйгээс төрийн захиргааны байгууллага иргэд, орон нутгийн удирдлагын оролцоогүйгээр, давуу боломжтойгоор шийдэх нөхцлийг бүрдүүлж өгчээ. Ийнхүү иргэд, түүний орон нутгийн төлөөллийн байгууллагын оролцоог Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан ч хэрэгжих боломжийг хязгаарлажээ.

Ашигт малтмалын тухай хуулиас

19.3.Энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн бол төрийн захиргааны байгууллага нь энэ талаар тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд энэ хуулийн 17.1-д заасны дагуу хийгдсэн талбайн зургийг хавсаргана.


19.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.3-т заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч 30 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ.

Ашиглалтын лиценз олгох үйл явцад иргэдийн оролцоог “Ашигт малтмалын хууль”-ийн 25.1.7-д ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хавсаргасан байх ба Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийн 5.4.8-д “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дэлгэрэнгүй тайланд тухайн нутгийн ашигт малтмалыг ашиглахыг хүссэн хуулийн этгээд тухайн нутгийн иргэд, сум, дүүргийн ИТХ-ын саналыг тусгах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл явцад иргэд санал бодлоо илэрхийлэхээр зохицуулсан байдаг ч судалгаанд хамрагдсан 3 сумдад иргэдийн оролцоог хангалтгүй байгааг тоон болон чанарын судалгааны үр дүн харуулж байна. Ашигт малтмалын тухай хуульд иргэдэд уул уурхайн явуулж байгаа үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, хэрэгжүүлж байгаа төсөл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг танилцуулна, мэдээллээр хангана гэж заасан байдаг энэ заалт мөн л хэрэгждэггүй байна.

Харин нөлөөллийн бүс дэх иргэд, малчид болж буй үйл явдлын талаар бодитой мэдээлэл авах, санал бодлоо илэрхийлэх зэргээр хууль эрх зүйн мэдлэгтэй байж

хүний эрх, эрх чөлөөгөө өөрөө хангаж хамгаалахыг чармайдаг болсон байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байлаа. Харин хүний эрхийг хангаж хамгаалах, төлөөлөх, хөндөгдсөн эрхийг нь нөхөн сэргээх үүрэгтэй субъект, институци байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага хоцрогдонгүй байдалтай байна.

Уул уурхайтай холбоотой асуудлаар орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанд малчдын дийлэнх буюу 68 хувь нь сэтгэл хангалуун бус байгааг орон нутгийн удирдлага өөрсдөө хувийн эрх ашгаар компаниудтай хамтарч ажилладаг, ажилгүй хүмүүсийг ажилд оруулдаггүй, эрх нь зөрчигдөж буй малчдын асуудлыг хөндөхдөө хойрго хэмээн иргэд үзэж байна.



Судалгаанд оролцсон малчид орон нутагт уул уурхайтай холбоотой асуудлаар шийдвэр гаргахад 34 хувь нь сум, багийн засаг дарга, 54 хувь нь иргэд, 86 хувь нь малчид ялангуяа нөлөөллийн бүсэд амьдарч буй малчдын оролцоо чухал бол багийн нийтийн хурлын дарга, тэргүүлэгчид, байгаль орчны байцаагч, хяналтын байгууллагууд мэргэжлийн хяналт, олон улсын байгууллага, ТББ, нутгийн нэр хүндтэй хүмүүс төдийлөн үүрэгтэй оролцож чадахгүй хэмээн үзлээ.



Уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулахыг хичээдэг гэж малчдын 46 хувь нь үзсэн бол 54 хувь нь огт оролцуулдаггүй хэмээхийн сацуу Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж буй компаниуд иргэдийн оролцоог

хангахдаа тааруу болох нь судалгаанаас хамрагдлаа. Уул уурхайн компаниуд малчидтай дараах хэлбэрээр хамтарч ажилладаг хэмээн үзсэн малчдын гурваны нэг нь хуралд оролцсон, 26,3 хувь орон гэрээр нь зочлон ярилцдаг, 21,2 хувь нь уул уурхайн компаниас зохион байгуулж буй арга хэмжээнд оролцсон, 10,5 хувь нь иргэдийн санал бодлыг харгалзан шийдвэр гаргадаг гэж үзсэн бол байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхөн сэргээлт хэрхэн хийж байгаагаа үзүүлэх, мэдээлэх үйл ажиллагаандаа ганц ч иргэн, малчныг оролцуулаагүй байгаа нь нэг талаас уул уурхайгаас авсан ашгаасаа эргээд байгаль орчин, нөхөн сэргээлтдээ зарцуулахад хойргоших өөрөөр хэлбэл хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, нөгөө талаас нөлөөллийн бүсэд байгаа иргэдийн эрхийг хүндэтгэх, хамтран ажиллах хүсэл эрмэлзэл сул байгааг харуулж байна.

Чанарын судалгаанд хамрагдсан иргэд нөхөн сэргээлт, тоос тоосжилт, бэлчээрийн талхлагдлын асуудлаар компани, орон нутгийн удирдлагад бичгээр болон, хурал уулзалтад асуулт тавих, санал хэлбэрээр илэрхийлдэг ч малчдын саналыг авдаггүй, үл тоодог хэмээн үзэж байгаагаа илэрхийлж байлаа. Түүнчлэн сум, аймаг, улсын төсөвт орж байгаа усны төлбөр, газар ашигласны төлбөр, байгалийн түгээмэл тархацтай нөөц баялаг ашигласны төлбөр, суманд байршуулсан нөхөн сэргээлтийн сан, кемп ажиллуулах болон бусад төлбөр хураамжаас орж байгаа орлогын хэдэн хувь нь суманд үлддэг, хэдэн хувь нь байгалийг нөхөн сэргээхэд зарцуулагддаг талаар мэдээлэл авах хүсэлтэй байгаагаа малчид илэрхийлж байлаа. Уул уурхайгаас орж байгаа орлогын тодорхой хувийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулахыг санал болгосон билээ.

Цогтцэций сумын байгаль орчны мэргэжилтнүүд уул уурхайн компаниуд зөрчил гаргасан тохиолдолд торгуулийн хэмжээ бага, нөхөн сэргээлтийн стандарт нь говийн нөхцлийг тусгаагүй нь хуулийн дагуу хариуцлага тооцоход хүндрэл учруулж байгааг тэмдэглэж байлаа.

Жишээ 6.12

Энержи ресурс ХХК-ний усны хэрэглээ өндөр. Сард 11 сая төгрөгний усны төлбөр төлдөг. Жилдээ 50 сая орчим төгрөг орон нутгийн төсөвт ордог ч аймаг руу төвлөрүүлдэг. Усны түвшин ерөнхийдөө доошилж байна. Янз бүрийн хүчин зүйл нөлөөлж байгаа. Түүнчлэн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулж байгаа компаниудад авч байгаа торгуулийн арга хэмжээ маш бага байна. 250 мянган төгрөг торгуульд төлчихөөд хогоо хаягдлаа хаясаар байдаг. Элс, хайрга их хэмжээгээр ашигладаг ч үүнд хангалттай хяналт тавьж чаддаггүй. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж байгаа компаниудаас авч байгаа төлбөрийн хэмжээ нь бохирдуулж байгаатай нь харьцуулбал маш бага байдаг. Иргэдээс уул уурхайн цэвэрлэх байгууламж, хог хаягдал, тоос тоосжилтын асуудлаар маш их гомдол ирдэг. Жижиг таван толгой үйл ажиллагаа явуулаад олон жил болж байгаа ч одоог хүртэл шороон замаар явж байна. Энержи ресурсийн тээвэрлэлт хийдэг олон туслан гүйцэтгэх компани тоос тоосжилт их хэмжээгээр гаргадаг ч тус компани А лицензийн талбайгаас гарсан үйл ажиллагаанд манайх хамаагүй гэдэг, уг нь тэдний тээвэрлэлтийг л гүйцэтгэж байгаа компани.

(Ганцаарчилсан ярилцлага, Цогтцэций сум, байгаль орчны улсын байцаагч)

БҮЛЭГ 7 . ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

7.1. Дүгнэлт

ХЭҮК, НҮБХХ-ийн захиалгаар “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас Хүний эрхэд үзүүлж буй нөлөө” судалгааг 2012 оны 5 дугаар сараас 9 дүгээр сард Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэнгийн судлаачид хийж гүйцэтгэлээ. Судалгаанд Өмнөговь аймгийн Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумын сумын төвийн иргэд, орон нутгийн засаг захиргааны байгууллагын төлөөлөл, уул уурхайн компанийн төлөөлөл, уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн Гурвантэс сумын Урт, Тост, Баясах, Ханбогд сумын Жавхлант, Гавилууд, Цагаанхад, Гоёот, Цогтцэций сумын Цагаан-Овоо, Сийрэст багийн малчид нийт 345 зорилтот хүн амыг хамруулав. Судалгаанд нийгмийн судалгааны тоон болон чанарын судалгааны аргыг хэрэглэн мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийв. Судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас Хүний эрхэд үзүүлэх нөлөө” судалгаанд нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа нийт 50 малчин хамрагдсан ба уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд хамгийн их өртөж, эрхэлж буй аж ахуй, амьжиргаа, эрүүл мэнд, сэтгэл зүйгээрээ хор хохирол амсаж байгааг судалгааны дүн харуулж байна. Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөө нь нөлөөллийн бүс дэх малчдын Үндсэн хуулиар баталгаажсан амьд явах, эрүүл аюулгүй орчинд аж төрөх, амьжиргааны хүрэлцээтэй түвшинд аж төрөх, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, газар өмчлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, өв соёлоо хойч үедээ өвлүүлэх, оролцох, мэдээлэл авах зэрэг хүний үндсэн эрх, нийгэм-эдийн засаг, эрүүл мэнд, нийгэм соёлын эрхүүд нь давхар зөрчигдөж байгааг судалгааны дүн харуулж байна. Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд Цогтцэций, Ханбогд сумын малчид илүүтэй өртөж байгаа бөгөөд тэр дундаа нийт нутгийн 50 хувь нь лицензийн талбайд орсон, нийт бэлчээрийн талбайн 80 орчим хувь нь талхлагдалтын шинж төлөвтэй болсон, нутаг дэвсгэрт нь 3 том нүүрсний уурхай, нүүрсний тээвэрлэлт гүйцэтгэдэг 50 гаруй компани ихэвчлэн шороон замаар тээвэрлэлт хийж байгаа Цогтцэций сумын иргэд, малчдын хувьд бэлчээрийн МАА эрхлэх боломж, нөхцөл туйлын хомс болж байна. Судалгаанд хамрагдсан сумын төвийн иргэдийн хариултад үндэслэн дүгнэвэл, уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөгөөр амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх, хөдөлмөрлөх таатай нөхцлөөр хангагдах, газар эзэмших, өмчлөх, амьдрах орчноо чөлөөтэй сонгох, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох, үг хэлэх зэрэг хүний үндсэн болон нийгэм-эдийн засгийн эрхүүд зөрчигдөж байгааг судалгааны дүн харуулж байна.

Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөгөөр Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумын уул уурхайн нөлөөлөлд өртсөн малчид 4 улирлын онцлогтойгоор бэлчээр сэлгэн нүүдэллэдэг уламжлалт бэлчээрийн МАА-гаа эрхлэх аргагүй нөхцөл байдалд тулж ирээд байгааг судалгааны дүн харуулж байна.

- Уул уурхайн компаниудад уугуул иргэд, малчид оршин суугаа нутаг дэвсгэр, малын бэлчээрээ алдах зэргээр халдашгүй байх эрхээ зөрчүүлж байна.
- Уул уурхайн нөлөөгөөр уугуул иргэд, малчид малын бэлчээрээ алдах, бэлчээрээ талхлуулах, бэлчээр ус хуваагдах, нэг талдаа бэлчээртэй болох, хүн малын ус холдох, шавхагдах, хуурайших, усгүйдэх, ус бохирдох, агаарын чанар

доройтох, мал эд хөрөнгийн аюулгүй байдал алдагдсаны улмаас уламжлалт бэлчээрийн МАА-аа эрхлэх боломжоор хомсдож байна. Үүнтэй холбоотойгоор усгүй, бэлчээргүй, малгүй болсон, аргагүй эрхэнд малаа цөөлсөн малчид сумын төв рүү нүүж ажилгүй иргэдийн тоог нэмэгдүүлэх, эсвэл уул уурхайн компаниудад орлого, нэр хүндээр тааруу энгийн хөдөлмөр эрхлэхэд хүрч байна.

- Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр нүүдлийн МАА эрхлэгч малчид бэлчээрээ сэлгэн нүүх боломжийг бараг 10 дахин бууруулж, Монголчуудын уламжлалт соёл алдагдахад хүрсэн буюу соёлын эрхэд нь халдаж байна. Түүнчлэн энэхүү нүүх боломжоор хомсдсоны улмаас малын тоо, малаас авах үр шимийг буурч байгааг судалгаанд хамрагдсан малчид тэмдэглэж байна. Өвс ургамал сийрэг, тачирхан ургадаг говь нутагт суурин МАА, фермерийг хөгжүүлэхэд таатай биш тул ирээдүйд МАА-н салбар үгүй болох эрсдэл бий болсныг анхаарах цаг болжээ. Уул уурхай бол тогтвортой хөгжлийн найдвартай эх сурвалж яав ч биш тул нутгийн иргэдийн эрх ашигт нийцэхүйц бодлогыг боловсруулан, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болсон байна. Засгийн газар, УИХ-ын түвшинд Оюу толгойн гэрээг ярьж байгаа шиг уул уурхайн уламжлалт бэлчээрийн МАА-д үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, уул уурхайгаас уламжлалт бэлчээрийн МАА-гаа хамгаалах бодлого, арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай болжээ.

Уул уурхайн компаниуд тэдгээрийн охин компани, туслан гүйцэтгэх гэрээт компаниуд малчдын хууль ёсны эзэмшилд байгаа өвөлжөө бууцанд дураараа халдах эсвэл өвөлжөө, хаваржаагаа чөлөөлөхийг тулган шаардах, нүүхээс аргагүй нөхцөл байдалд оруулах зэргээр газар эзэмших эрхэнд нь халдаж байна.

- Уул уурхайн сөрөг нөлөөгөөр малчид үе уламжлан нутаглаж ирсэн өвөлжөө бууцаа алдаж, 4 улирлаар нүүх нутаггүй, хүн малгүй тайван амгалан амьдрах аргагүй болсонд уугуул иргэд хамгийн их бухимдалтай бана.
- Малчдын дийлэнхи нь өвөлжөөний газраа “лицензийн талбайд орсон” гэсэн шалтгааны улмаас Үндсэн хууль, бусад холбогдох хуулиар олгогдсон хувийн хэрэгцээнд зориулан үнэ төлбөргүйгээр газар эзэмших эрхээ эдэлж чадахгүйд хүрчээ. Мөн уул уурхайн нөлөөллийн бүсэд багтаж байгаа малчдын тоо нэмэгдсээр байгаа тухай мэдээллийг орон нутгийн удирдлага өгч байсан нь уул уурхай компани бэлчээрийн зориулалттай газар руу улам бүр халдаж байгааг харуулна.
- Түүнчлэн сумын төвийн иргэдийн хувьд ч эзэмшүүлэх, өмчлүүлэх газар хомсдсоны улмаас дээр дурдсан эрхийг эдлэх боломжоор хязгаарлагдмал байна.
- Харин уурхайн дарга нар, орон нутгийн эрх мэдэлтнүүд морины жүчээ, үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар хамгийн тохиромжтой газруудыг хэдэн га-аар нь эзэмшүүлэн өгч байгаагаас иргэдийн газар эзэмших эрх ялгавартайгаар хэрэгжиж, эрх тэгш байх, шударга байх зарчим алдагджээ.

Уул уурхайн үйлдвэрлэл нь амьжиргааны хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн хэрэгжилтэд эерэг, сөргөөр нөлөөлж байна.

- Малын тоо толгой, малчдын тоо жилээс жилд уул уурхайд шахагдан буурч байгаагаас бэлчээрийн МАА эрхлэх боломж хомсдож байна.
- Судалгаа хийгдсэн сумын төвийн иргэдийн амьжиргаанд тодорхой хэмжээгээр эерэгээр нөлөөлсөн бол харин малчдын амьжиргааны түвшинд сайнаар

нөлөөлж чадаагүй гэж үзэх үндэслэл байна. Учир нь гурван малчин тутмын нэг нь өрхийн амьжиргааны түвшнээ тааруухан хэмээн үнэлсэн, мөн судалгаанд хамрагдсан малчдын дийлэнх нь 200 хүрэхгүй орчим бог малтай байна. Түүнчлэн малын арьс, шир, ноос үнэ хүрэхээ байсантай холбоотойгоор үр шим нь буурсан байна.

- Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр бэлчээр талхлагдан, ургамлын гарц муудаж, усны түвшин багасч байгаа нь малын тоо толгой, ашиг шимийн бууралтад дам байдлаар нөлөөлж байна.
- Ханбогд, Цогтцэций суманд өвөлжөө, хаваржаа, зуслангийн бэлчээр нь уурхайн нөлөөлөлд өртсөн орсон зарим малчин өрхийн гишүүдийг Оюу толгой, Энержи ресурс ХХК зам цэвэрлэгч, үйлчилгээний туслах ажилчнаар 300-500 мянган төгрөгөөр цалинжуулж байгаа нь мөнгөн орлогын хувьд өссөн ч, энэхүү орлого нь тогтвортой эх үүсвэр байж чадах эсэх, хэдэн үеэрээ нутаглаж ирсэн газар нутгийг нь авсан, МАА-гаа эрхлэн амьдрах аргагүй болгож байгааг анхаарах ёстой.

Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөгөөр Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумын малчид, орон нутгийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд аж төрөх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх ноцтой зөрчигдөж байна.

- ОТ ХХК-ийн БОННУ, НЭМХ-ээс Ханбогд суманд явуулсан чанарын судалгааны дүн болон сумдын эмнэлгийн статистик үзүүлэлтээр уул уурхайн нөлөөтэй амьсгалын зам, харшил, тоосжилт, ургийн гажиг төрөлт, бэртэл хордлого болон БЗДХ зэрэг халдварт өвчний тоо сүүлийн жилүүдэд тасралтгүй өсч тэргүүлэх 5 өвчлөлийн эхний байранд орж байгааг харуулж байна.
Судалгаанд хамрагдсан Ханбогд, Цогтцэций сумын хүн ам бүхэлдээ тоосон дунд амьдарч байгаа бөгөөд малын уушиг дэлүү, дотор эрхтэн харлах, устах зэрэг шинэ өвчний шинж тэмдэг илэрч байгааг уул уурхайн үйлдвэрлэл, тээвэрлэлтээс үүсч байгаа тоос тоосжилт хүн малын эрүүл мэндэд эрсдэл учруулах хэмжээнд хүрсэнтэй холбогдуулан тайлбарлалаа.
- Тоос тоосжилтын хор хөнөөл хүний эрүүл мэндэд харшил, амьсгалын замын өвчин хэлбэрээр түгээмэл илэрч байгаа ч нарийн ширхэгт тоосонцор хүний уушиг болон бусад эрхтэнд ямар нөлөө үзүүлж байгаа хожмын уршгийн талаар тандалт, мэргэжлийн байгууллагын судалгаа өнөөг хүртэл огт хийгдээгүй байна.
- Өнөөг хүртэл уул уурхайн салбарын үйл ажиллагааны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөлд үнэлгээ хийх эрх зүйн орчин, бодлого, хөтөлбөр, нөлөөллийн үнэлгээ хийх арга зүй, аргачлал байхгүй байгаагаас үзвэл эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтад илүү анхаараад хүн, хүний эрүүл мэндэд төдийлөн анхаарахгүй өөрөөр хэлбэл иргэний Үндсэн хуульд заасан эрхийг хангаж хамгаалахад гол үүрэгтэй төр Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Эрүүл мэндийн тухай хуульд заасан үүргээ бүх шатандаа биелүүлэхгүй байгааг харуулж байна.
- Оюу толгой ХХК-ийн 2012 онд хийсэн судалгаагаар ОТ ХХК-ийн үйл ажиллагааны бүс нутагт тоосонцорын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан судалгааны үр дүн гарсан нь 2012 онд Оюу толгой төслийн агаарын чанарын суурь судалгааны дүнгээр нүүрсний зам дагуу болон уул уурхайн орчим нутагладаг малчид нарийн ширхэгт тоосонцороор амьсгалж, эрүүл мэндийн хувьд эрсдэлт нөхцөл бүрэлдсэнийг хүлээн зөвшөөрснийг харуулж байна.
- Тэрчлэн орон нутгийн засаг захиргааны байгууллага тоосжилтыг хэмжих багаж төхөөрөмжөөр хангах, мэргэжлийн байгууллагатай хамтран сумын тоосжилт

болон хүн амын эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг хэмжих, урьдчилан сэргийлэх зэрэгт хөрөнгө төсөвлөж зарцуулах үүргээ огт биелүүлэхгүй байгаа нь судалгаагаар харагдаж байлаа. Зөвхөн Энержи ресурс компани Цогтцэций сумын төвийн 4 хэсэг газарт агаар хэмждэг бөгөөд үр дүн нь ямар нэгэн сөрөг нөлөөгүй хэмээн гарч байгаа нь анхаарал татаж байгаа юм. Иймд сумын захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллага давхар хэмжилт хийж үр дүнг нь харьцуулах шаардлагатай байгааг харуулж байна. Хамгийн их тоос тоосжилттой нүүрсний зам дагуу амьдарч байгаа малчин өрхийн хавь орчимд хэмжилт хийсэн тохиолдол байхгүй байгаа нь судалгаагаар харагдаж байлаа.

- Уул уурхайн компаниудын ухсан нүх шуудуу, суваг, карьер, хаягдлын далан зэрэгт мал орж үхэх нь ердийн үзэгдэл болсон төдийгүй ихэнх компани нөхөн төлбөр олгох тал дээр хариуцлагагүй хандаж байна. Өөрөөр хэлбэл ухсан нүх шуудуу, далангаа булах, техникийн нөхөн сэргээлт хийх үйл ажиллагаа хангалтгүй хийгдэж байгааг харуулаад зогсохгүй хянах, шалгах чиг үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагаа тааруу байгаатай холбоотой байна.
- Нэг жилийн дотор авто тээврийн осол 2.5 дахин нэмэгдэж, осолдож гэмтэгсдийн тоо мөн тэр хэмжээгээр нэмэгдэж байна. Авто замын осолд нутгийн иргэд, малчид, хүүхэд, мал өртөмхий байна. Энэ нь улмаар амьд явах эрхэд халдаж байгаа хэрэг юм.
- Судалгааны дүнгээс харахад уул уурхайн сөрөг нөлөөгөөр уул уурхайн бүсэд амьдарч байгаа иргэд, малчдын эрүүл мэндэд ноцтой урхагтай сөрөг үр дагавар үзүүлж байгааг төр засаг, тодруулбал Засгийн газар, ЭМЯ, эрдэм шинжилгээний байгууллага анхааралдаа авч уул уурхайн нөлөөгөөр эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл, хор хохирлыг тогтоох, тандах судалгааг зайлшгүй хийх шаардлагатай байна. Ялангуяа тандалтын судалгааг тогтмол давтамжтайгаар хийх нь хамгийн чухал асуудал болж байна.
- Судалгаагаар уул уурхайн компани хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тухайн уул уурхайн орчинд амьдарч байгаа иргэдийн эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлэх вэ, сөрөг нөлөөллийг бууруулахын тулд юу хийх, нөлөөллийг бууруулахад хэр хэмжээний хөрөнгө оруулалт хийх, зэрэг асуудлын талаар мэдээлэл өгч эдгээр асуудлын хүрээнд тэдэнтэй зөвлөлдөж, харилцан тохиролцдог практик огт байхгүй байна. Уул уурхайн компани ажилчдынхаа эрүүл мэндийг хариуцдаг атлаа нутаг орных нь баялгийг аваад дээр нь эрүүл мэндэд нь тооцоолох боломжгүй хор хөнөөл учруулж байгаа ийм нийтлэг дүр төрх сүүлийн 4-5 жилийн туршид ажиглагдаж байгаа ч одоог хүртэл эрүүл мэндийн холбогдох хууль тогтоомжид үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэндэд учруулж буй нөлөөлөлд үнэлгээг хийх тухай заалт байхгүй хэвээр байсаар байна.

Байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн хэрэгжилт

- Судалгаанд оролцогчдын дунд байгаль экологи хэрхэн сүйрч байгаа талаар олон баримтуудыг хэлснээс товчлон дүгнэвэл ус, бэлчээр, ургамал, ан амьтантай байгалийн үзэсгэлэнтэй газар нутагт хайгуул, олборлолт, тээвэрлэлт хийж байгаль орчин, экологи нь дахин сэргэхээргүй өөрчлөгдөж байна гэж үзэх хандлага зонхилж байна.
- Уул уурхайн үйлдвэрлэл, бүтээн байгуулалт, тээвэрлэлт тоос тоосжилт ихсэж, малын бэлчээр талхлагдан, хуурайшилт нэмэгдэхэд нөлөөлж байна.
- Нүүрс олборлодог, тээвэрлэдэг компани, гэрээт компаниудын дунд орон нутгийн зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, түр кемп барих, усны хайгуул хийх, өрөм

тавих, түр зам гаргах, голын хайрга чулуу авах зэргээр түгээмэл тархацтай байгалийн ашигт малтмал ашиглах, карьер шуудуу ухах явдал нийтлэг байгаа ч багийн засаг дарга нар, байгаль орчны байцаагч нарын хувьд хууль бус үйлдэлд хяналт тавих, хариуцлага тооцож чадахгүй хэвээр байна.

- Судалгаанд оролцогч малчид, иргэдийн хувьд Ханбогд, Цогтцэций, Гурван тэс сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын байгаль орчинд нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун бус байна.

Газар эзэмших эрхийн хэрэгжилт болон уламжлалт бэлчээрийн МАА-н ирээдүйн төлөв байдал

- Уул уурхайн сөрөг нөлөөгөөр малчид үе уламжлан нутаглаж ирсэн өвөлжөө бууцаа алдаж, 4 улирлаар нүүх нутаггүй, хүн малгүй тайван амгалан амьдрах аргагүй болсонд хамгийн их бухимдаж байгааг судалгааны дүн харуулж байна. Судалгаанд хамрагдсан малчдын талаас илүү хувь нь уул уурхайн компанид өвөлжөө бууцаа алдаж газар эзэмших эрхээ эдэлж чадахгүйд хүрч байна гэж үзлээ.
- Нийт судалгаанд хамрагдсан 50 малчны 34 нь буюу 62 хувь нь өвөлжөөний газар лицензийн талбайд орсон гэж хариулснаас үзвэл Үндсэн хуулиар олгогдсон газар эзэмших эрх нь хангагдахгүй байгааг илтгэж байна. Малчид, орон нутгийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар нэг л өдөр малчдыг мэдээгүй байхад өвөлжөө бууцанд нь халдах эсхүл газрын зориулалтыг өөрчлөн уул уурхайн үйл ажиллагаа явуулах газарт оруулж 60 жилээр эзэмшсэн газар нь уурхайн мэдэлд орсон байдаг байна. Олон улсын жишигт уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх гэж байгаа компани орон нутгийн иргэдийн зөвшөөрөл, зөвшилцөлгүйгээр хэзээ ч газар нутаг, бэлчээр, ус, худаг усанд нь хүрдэггүй буюу үйл ажиллагаагаа эхлүүлдэггүй байна. Манай улсад энэ сайн туршлагыг цаг алдалгүй нэвтрүүлэх шаардлагатай байна.
- Уул уурхайн нөлөөлийн бүсэд багтаж байгаа малчдын тоо нэмэгдсээр байгаа тухай мэдээллийг орон нутгийн удирдлага, уул уурхайн компани өгч байснаас дүгнэвэл уул уурхайн компани бэлчээрийн зориулалттай газар руу улам бүр халдаж олон малчныг газар эзэмших эрхгүй болгож байгаагийн нотолгоо болж байгааг харуулж байна.
- Судалгаанд хамрагдсан малчид, холбогдох мэргэжилтнүүд, багийн удирдлага нутаг оронд нь уул уурхайн үйлдвэрлэл эрчимжсэнээр сум орон нутаг хөгжих биш харин ус, бэлчээр, агаар, хөрс, ургамал зэрэг байгалийн нөөцүүд дахин сэргэхээргүй хомсдож, МАА-н үйлдвэрлэл шахагдахад хүрээд байгаад туйлын их эмзэглэж байгааг судалгааны дүн харуулж байна.
- МАА-н үйлдвэрлэл уул уурхайд шахагдаж байгаагийн сөрөг үр дагаврыг судалгаанд хамрагдсан малчид, орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүд уул уурхайн нөлөөгөөр уугуул иргэд, малчдын эрх ашиг маш их зөрчигдөж байгаагийн илрэл нь усгүй, бэлчээргүй, малгүй болсон малчид сумын төв рүү нүүж ажилгүй иргэдийн тоог нэмэгдүүлж гэсэн билээ.
- Цогтцэций, Ханбогд суманд орон нутгийн иргэд, малчид үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх зорилгоор газар эзэмших эрхгүй байхад уурхайн дарга нар, орон нутгийн эрх мэдэлтнүүд морины жүчээ, үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар хамгийн тохиромжтой газруудыг хэдэн га-аар нь эзэмшүүлэн өгч байгааг иргэд, багийн засаг дарга нар шүүмжилж байлаа.

Өөрөөр хэлбэл Өмнөговь аймгийн иргэдэд газар эзэмших эрх нь тэгш, шударгаар олгогдохгүй байгааг харуулж байна.

- ДНБ-ний 30 хувь, ажиллах хүчний 30 хувийг шингээдэг ХАА, МАА-н салбар уул уурхайн сөрөг нөлөөллийн улмаас хүнд нөхцөл байдалд тулж ирснийг малчид бүгд хэлж байлаа. Зарим малчид МАА мөхлийн эрмэгт ирлээ гэж хурцаар хэлж байсныг дурьдах нь зүйтэй. Ялангуяа нүүрсний лицензийн талбайд бүхэлдээ шахуу орсон Цогтцэций суманд МАА эрхлэх нөхцөлгүй болсныг бүх оролцогчид тэмдэглэсэн.
- Говь нутаг тэмээ, бог малын бэлчээрлэхэд хамгийн тохиромжтой бөгөөд говийн малчид жилдээ олон удаа отор нүүдэл хийдэг мал маллагааны онцлогтой ард түмэн. Уул уурхайн үйлдвэрлэл эхлэхээс өмнө судалгаанд хамрагдсан малчид жилдээ дунджаар дор хаяж 4 удаа нүүдэллэдэг, хамгийн их нүүдэг малчин өрх жилдээ 14 удаа нүүдэллэж МАА эрхэлдэг байсан бол уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр нийт оролцогчдын 60 хувь нь нүүх нутаг бэлчээргүй болсон, жилдээ 1-2 удаа нүүвэл 4 улирлаар нүүсэнд тооцогдох ийм хэмжээнд хүрснийг судалгааны дүн харуулж байна.
- Судалгааны мэдээлэл цуглуулах үеэр судалгаанд хамрагдсан зарим айлууд зуны дэлгэр цагаар өвөлжөөндөө сууж байгаа дүр зураг нийтлэг ажиглагдаж байсан билээ.
- Нүүдлийн ахуй соёлыг илэрхийлдэг, 4 улирлаар ус, бэлчээрийн соргогийг дагаж нүүдэг нүүдэлч уламжлалтай малчид уул уурхайн нөлөөгөөр хагас суурин маягаар МАА-гаа маллахад хүрч байна. Хэрэв Цогтцэций сумын нутгаар нүүрс тээвэрлэх зорилгоор Төмөр зам орж ирвэл тус суманд хөндөгдөөгүй үлдсэн бэлчээрийн газар сүйтгэгдэж МАА-н ирээдүй бүрхэг болно хэмээн олон хүмүүс үзэж байсныг тэмдэглэж байна.

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговорын зохицуулалтад уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн малчид сэтгэл хангалуун бус байна.

- Судалгааны дүнгээс харахад Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумын малчид автозам, уул уурхайн компаниудын дэд бүтэц, барилгажилтын нөлөөлөлд өртсөн 200 гаруй малчин өрх, төмөр замын нөлөөлөлд өртөж болзошгүй 30 гаруй айл өрхийг уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн гэж үзэж байна. Малчдын өрхийн өвөлжөө бууц, хаваржаа, намаржаа, зуслангийн бэлчээр, худаг ус нь уул уурхайн үйл ажиллагааны нэг болон түүнээс дээш нөлөөлөлд орж, бэлчээрээ алдах, бэлчээр шахагдах, бэлчээр ус хуваагдах, замын хөдөлгөөн, барилгын тоос тоосжилт, дуу чимээний нөлөөлөлд өртөж байгаа нь түгээмэл байна.
- Судалгаанд хамрагдсан малчдын үзэж байгаагаар нөлөөллийн бүс тогтоох, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудлыг шийдэхдээ малчдын саналаар зөвшилцөж бус засаг захиргааны төлөөлөл, уул уурхайн компанийн саналаар асуудлыг шийдсэний дараа эрх ашиг нь хамгийн хөндөгддөг тал болж байгаа малчдаар хэлэлцүүлдэг гэж үзлээ. Ерөнхийдөө уул уурхайн компаниуд энэ асуудлын хүрээнд иргэд, малчдад тулгах байр суурийг баримталж байгаа нь малчид аргагүйн эрхэнд нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговорын гэрээнд гарын үсэг зурахаас өөр аргагүй нөхцөл байдалд хүргэж байгааг малчидтай хийсэн чанарын судалгааны дүн харуулж байна. ОТ ХХК нь бусад уурхайг бодвол нүүлгэн шилжүүлэлтийн олон улсын стандартыг баримтлан анх удаагаа орон нутгийн удирдлагын оролцоотой эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн бодлого хэрэгжүүлэх эхлэлийг тавьсныг Ханбогд сумын удирдлага тэмдэглэж

байлаа. Оюу толгой ХХК-ийн хувьд орон нутгийн ЗДТГ-тай хамтран ажилласан нь сайн туршлага ч малчдын оролцоог орон нутгийн удирдлагыг оролцуулсаны адил түвшинд эхнээс нь оролцуулж зөвшилцөөгүй нь малчид нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговорын арга хэмжээнд сэтгэл ханамжгүй үлдэхэд хүргэжээ.

- Тоон болон чанарын судалгааны дүнгээс харахад, Оюу толгой, Энержи ресурс ХХК-ийн ажилтнууд малчдын оролцоотойгоор нөлөөллийн бүсээ тогтоосон, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговорын хэмжээг зөвшилцлөөр шийдвэрлэж байна гэж үзсэн ч Ханбогд сумын малчид, орон нутгийн удирдлага 20 км-ээр тогтоох хүсэлт гаргасан ч эцэстээ Оюу толгой ХХК нөлөөллийн бүсээ 10 км-ээр, Энержи ресурс ХХК 1 км-ээр нөлөөллийн бүсээ тогтоосныг малчид хүлээн зөвшөөрөхгүй байгаа явдал нь уул уурхайн компаниуд малчид, орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурласан гэж үзэхэд хүндрэлтэй байна.
- Бүлгийн ярилцлагад оролцсон орон нутгийн засаг захиргааны төлөөлөл нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, хохирол барагдуулах нь малчин, компани хоорондын асуудал гэж үзэх хандлага нийтлэг илэрч байсан бөгөөд энэ харилцааг зохицуулсан хууль эрх зүйн орчин байхгүй, хааяа нэг газрын хуулиар зохицуулна гэж үзсэн хэдий ч энэ хуулийг ашиглаж шийдсэн тохиолдол огт байхгүй байлаа.
- Орон нутагт газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговорын талаарх өөрийн гэсэн бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ огт байхгүй байна. Малчин, компаний хоорондын асуудал гэж үзэх хандлага түгээмэл байна.
- Нөлөөллийн бүс тогтоох, нөлөөлөлд өртсөн малчинд учирсан эд хөрөнгийн болон бусад хор хохирлыг үнэлэх аргачлал, үнэлэх стандарт байхгүйгээс шалтгаалан уул уурхайн компаниуд зөвхөн биет нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээгээр хязгаарлаж байна.
- Уул уурхайн компаниуд эхлээд нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосны дараа малчдад санал болгох, тулгах, шахалтад оруулах хэлбэрээр зохицуулж байгаа нь малчидтай хийсэн чанарын судалгааны дүн харуулж байна. Малчдын дунд өвөлжөө хаваржаа, бэлчээр нутаг усаа мөнгөөр хэмжигдэхгүй үнэт зүйл гэж үзэх хандлага нийтлэг ажиглагдсныг тэмдэглэх нь зүйтэй. Судалгаагаар эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговорын хэмжээг тогтоохдоо уул уурхайн компани малчидтай зөвшилцөх замаар гэрээ байгуулж байна гэж үзсэн бол малчдын хувьд хүлээн зөвшөөрч зурсан, тулган шаардаж, шахалтанд оруулж гарын үсэг зурсан гэж нэг хэсэг нь үзсэн байхад өвөлжөө хаваржаа, бэлчээр усгүй юу юу ч үгүй үлдэж байхаар оногдох зүйлээ авъя гэж үзээд зурсан гэх малчид ч судалгааны явцад таарч байлаа.
- Малчид авч буй нөхөн төлбөртөө төдийлөн сэтгэл хангалуун бус байгаагаа бэлчээрийн МАА-гаа эрхэлж чадахгүйд хүрч, өвөлжөө бууцгүй болсонтой холбон тайлбарласан бөгөөд хэзээ нэгэн цагт уурхай хаахад МАА эрхлэхээс өөрөөр амьдрах ур чадварт суралцаагүй малчдын хувьд нөхөн төлбөр нь амьжиргааны тогтвортой эх үүсвэр биш хэмээн үзлээ.
- Уул уурхайн компаниуд нүүлгэн шилжүүлэх ялгаатай хөтөлбөрийг хэрэгжүүлдэг ба Ханбогд сумын Жавхлант, Гавилуут зэрэг багт өвөлжөөний газрын оронд 20 сая хүртэлх төгрөгний нөхөн олговор олгосон бөгөөд ажлын байраар хангах, хүүхдийн сургалтын төлбөр төлөх зэрэг арга хэмжээнүүдийг шийдсэн байна. Харин малчдын хувьд энэхүү нөхөн олговорын хэмжээнд сэтгэл хангалуун бус байна.

Мэдээлэл авах, оролцох эрхийн хэрэгжилт

- Нутгийн иргэд, малчдын уул уурхайн үйл ажиллагааны талаарх мэдээлэл хомс, аливаа шийдвэрийг гаргахдаа ашиг сонирхол нь хөндөгдөж буй бүлгүүдтэй зөвшилцөх, хэлэлцэх явдал хангалтгүй байгаа тул иргэдийн оролцох эрх хэрэгжиж чадахгүй байна.
- Уул уурхайн компаниас орон нутгийн төсөвт орж байгаа татварын орлого, хандив, тусламж, хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл иргэд, малчдын дунд хомс байна. Үүнтэй холбоотойгоор сум, аймаг, улсын төсөвт орж байгаа усны төлбөр, газар ашигласны төлбөр, байгалийн түгээмэл тархацтай нөөц баялаг ашигласны төлбөр, суманд байршуулсан нөхөн сэргээлтийн сан, кемп ажиллуулах болон бусад төлбөр хураамжаас орж байгаа орлогын хэдэн хувь нь суманд үлддэг, хэдэн хувь нь байгалийг нөхөн сэргээхэд зарцуулагддаг талаарх мэдээллийг ил тод болгох хэрэгцээ иргэд, малчдын дунд их байна.
- Мөн Байгаль хамгаалах үйл ажиллагаанд улсын болон орон нутгийн төсвөөр хийгдэх үйл ажиллагаа, мөн уул уурхайн компаниас орж ирж байгаа орлого тодруулбал түгээмэл тархацтай ашигт малтмал, зөвшөөрлийн хураамж, сум хөгжүүлэх сан, нөхөн сэргээлт хийх сангийн хөрөнгө мөнгөний төлөвлөлт, зарцуулалтын мэдээлэл иргэд, малчдад төдийгүй зарим төрийн албан хаагчдад ил тод, нээлттэй бус байна.
- Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход иргэдийн оролцоог хангах явдал туйлын хангалтгүй байна. Учир нь практикт Ашигт малтмалын газраас аль болох иргэдийн оролцоог хумих боломжийг хуулиар олгосон байна.
- Уул уурхайтай холбоотой асуудлаар орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанд иргэдийн дийлэнх нь сэтгэл хангалуун бус байгаа ба хувийн эрх ашгаар компаниудтай хамтарч ажилладаг, эрх нь зөрчигдөж буй малчдын асуудлыг хөндөхдөө хойрго ханддаг хэмээн үзэж байна.
- Уул уурхайн үйл ажиллагааны талаар мэдээлэл хомс, аливаа шийдвэрийг гаргахдаа ашиг сонирхол нь хөндөгдөж буй бүлгүүдтэй зөвшилцөх, хэлэлцэх явдал хангалтгүй байгаа нь иргэдийн оролцох эрх хязгаарлагдмал байгааг харуулж байна. Иргэдийн хүний эрхийн боловсрол хангалтгүйгээс эрх нь зөрчигдөж байгаа эсэх, хэрхэн зөрчигдөж байгааг тогтоох, зөрчигдсэн эрхээ сэргээлгэхээр шүүхээр хамгаалуулж чадахгүй байгаад холбогдох байгууллагууд анхаарах ёстой.
- Малчдын өгсөн хариултаас үзвэл уул уурхайн компаниуд малчин хүний үнэт хөрөнгө болсон өвөлжөө, хаваржааны газар түүн дээрх хонд бууц, хашаа хороо, худаг ус зэрэг малчин хүний эд хөрөнгөд дураараа халдаж өмнөх нөхцөл байдлаас нь дордуулсан үйл ажиллагаа явуулчихаад хариуцлага хүлээхгүй байгаа нөхцөл байдал нийтлэг ажиглагдаж байна.
- Үндсэн хуульд эрх ашиг нь хөндөгдсөн иргэнийхээ хангаж хамгаалах үүргийг төр хүлээнэ гэж заасан байдаг тул бүх шатны төрийн байгууллага энэ үүргээ хэрхэн биелүүлж байгааг сумын жишээн дээр тодруулахад уул уурхайн сөрөг нөлөөллийн улмаас нутгийн иргэдийн эрх зөрчигдсэн тохиолдолд тэдний эрх ашгийг төлөөлөх, хамгаалах арга хэмжээг нутгийн удирдлагын зүгээс огт авч хэрэгжүүлдэггүйг судалгааны дүн илтгэж байна. Өөрөөр хэлбэл иргэдийн Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг хангаж, хэрэгжүүлэх үүрэгтэй төрийн байгууллага хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх үүргээ биелүүлэхгүй байна. Үүнтэй холбоотойгоор нутгийн иргэдийн дунд орон нутгийн

төрийн удирдлагын нэр хүнд ихээхэн доогуур байгаа нь сумын төвийн иргэдийн хариултаас харагдаж байна.

Холбогдох хууль, эрх зүйн актууд, тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй байна.

- Судалгаанд хамрагдсан иргэд, орон нутгийн удирдлага, мэргэжлийн хүмүүс уул уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль экологийн унаган төрх алдагдсан, тоос тоосжилт агаарын чанарын стандарт түвшнээс давсан, усны түвшин эрс багасан, хөрс, ургамлын бүрхэвч, бэлчээр талхлагдсан, нөхөн сэргээлтийг хангалтгүй гэснээс үзвэл холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Үндсэн хууль, байгаль хамгаалах тухай хууль, байгаль хамгаалах багц хууль, эрүүл мэндийн тухай, газрын тухай, ашигт малтмалын тухай хуулиудын хэрэгжилтийг хангах үүрэгтэй аймаг, сумын ИТХ, Засаг дарга нар энэ талаар тодорхой арга хэмжээ авахгүй байна.
- Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэм, хүнд үзүүлэх нөлөөлөлтэй холбогдох хуулийн заалтын биелэлт хангалтгүй байгаа ч байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг дахин шинэчлэн баталжээ. Үүнтэй холбоотойгоор дараах давуу талууд бий болсон байна.
 - o Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар болсон,
 - o Үнэлгээний тухай шинэ хуулийн нэр томъёонд стратеги үнэлгээ, бодлого хөтөлбөр төлөвлөгөө олон нийт зөвлөлдөх байгуулга, аюул ослын үнэлгээ зэрэг ойлголтуудыг шинээр оруулсан нь асуудлыг цогцоор харах боломжийг олгосон,
 - o Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоо хяналт тавих гэдэгт үнэлгээний явцыг олон нийтэд мэдээлэх, үнэлгээний тайланд санал авах, хэрэгжилтэнд хяналт тавих, хянан магадлагаа хийхтэй холбогдсон зохицуулалт ялангуяа орон нутгийн иргэдийн оролцоог ашигт малтмал олборлох боловсруулах төслийг хэрэгжүүлэхэд идэвхжүүлэх мэдээллээр хангах санал авах боломжийг тусгасан нь нөлөөллийн бүс дэх иргэд, малчид оролцох боломжийг зохицуулж өгчээ.
 - o Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудлыг зохицуулах, үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаа болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ юм.
- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас нөлөөллийн бүсэд нутаглаж буй малчин өрхийн газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх маш ихээр зөрчигддөг, гэтэл өнөө хэр газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрыг зохицуулсан хууль байхгүй байсаар байна.
- Ашигт малтмалын тухай хуульд хайгуулын лицензийн тусгай зөвшөөрөл олгохдоо АМГ-аас аймаг сумын засаг даргад ирүүлсэн өргөдлийг ИТХ-аар хэлэлцүүлэн хянуулж тэдний саналыг авахаар хуульчилсан нь иргэд ИТХ-аараа дамжуулан санал бодлоо илэрхийлэх боломжтой болсон ч АМГ нь засаг дарга нараас ирүүлэх саналыг 30 хоногт хүлээн авах бөгөөд хугацаа хэтэрсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл олгохыг зөвшөөрсөнд тооцохоор зохицуулсан байна. Гэвч АМГ-аас ирүүлэх бичгийн хугацааг хуулиар тогтоогоогүйгээс орон нутгийн удирдлага, иргэдийн оролцоог хангах боломжийг боомилсон байна.

- Олон улсын туршлага, шинэчлэгдэн найруулагдаж байгаа байгаль орчны талаарх хууль тогтоомжид иргэдийн оролцоо, иргэдийн саналаар асуудлыг шийднэ гэсэн заалт туссан ч бодит нөхцөл байдалд огт хэрэгждэггүй байна.

Бусад эрхийн зөрчил

- Хөдөлмөрлөх эрх тодорхой хэмжээгээр зөрчигдөж байна гэж үзэх үндэслэл байна. Учир нь нэгд, Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумдын нутаг дэвсгэр дэх уул уурхайн компани орон нутгаас харьцангуй цөөн хүнийг ажлын байраар хангаж байна. Хоёрт, ажлын байраар хангагдсан иргэдийн дийлэнх нь нэр хүнд, цалин хөлсөөр бага энгийн ажил эрхэлж, тэдгээрт ажил мэргэжлийн ур чадвар олгох чиглэлээр төдийлөн үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байна. Гуравт, ажил хөдөлмөр эрхлүүлэхгүй атлаа Ханбогд суманд ажилчин зуучилдаг компани толгой компанитай үгсэн нутгийн иргэдийг сул цалинжуулж байна. Энэ нь иргэдийн дунд бэлэнчлэх сэтгэлгээг улам бүр даамжруулж, бусдаас хамааралтай болгон өөрчилж, хөгжлийн хувьд тогтвортой үр нөлөө авчрахгүй ба иргэдийн ажил хөдөлмөрийн сонголтын хүрээг хязгаарлаж байгаа тул хөдөлмөрлөх эрхийг зөрчиж байна гэж үзэх үндэслэл болох юм. Дөрөвт, гадаад ажилчдын тоог тогтоосон квотоос илүү хэмжээгээр ажиллуулах, нуух зэргээр Монгол улсын хууль, тогтоомжийг зөрчих нь нүүрсний компаниудын хувьд нийтлэг ажиглагддаг байна. Тавд, орон нутгийн иргэдийг мэдлэг чадваргүй байдлыг далимдуулан илүү цагаар, уртасгасан ээлжийн системээр бага цалинтайгаар ажиллуулж хөдөлмөрийн мөлжлөг явуулж байгааг шүүмжилж байлаа.
- Иргэд, малчид, орон нутгийн удирдлага, байгаль орчны улсын байцаагч, эмч зэрэг мэргэжилтнүүдийн баталж байгаагаар уул уурхайн компаниуд ялангуяа 3 суман дахь томоохон компани тэдгээрийн охин компани агаар, байгалийн нөөцөд учруулж буй сөрөг нөлөө, хор хохирлоо арилгах, бууруулах арга хэмжээ авдаггүй, иргэд, малчдын зүгээс гомдол гаргадаг ч шийдвэрлэж өгдөггүй, сум аймгийн ИТХ, Засаг дарга гэх мэт шийдвэр гаргах түвшний хүмүүстэй эрх ашиг нэгдэж ажилладаг, иргэд, малчдыг уул уурхай, байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах, саналыг нь авах, тэдний саналд тулгуурлан асуудлыг шийдэх тал дээр хойрго хандаж байгаа нь нөлөөллийн бүс тогтоосон, нөхөн олговор олгосон, өвөлжөө бууцыг нь уурхайн эзэмшил газарт тулган шаардаж оруулсан зэрэг сэтгэл зовнисон асуудлуудыг хөндөж байна.
- Иргэдийн хүний эрхийн боловсрол хангалтгүйгээс эрх нь зөрчигдөж байгаа эсэх, хэрхэн зөрчигдөж байгааг тогтоож, зөрчигдсэн эрхээ сэргээлгэхээр шүүхээр хамгаалуулж чадахгүй байгаад холбогдох байгууллагууд анхаарах ёстой. Мөн уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх хайгуулын лицензийн зөвшөөрөл олгоход нутгийн иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэнэ гэсэн заалтын талаарх мэдлэг нутгийн иргэдийн дунд хомс байна.

7.2 Зөвлөмж

Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөө, хор хохирол уул уурхайн бүс нутаг, уул уурхайн нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа малчдын Үндсэн хуулиар баталгаажсан амьд явах, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, эрүүл аюулгүй орчинд аж төрөх, эрүүл мэндээ хамгаалуулах, газар өмчлөх, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлэх, мэдээлэл авах, оролцох, өв соёлоо өвлүүлэх эрхэд нь сөргөөр нөлөөлж байгааг судалгааны дүн харуулсан. Иймд судалгааны үр дүн, дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг судалгааны баг дэвшүүлж байна. Үүнд:

Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс нүүдлийн МАА-гаа хамгаалах, малчдын газар эзэмших эрхийг хангах хүрээнд

1. Судалгаагаар иргэдийн хамгийн их хөндөгдөж байгаа эрх нь газар эзэмших, МАА-гаа эрхлэх аргагүй нөхцөл бий болж байгааг судалгаанд оролцогчид тэмдэглэсэн. Иймд төр засгийн бүх түвшинд уламжлалт бэлчээрийн МАА эрхлэх, өвөлжөө бууцаа эзэмших хуулиар олгогдсон халдашгүй эрхээ хэрэгжүүлэхэд нь Үндсэн хуулиар иргэнийхээ эрхийг хангаж хамгаалах үүрэгтэй төрийн бүх шатны байгууллагууд наад зах нь одоо байгаа хууль тогтоомжид заасан эрх үүргээ хэрэгжүүлж ажиллах,
2. Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөгөөр уламжлалт бэлчээрийн МАА эрхлэх аргагүй болсон гэж судалгаанд хамрагдсан малчид, сум багийн зарим удирдлага үзэж байгаа. Иймд төр засгийн түвшинд уул уурхайн салбарын хөгжлийг дэмжсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж байгаагийн нэгэн адил уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс нүүдлийн МАА-гаа хамгаалах бодлого, арга хэмжээг нэн яаралтай хэрэгжүүлж эхлэх,
3. Хууль бусаар малчдын эзэмшил газар халдсан, ухсан, хууль бусаар нөлөөллийн бүс хэмээн тогтоосон, тулгасан хүний эрхийн зөрчлийг арилгах, малчдын хөндөгдсөн эрхийг төлөөлөх, шүүхэд хандах, зөрчигдсэн эрхийг нь нөхөн сэргээх үүргийг төрийн бүх шатны байгууллагууд хүлээх,
4. Цогтцэций, Ханбогд суманд иргэн бүр Үндсэн хуулиар олгогдсон газар эзэмших эрхээ шударгаар, тэнцүү эдлэх эрхтэй бөгөөд газрын зориулалтыг өөрчлөн эрх мэдэлтэй, уул уурхайн эзэд, хөрөнгө чинээтэй хүмүүст өгсөн хууль бус үйлдлийг таслан зогсоох, хууль зөрчсөн хүмүүст хариуцлага тооцох,
5. Мал хувийн өмчид, газар төрийн өмчид байгаа энэ тохиолдолд нийтийн эзэмшлийн газар нутаг руу халдах, ялангуяа нийтээр эзэмшдэг зуслан, намаржаа, хаваржааны бэлчээрийн газар уул уурхайн эзэмшилд хуулийн хүрээнд болон хууль бусаар олгогдож байгаад дүгнэлт хийж, хууль бус зөрчлийг дахин гаргуулахгүй байх,

Уул уурхайн сөрөг нөлөөгөөр өвөлжөө бууц, эд хөрөнгөөрөө хохирсон малчдын нөхөн олговрын асуудлыг хүний эрхэд суурилсан хандлагаар шийдвэрлэх, зохицуулах хүрээнд

6. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээс гадна өмнө байсан амьдралын нөхцөл байдлыг дордуулж байна уу эсвэл сайжруулж байна уу, эзэмшиж байгаа өвөлжөө, тэрхүү эзэмшиж байгаа газартаа өмчилж буй эд хөрөнгөнд нь ямар нөлөө үзүүлэх, хөрөнгө нь хэдээр үнэлэгдэх вэ гэдэг асуудлыг эрх ашиг нь хөндөгдөж байгаа тал буюу малчинтай заавал ярилцаж, зөвшилцөж байж шийдсэний дараа уул уурхайн компанийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна.

7. Уул уурхайн төсөл, барилга, тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь тухайн малчны эзэмшил, өмчлөл дэх эд хөрөнгө, аюулгүй байдлыг дордуулсан үйл ажиллагаа явуулбал зөвшөөрөхгүй байх эрх нь бий. Хэрэв энэ эрхийг нь уул уурхайн компаниуд хангахгүй тохиолдолд Үндсэн хуульд заасанчлан төрийн захиргааны байгууллагууд иргэнийхээ хөндөгдсөн эрхийг хангаж хамгаалах үүргийг хүлээх
8. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээс гадна өмнө байсан амьдралын нөхцөл байдлыг дордуулж байна уу эсвэл сайжруулж байна уу, эзэмшиж байгаа өвөлжөө, тэрхүү эзэмшиж байгаа газартаа өмчилж буй эд хөрөнгөнд нь ямар нөлөө үзүүлэх, хөрөнгө нь хэдээр үнэлэгдэх вэ гэдэг асуудлыг эрх ашиг нь хөндөгдөж байгаа тал буюу малчинтай заавал ярилцаж, зөвшилцөж байж шийдсэний дараа уул уурхайн компанийн үйл ажиллагаа явагдах ёстой. Уул уурхайн төсөл, барилга, тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь тухайн малчны эзэмшил, өмчлөл дэх эд хөрөнгө, аюулгүй байдлыг дордуулсан үйл ажиллагаа явуулбал зөвшөөрөхгүй байх эрх нь бий. Хэрэв энэ эрхийг нь уул уурхайн компаниуд хангахгүй тохиолдолд Үндсэн хуульд заасанчлан төрийн захиргааны байгууллагууд иргэнийхээ хөндөгдсөн эрхийг хангаж хамгаалах үүргийг хүлээх
9. Цаашид уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн малчдын нөхөн олговрын зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ нүүн шилжихэд нь туслалцаа үзүүлэх, нүүн шилжих хүртэл байх нөхцөл байдлыг хангах, амьжиргааг дэмжих зэрэгтэй хамтад нь шийдвэрлэх
10. Уул уурхайн компаниуд нөлөөлөлд өртсөн орон нутгийн малчдад нүүлгэн шилжих үе, нүүн шилжих завсрын үе болон амьжиргааг дэмжих зэрэг нөхөн олговрын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх

Иргэд, малчдын оролцоог хангах, мэдээлэл хангах хүрээнд

11. Сум, аймаг, улсын төсөвт орж байгаа усны төлбөр, газар ашигласны төлбөр, байгалийн түгээмэл тархацтай нөөц баялаг ашигласны төлбөр, суманд байршуулсан нөхөн сэргээлтийн сан, кемп ажиллуулах болон бусад төлбөр хураамжаас орж байгаа орлогын хэдэн хувь нь суманд үлддэг, хэдэн хувь нь байгалийг нөхөн сэргээхэд зарцуулагддаг талаар мэдээлэл авах хүсэлтэй байгаагаа малчид илэрхийлж байгаатай холбогдуулан самбар, сурталчилгааны танхимаар дамжуулан иргэд хүссэн мэдээллээ авах боломжоор хангах,
12. Олборлох салбарын ил тод байдлыг хангах хүрээнд Гурвантэс, Ханбогд, Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудаас орж байгаа орлого, түүний төлөвлөлт, зарцуулалтын мэдээллийг ил тод, нээлттэйгээр мэдээлдэг байх,
13. Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход нутгийн иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэнэ гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд нөлөөллийн бүсийн иргэд малчдын оролцоог хангах, мэдээлэлтэй байлгах, мөн уул уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шат ялангуяа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийхэд иргэдийн оролцоог хангах,

Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах хүрээнд

14. Уул уурхай үйл ажиллагааны хор уршгаар хүний эрүүл мэндийн алдагдлыг тооцож хэн буруутай этгээдээр нь нөхөн төлүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх,
15. Уул уурхайн олон жилийн үйл ажиллагааны сөрөг нөлөө нь хүний эрүүл мэнд, хүний амьжиргаа, болон байгалийн нөөцүүдэд хэр зэрэг нөлөө үзүүлж байгааг

- олон жилийн туршийн хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг хийх, улмаар хохирлыг тооцох, үүн дээрээ үндэслэн хохирлын стандартыг гаргах
16. Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас хүний эрүүл мэнд, малчин хүний амьжиргааны гол хэрэглүүр болсон малын эрүүл мэнд, малын тооны бууралт, ашиг шим, бусад эд хөрөнгийн алдагдалд хариуцлага хүлээх уул уурхайн компани олдохгүй байх нөхцөл байдалтай байна. Уул уурхайн компаниуд бүгд тоос тоожилт бий болгоход нөлөөлж байгаа атлаа бие бие рүүгээ түлхэх хандлага ажиглагдаж байна. Гэтэл иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй төрийн бүх шатны байгууллагуудын хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага, оролцоо туйлын хангалтгүй байгаа нь уул уурхайн сөрөг нөлөөллийн улмаас хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг уул уурхайн компаниуд тооцохгүй байх боломжийг олгож өгч байна. Наад зах нь төрийн байгууллага түүний холбогдох асуудал хариуцсан ажилтнууд хуулиар олгогдсон эрх үүргээ хэрэгжүүлж ажиллах,
 17. Шат шатны эрүүл мэндийн байгууллагууд уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөгөөр иргэдийн эрүүл мэндэд эрсдэл учирч байгааг хүлээн зөвшөөрч, нотлох баримт, нотолгоонд суурилсан судалгаагаар өвчлөлийн цар хүрээ, цаашдын хандлага прогнозыг тогтоох,
 18. Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн үр дагавар, хор хохирол нь уул уурхай үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй харьцуулбал хожуу илэрдэг тул уул уурхайн шууд болон шууд бус нөлөөллийн бүсэд нутаглаж байгаа иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ, орчны нийгмийн нөлөөллийн үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллага нь цаг алдалгүй хийх нь нэн тулгамдсан асуудал болсныг судалгаанд оролцогчдын өгсөн мэдээлэл харуулж байгаа билээ. Иймд ЭМЯ болон холбогдох байгууллага эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх институци байгууллага, мэргэжилтнээ бэлтгэх, эрүүл мэндийн асуудлыг нийгмийн асуудалтай уялдуулах,
 19. Уул уурхайн үйлдвэрлэл явагдаж байгаа сум орон нутагт хүн амын тоо нэмэгдсэн, осол гэмтэл, өвчлөлийн давтамж нэмэгдэж байгааг харгалзан эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, санхүүжилтыг өнөөгийн хүчин чадалд нь тохируулан шийдэх,
 20. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр агаарын бохирдол, хүний эрүүл мэндэд өөрчлөлт гарч байгааг хянах, тандах, оношлох багаж тоног төхөөрөмжөөр хангах,
 21. Цогтцэций, Ханбогд сумын төв болон агаарын бохирдол, тоос тоосжилт ихтэй газар агаарын чанарын үнэлгээ хийх багаж төхөөрөмжийг суурилуулах, үүнтэй холбоотой тандалт судалгааг байнга хийх
 22. Судалгаанд хамрагдсан сумдад тоосжилтын түвшин агаарын чанарын стандарт үзүүлэлтээс давсныг ОТ ХХК-ийн судалгаагаар тогтоосон тул сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээг уул уурхайн компанид хариуцуулах, өөрчлөлтөд мэргэжлийн байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага хяналт тавих,
 23. Сум, аймгийн засаг захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллага уул уурхайн нөлөөгөөр эрүүл мэндээрээ хохирсон иргэд, малчдын судалгааг гаргаж, мэргэжлийн байгууллагатай хамтран эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх, эрүүл мэндийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, гарсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх,
 24. Шороон замаар нүүрс тээвэрлэж зөвшөөрөлгүй зам гаргаж байгаа, байгалийн түгээмэл тархацтай баялаг ашиглаж байгаа гэх мэт компаниудын бүртгэл

- судалгааг гаргаж, үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарлах, энэ ажилд иргэд олон нийтийн оролцоог бий болгох, ТББ-уудтай хамтран ажиллах,
25. Шороон замаар тээвэрлэлт гүйцэтгэж байгаа компани түүний толгой компанитай Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцох, тоос тоожилтын улмаас учруулсан хор хохирлын хэмжээг гаргах, хариуцлага тооцох механизмыг бий болгох
 26. Уул уурхайн нөлөөлөл малын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгааг судалгаанд оролцогчид дурдсан тул мал эмнэлгийн үйлчилгээг идэвхжүүлэх, уушиг дэлүү, дотор эрхтэн нь гэмтсэн, өвчилсөн малыг мэргэжлийн байгууллагаар оношлуулах, судлуулах арга хэмжээг зохион байгуулах

Байгаль орчинд ээлтэй хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх хүрээнд

27. Уул уурхайн компаниуд техникийн болон биологийн нөхөн сэргээлт стандартын дагуу хийж байх, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх,
28. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, хариуцлага тооцох, иргэдийн оролцоотой хяналт үнэлгээ хийдэг байх,
29. Уул уурхайн компаниудын ухсан нүх, суваг шуудуу, карьер, хаягдлын далан зэрэгт мал орж үхэх үзэгдэл ихэссэн тул булах, тэгшлэх арга хэмжээг авахыг шаардах, хяналт тавих,

Уул уурхайн салбарт зохицуулагдаагүй байгаа харилцааг шинэ хууль эсвэл бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар зохицуулах

30. Уул уурхайн нөлөөллийн бүс тогтоох, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговортой холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх,
31. Нийтийн эзэмшлийн газар хувьчлагдаагүй зэрэг Монгол улсын хууль эрх зүйн орчны сул талыг ашиглан иргэний өмчлөх, эзэмших, ашиглах эрхэнд халдах үзэгдэл уул уурхайн хөгжиж байгаа бүс нутагт түгээмэл ажиглагдаж байгаа тул нийтийн эзэмшлийн өмчлөлийн хуулийг боловсруулах, малчдын газар өмчлөх ялангуяа өвөлжөө бууцаа өмчлөх эрх үүргийг баталгаажуулах,
32. Мөн зуслан намаржаа, хаваржаа, оторын хэлбэрээр улирлаас хамааруулан бэлчээр ашигладаг нийтийн эзэмшлийн газар нутгийг нүүдлийн уламжлалыг нь хэвээр хадгалах, бэлчээрийн МАА-гаа үе уламжлан залгуулах, өв соёлоо хойч үедээ үлдээх эрхээ илүүтэй эдлэх нөхцөл бололцоогоор нь хангах,
33. Судалгааны дүнгээс харахад уул уурхайн сөрөг нөлөөгөөр уул уурхайн бүсэд амьдарч байгаа иргэд, малчдын эрүүл мэндэд ноцтой урхагтай сөрөг үр дагавар үзүүлж байгааг төр засаг, тодруулбал Засгийн газар, ЭМЯ, эрдэм шинжилгээний байгууллага анхааралдаа авч уул уурхайн үйл ажиллагааны эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг тогтоох, тандах судалгааг зайлшгүй хийх шаардлагатай байна.
34. Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх нь уул уурхайн сөрөг нөлөө, зохисгүй үйл ажиллагааны улмаас байгаль орчны доройтол, өвөлжөө хаваржааны газрыг талхалж байгаа талаар гомдол санал гаргадаг ч хариуцах эзэн байхгүй, авч байгаа арга хэмжээ байхгүй гэсэн билээ. Иймд нийтийн ашиг сонирхлыг хангах, хамгаалах талаар эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, ялангуяа уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, нийтийн эрх ашиг зөрчигдсэн гомдол, саналыг барагдуулдаг, нийтийн эрх ашгийг төлөөлдөг уул уурхай ба байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах,

35. Уул уурхайн компани, ялангуяа нүүрс олборлодог, тээвэрлэдэг компанийн ажиллагсдын дийлэнх нь Хятад ажилчид эзэлж байгаа гэсэн мэдээллийг иргэд, орон нутгийн зарим төрийн албан хаагчид өгсөн. Иймд Хятад ажилчдын тоо зөвшөөрсөн хэмжээнээс давсан эсэхийг хянах, хэтэрсэн тохиолдолд хуулийн дагуу гадаад ажилчны ажлын байрны төлбөрийг нөхөн төлүүлэх,
36. Зарим уул уурхайн компанийн туслах гэрээт компаниуд Монгол ажилчдыг сул цалинжуулдаг хууль бус үйлдлийг таслан зогсоох, туслан гүйцэтгэх гэрээт компаниуд Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийх,

Хуулийн биелэлтийг хангаж ажиллах үүрэг хүлээсэн субъектүүд болон орон нутгийн захиргааны байгууллага

37. Үндсэн хууль, Байгаль хамгаалах тухай хууль, Байгаль хамгаалах багц хууль, Эрүүл мэндийн тухай, Газрын тухай, Ашигт малтмалын тухай хуулиудын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулаад зогсохгүй хуулийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй аймаг, сумын ИТХ, Засаг дарга нар тодорхой арга хэмжээ авахгүй байгааг илтгэсэн жишээ баримтыг малчид, орон нутгийн төрийн албан хаагчид өгсөн. Иймд хууль биелүүлэх үүрэгтэй орон нутгийн удирдлага, төрийн албан хаагчид хуулийн хүрээнд ёс зүйтэй, авилгал хээл хахуулиас ангид ажиллах, хууль биелүүлж ажиллах,
38. Уул уурхайн компаниуд Монгол улсын хууль тогтоомжийг биелүүлж ажиллах, хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд бүх шатны төрийн байгууллага хуулиар олгогдсон эрх үүргээ хэрэгжүүлж ажиллах,

Уул уурхайн салбарт хөдөлмөр эрхээ хэрэгжүүлэх хүрээнд

39. Орон нутгийн иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжилт сургалт, ур чадвар олгох сургалтуудад хамруулах замаар уул уурхайд өөрийн мэдлэг чадвар, хүсэл сонирхолд нийцсэн ажил эрхлэх боломжоор хангах, үүнд нь орон нутгийн захиргааны байгууллага дэмжлэг үзүүлж ажиллах,
40. Цаашид уул уурхайн салбарт орон нутгийн иргэдийг ажиллуулахад анхаарал хандуулах шаардлагатай зорилтот үйл ажиллагааны нэг нь уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч буй малчин өрхийн гишүүдийн мэргэжил, боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа болох нь ажиглагдаж байна.



Ном зүй

1. Үндсэн хууль
2. Ашигт малтмалын тухай хууль
3. Байгаль хамгаалах тухай хууль
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
5. Эрүүл мэндийн тухай хууль
6. Агаарын тухай хууль
7. Газрын тухай хууль
8. Төрийн хяналт шалгалтын тухай хууль
9. Газар албадан чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн баримт бичиг, АХБ-ны Нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлж, ашиглах төсөл, 2012
10. Бүрэн эрхэт төлөөлөгчийн жилийн тайлан, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, 2011
11. Уул уурхайн зарим салбарт хөдөлмөрийн хүрээний суурь зарчмууд болон Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжинд заасан эрхийн хэрэгжилтэд хийсэн шалгалт судалгааны тайлан 2003, ХЭҮК.
12. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, ХЭҮК 2007
13. Уул уурхай, барилгын салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, 2011 НХХЯ, ОУХБ, БНСУ-ын Засгийн газрын түншлэлийн байгууллага
14. Б.Алтанцэцэг. Уул уурхай ба тогтвортой хүний хөгжил, 2010
15. Ч.Энхзаяа. Албан бус уул уурхай ба хүний хөгжил, 2010
16. Оюу толгой төслийн эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ: Орон нутгийн судалгаа, 2010, Хөх тэнгэр Хөгжил консорциум
17. Алтны уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн байдал, 2002, МУИС
18. Хувиараа алт олборлогчдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын байдал, 2002 Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн
19. Ухаа худаг төсөл-Байгаль орчин болон нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ
20. МАК, Цагаан суварга-БОНБНҮ-ний тайлан
21. БОННБҮ, ОТ ХХК, 2012
22. Монгол орны уул уурхайн салбараас байгаль орчин болон нийгмийн салбарт үзүүлж буй үр нөлөө, 2006, Дэлхийн банк.
23. Paul Burke (2002) How can judges calculate Native title compensation